



# ДЭЛХИЙН ИРГЭНИЙ БОЛОВСРОЛ

Бодлогын нөлөөллийн баримт бичиг

Улаанбаатар хот  
2025 он







# ДЭЛХИЙН ИРГЭНИЙ БОЛОВСРОЛ

*Бодлогын нөлөөллийн баримт бичиг*

Улаанбаатар хот  
2025 он

# ДЭЛХИЙН ИРГЭНИЙ БОЛОВСРОЛ

*Бодлогын нөлөөллийн баримт бичиг*

Эмхэтгэсэн Я.Мөнхчимэг

Орчуулагч Т.Бэхцэцэг, Б.Болорсайхан

Хянасан Д.Тунгалаг

Боловсролын төлөө чанга дуугарцгаая! төслийн санхүүжилтээр хэвлэв.

## АГУУЛГА

УДИРТГАЛ .....	5
ДЭЛХИЙН ИРГЭНИЙ БОЛОВСРОЛЫН ГОЛ ОЙЛГОЛТУУД .....	6
<b>БҮЛЭГ 1. ДЭЛХИЙН ИРГЭНИЙ БОЛОВСРОЛ: АЛСЫН ХАРАА, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ .....</b>	<b>7</b>
1.1 УРЬДАЧ НӨХЦӨЛ .....	8
1.2 ДЭЛХИЙН ИРГЭНИЙ БОЛОВСРОЛ ГЭЖ ЮУ ВЭ? .....	11
<b>БҮЛЭГ 2. МОНГОЛ ДАХЬ ДЭЛХИЙН ИРГЭНИЙ БОЛОВСРОЛЫН ӨНӨӨГИЙН ТОЙМ МЭДЭЭЛЭЛ....</b>	<b>19</b>
<b>БҮЛЭГ 3. ДЭЛХИЙН ИРГЭНИЙ БОЛОВСРОЛ: БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭЛТ, САЙН ТУРШЛАГУУД .....</b>	<b>31</b>
3.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТЭРГҮҮЛЭХ ТАЛБАР 1: БОДЛОГЫН ШИНЖИЛГЭЭ, БОЛОВСРУУЛАЛТ	32
3.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТЭРГҮҮЛЭХ ТАЛБАР 2: СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, БОЛОВСРУУЛАХ .....	35
3.3 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТЭРГҮҮЛЭХ ТАЛБАР: ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ.....	39
3.4 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТЭРГҮҮЛЭХ ТАЛБАР 4: МЭДЛЭГ БҮТЭЭХ, ХУВААЛЦАХ, ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭХ НЬ.....	44
3.5 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТЭРГҮҮЛЭХ ТАЛБАР 5: ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ.....	46
<b>БҮЛЭГ 4. СУРГУУЛЬ БҮХЭЛДЭЭ ДЭЛХИЙН ИРГЭНИЙ ХАНДЛАГА, АРГА ЗҮЙ СОЁЛЫГ ТӨЛӨШҮҮЛЭХ НЬ .....</b>	<b>51</b>
4.1 МОНГОЛ УЛСЫН САЙН ТУРШЛАГА.....	53
<b>БҮЛЭГ 5. ДЭЛХИЙН ИРГЭНИЙ БОЛОВСРОЛ ХӨТӨЛБӨР .....</b>	<b>57</b>
5.1 ДЭЛХИЙН ИРГЭНИЙ БОЛОВСРОЛ: МЭДЛЭГ, ОЙЛГОЛТ .....	58
5.2 ДЭЛХИЙН ИРГЭНИЙ БОЛОВСРОЛ: УР ЧАДВАР .....	61
5.3 ДЭЛХИЙН ИРГЭНИЙ БОЛОВСРОЛ: ҮНЭТ ЗҮЙЛС, ХАНДЛАГА .....	63
<b>ХАВСРАЛТ .....</b>	<b>65</b>
<b>ХАВСРАЛТ 1</b> ЭНХТАЙВАН, ХҮНИЙ ЭРХ, ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ ЮНЕСКОГИЙН ЗӨВЛӨМЖ (тайлбар).....	66
<b>ХАВСРАЛТ 2</b> ДЭЛХИЙН ИРГЭНИЙ БОЛОВСРОЛЫН ЦАГААН ТОЛГОЙ .....	73
<b>“БҮХ НИЙТ БОЛОВСРОЛЫН ТӨЛӨӨ!” ИРГЭНИЙ НИЙГМИЙН ҮНДЭСНИЙ ЭВСЛИЙН ТУНХАГ .....</b>	<b>80</b>



## УДИРТГАЛ

Тогтвортой хөгжлийн зорилго 2030 (ТХЗ)-ыг баталснаар дэлхийн улс орнууд хөгжлийн зорилгыг амбицтай тодорхойлж, хувирган өөрчлөгч бүх нийтийн боловсролыг бий болгох үүрэг хүлээж, амлалт авсан. 2015 онд ТХЗ 4 “Хэнийг ч ардаа үл үлдээх чанартай боловсрол” зорилго нь боловсролын шинэ эрин үеийг эхлүүлсэн гэхэд болно. “Боловсрол 2030” Инчоны тунхаглалыг баталснаар бүх нийтийн, цогц, хувирган өөрчлөх алсын харааг тодорхойлж, нийт 7 зорилт, 3 арга замаар хүрэх замын зургаа тодорхой болгосон. “Боловсрол 2030” нь тэгш хамруулсан чанартай боловсрол хийгээд насан туршийн суралцахуйд онцгой ач холбогдол өгч, боловсролыг дэлхий нийтийн хөгжлийн томоохон хурдасгуур юм хэмээн хүлээн зөвшөөрсөн. Тогтвортой хөгжлийн зорилгуудын хэрэгжилтийн явц зөрчил мөргөлдөөнтэй, цар тахалтай сүүлийн жилүүдэд байрандаа зогссон, зарим талаар ухарснаас Засгийн Газрууд амлалтдаа хүрч чадахгүйд хүрлээ. Дэлхий нийтээр тархсан Ковид 19 цар тахал, улс орнуудын улс төрийн дэглэмийн өөрчлөлт, ардчилсан тогтолцооны хямрал, хүний эрхийн зөрчлүүд, дайн болон уур амьсгалын өөрчлөлт нь өнгөрсөн үеийн авчирсан хамтын хичээл зүтгэл, ахиц дэвшлүүдийг ухрааж, ардчилалд элэгдэл, хамтын үнэт зүйлд үл итгэлцэл бий болголоо.

Маргинал, орхигдож гадуурхагдсан бүлгийн хүүхэд, залуус, насанд хүрэгчид боловсролын тогтолцооны гадна хэвээр, боловсролд хамрагдсан хэдий ч амжилттай суралцаж чадахгүй суралцахуйн хоцрогдолд орж байна. Ядуурал, жендэрийн тэгш бус байдал, хүнд ээлтэй бус хот төлөвлөлт зэрэг олон тогтолцооны хүчин зүйлүүд хүүхэд, залуусын сурч боловсрох эрхэд саад болсон хэвээр байна. 2021 онд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын санаачилгаар Хувирган өөрчлөх боловсрол, “Ирээдүйгээ хамтдаа төсөөлөхүй: Боловсролын нийгмийн шинэ гэрээ” үзэл санаа, бодлогын баримт бичиг, судалгаануудыг гаргаж, Засгийн Газрууд дахин амлалт авч, ТХЗ 4: Чанартай боловсролын зорилго нь бусад зорилгуудаа хурдасгах хүч болох зайлшгүй шаардлага үүссэн.

Өнөөдрийн боловсрол шударга, эрх тэгш, энх тайвнаар зэрэгцэн орших, тогтвортой хөгжлийг хангах зорилгоо хэрэгжүүлж чадахгүйд хүрч байна. Бид хөгжил дэвшлийн төлөө тэмүүлэх явцдаа эх дэлхий, байгаль орчноо сүйтгэж, энэ нь бид бүхний амьд үлдэх эсэх асуудалд заналхийлж эхэллээ. Амьжиргааны түвшин өсөх, шинэ технологи нэвтрэх тутам нийгмийн тэгш бус байдал улам гүнзгийрч, ардчилал, нийгмийн нэгдэл нягтралыг хангаж чадахгүйд хүрч байна. Гэлээ ч бид ирээдүйгээ ардчилсан, илүү эрх тэгш байдлаар байдлаар төсөөлөх хэрэгтэй нь маргаангүй билээ. Бидний хүсэж буй энх амгалан, шударга, хүний эрхийг дээдэлсэн, хүмүүсийн болон соёлын олон янз байдлыг хүлээн зөвшөөрдөг ирээдүйг хувь хүний болон хамтын үйл ажиллагааны үр дүнд бодит болгох боломжтой. Хүн төрөлхтөн ганцхан дэлхийтэй. Гэтэл дэлхийн улс орнууд төсөөлснөөс ч бэрх тэгш бус байдлын дөнгөнд байсаар байна. Жендэрийн тэгш бус байдлыг бууруулж, охид эмэгтэйчүүдийг эрхмэдэлжүүлж, хүүхдийн хөдөлмөр, хүсээгүй жирэмслэлт, өвчлөлөөс урьдчилан сэргийлж чадахгүй байна. Технологи биднийг өөр хооронд маань холбох боломж гэж үзэж байгаа ч дижитал хуваагдал байсаар байна. Хүмүүсийн мэдлэг олж авах, бүтээх чадамжинд эрх мэдлийн эрх тэгш бус байдал оршсоор байна. Гэхдээ **боловсрол л өнөөг хүртэл амь бөхтэй оршсоор байгаа тэгш бус байдлыг арилгах гол арга зам гэдгийг мартаж учиргүй.**

# ДЭЛХИЙН ИРГЭНИЙ БОЛОВСРОЛЫН ГОЛ ОЙЛГОЛТУУД<sup>1</sup>

## Олон улсын болон орон нутгийн шинжтэй асуудлууд, тэдгээрийн уялдаа холбоо, засаглалын тогтолцоо, бүтэц\ үндсэн ойлголт ба засаглалын эрх мэдэл

- Иргэншил, ажил эрхлэлт, даяарчлал, цагаачлал, харилцан холбоотой байдал, харилцан хамаарал, шилжилт хөдөлгөөн, улс төрийн нөхцөл байдал, хойд ба өмнөдийн харилцаа, дижитал хуваагдал
- Шударга шүүхээр шүүлгэх, шийдвэр гаргалт, ардчиллын үйл явц, сайн засаглал, аюулгүй хүнс, үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөө, хэвлэлийн эрх чөлөө, жендэрийн эрх тэгш байдал, хүмүүнлэгийн хууль, энх тайван, энх тайвныг цогцлоох, нийгмийн сайн, хүний эрх (хүүхдийн эрх, соёлын эрх, бүлгийн эрх, сурч боловсрох эрх, эмэгтэйчүүдийн хүний эрх), хариуцлага, дүрэм журам, хууль ёс, ил тод байдал, сайн сайхан байдал (хувь хүний, хамт олны)
- Гэмт хэрэг, орогнол хүсэгчид, хүүхдийн хөдөлмөр, цэрэгжилт, цагдан хяналт, геноцид<sup>2</sup>, апартейд<sup>3</sup>, ядуурал, тэгш бус байдал, үл хүлцэн тэвчихүй, арьсны үзэл, дүрвэгсэд, цөмийн зэвсэг, эрчим хүч, хүйсээр ялгаварлан гадуурхалт, хомофобиа<sup>4</sup>, терроризм, ажилгүйдэл, хүчирхийлэл, дайн
- Иргэний нийгэм, хамтын нийгэмлэгийн хариуцлага, үндэстэн дамнасан корпораци, хувийн хэвшил, төр шашин тусдаа байх, болон оролцогч талууд, төрийн үүрэг хариуцлага, залуус
- Биологийн төрөл зүйл, цаг уурын өөрчлөлт, уур амьсгалын өөрчлөлт, гамшгийн эрсдлийг бууруулах, онцгой байдал (онц байдал), хүрээлэн буй орчин, байгалийн гамшиг, усны чанар, тогтвортой хөгжил
- Газарзүй, түүх, колончлолын өв, хэвлэл мэдээллийн мэдээллийн боловсрол, олон нийтийн сүлжээ,

## Амин чанар (айдентити) харилцааг хөгжүүлэх, удирдах, ялгаатай байдлыг хүндэтгэх

- Олон нийт, улс орон, нутгаасаа гарсан хүмүүс, цөөнх хүн ам, гэр бүл, уугуул хүн ам, цөөнх, хөрш, сургууль, хувь хүн ба бусад, дэлхий ертөнц
- Хандлага, зан үйл, итгэл үнэмшил, шашин, соёл, соёлын ялгаатай байдал, ялгаатай байдал, жендэр, амин чанар, соёл хоорондын яриа, хэл (хос хэл, олон хэл), хүйс, бэлгийн чиг баримжаа, үнэт зүйл
- Халамж, энэрэх сэтгэл, анхаарал, нинжин сэтгэл, шударга байдал, үнэнч байдал, эелдэг зан, хайр, хүндлэл, эв нэгдэл, хүлцэн тэвчихүй, ойлголцол, нэг ертөнцийн иргэн гэх үзэл,
- Итгэлтэй байдал, харилцаа, зөрчлийг шийдвэрлэх, харилцан яриа, соёл хоорондын яриа хэлэлцээр, амьдрах чадвар, ялгаатай байдлыг зохицуулах чадвар, эвлэрүүлэх, хэлэлцээр хийх, түншлэх чадвар (олон улсын болон орон нутгийн), урьдчилан сэргийлэх (мөргөлдөөн, дарамт, хүчирхийлэл), харилцаа, эвлэрэл, харилцан ашигтай шийдэл
- Амьтанд харгис хэрцгий хандах, үе тэнгийн дээрэлхэлт, ялгаварлан гадуурхах, арьс өнгөний үзэл, хүчирхийлэл, жендэрт суурилсан хүчирхийлэл, сургуультай холбоотой жендэрт суурилсан хүчирхийлэл

## Оролцоо, үйлдэл, ёсзүйн хариуцлага

- Хэрэгцээний зуршил, компанийн нийгмийн хариуцлага, ёс зүйн асуудлууд, ёс зүйн хариуцлага, шударга худалдаа, хүмүүнлэгийн үйлс, нийгмийн шударга байдал
- Хувиараа аж ахуй эрхлэх, санхүүгийн ур чадвар, инновац

1 Дэлхийн иргэний боловсрол: сэдвүүд ба суралцахуйн зорилтууд, ЮНЕСКО, 2015 он

2 Геноцид – НҮБ-аас аль нэг үндэстнийг, угсаатныг, арьсны өнгө болон шашны бүлгийг бүхэлд нь буюу хэсэгчлэн устгах зорилготой олон нийтийг хамарсан хүчирхийллийн хэлбэр хэмээн тодорхойлсон.

3 Апартейд – Апартейд нь Өмнөд Африкт явуулж байгаа нэг арьс үндсийн бүлэг хүний зүгээс нөгөө арьс үндсийн бүлэг хүнийг ноёрхолдоо тогтоон барьж байх, тэднийг системчлэн дарлах зорилго бүхий арьс өнгөөр ялган тусгаарлах, алагчлах хуульчилсан тогтолцоог хэлнэ.

4 Хомофобиа - Ижил хүйстэн эсвэл бэлгийн чиг баримжааны олон талт байдлаас айх, үл тэвчих, үзэн ядах үзэл



## БҮЛЭГ 1.

**ДЭЛХИЙН ИРГЭНИЙ БОЛОВСРОЛ:  
АЛСЫН ХАРАА, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

## БҮЛЭГ 1.

# ДЭЛХИЙН ИРГЭНИЙ БОЛОВСРОЛ: АЛСЫН ХАРАА, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

БОЛОВСРОЛ бол энх тайван, хүлцэл тэвчил, хүний эрх ба тогтвортой хөгжлийн суурь.

### 1.1 УРЬДАЧ НӨХЦӨЛ

**Яагаад ирээдүйн боловсролыг өөрөөр төсөөлөх шаардлагатай вэ? Өөрчлөгдөн буй дэлхий ертөнцөд боловсролын гүйцэтгэх үүрэг юу вэ?**

**Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөөс** үүдэн гарч буй санаачлагууд (нүүрсхүчлийн хийн агууламжийг бууруулах, ногоон эдийн засаг – залуу үеийн санаачлагууд) зэрэгт одоогийн боловсролын тогтолцоо хувь хүмүүс болон нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн чанар, хүртээмж, эрх тэгш байдлыг хангаж чадахгүй байгааг дурдаж байна. Цаг агаарын эрс тэс үзэгдэл, үүнтэй холбоотой байгалийн гамшигт үзэгдэл эрчимжиж, боловсролын хүртээмжид саад учруулж байна. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн дүрвэлт, нүүлгэн шилжүүлэлтийн үр дүнд багш нарын хомсдол үүсэх нь бодитой байна. Агаарын температурын өсөлт боловсролд эрсдэл учруулдаг. Хэт халуун нь суралцахуйд, танин мэдэхүүд сөргөөр нөлөөлдөг бөгөөд сургууль, орон байрны температурыг бууруулж, уур амьсгалыг хянахад тохиромжтой материал, архитектурын шийдэл технологи одоогоор алга. Уур амьсгалын өөрчлөлт нь нэн ядуу, гадуурхагдсан, амь зуулга нь хөдөө аж ахуй, мал аж ахуйгаас хамааралтай хүмүүсийн дунд жендэрийн тэгш бус байдлыг нэмэгдүүлж байна. Мөн энэ нь эрэгтэйчүүдийн гадагш чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг нэмэгдүүлж, эмэгтэйчүүд дээр ирэх ахуйн ачааллыг нэмдэг. Сурагчдад уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сааруулах нөөц чадваруудыг хөгжүүлэхэд туслах шинэчилсэн, илүү үр дүнтэй арга барил хэрэгтэй байна.

**Ардчилсан засаглалаас популист хандлагад шилжиж буй байдал** - шударга бус, тэгш бус байдлын эсрэг иргэний идэвхтэй хөдөлгөөн, шүүмжлэлт сэтгэлгээ, инноваци, хувь хүний болон хамтын үнэт зүйл, зорилгыг хэрэгжүүлэхэд хүний эрхийг дээдэлсэн, утга учиртай оролцоотой, ардчилсан нийгэм хамгаас чухал. Гэвч сүүлийн 10 жил ардчилал мэдэгдэхүйц ухралтад орж, айдентити (амин чанар)-д суурилсан үндсэрхэг, популист үзэл хандлага өсөж байна. Үүнийг зөрчил мөргөлдөөн, эдийн засгийн хямрал, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн дүрвэлт, нүүлгэн шилжүүлэлт гал дээр тос мэт нэмлээ. Иргэдийн эв нэгдлийг таслах, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд халдаж буй зөрчил нь иргэний оролцоонд суурилсан боловсролд ихээхэн хор уршигтай. Дэлхий хуваагдан туйлширч, олон тооны ардчилсан инстүүцүүд бүслэгдсэн нөхцөл байдал үүслээ. Ардчилал амлалтаа биелүүлээгүй гэх үзэлтэй хүмүүс болон ардчилал аль хэдийнэ хэрээс хэтэрсэн хэмээн үзэж буй хүмүүсийн хоорондын зөрчил дунд бид байна. Айдас, ухвар мөчид үзэл, өрөөсгөл хандлага, ялгаварлан гадуурхалтыг ашигладаг авторитар засгийн газрууд иргэний, нийгмийн, хүний, байгаль орчны эрхийг хязгаарлаж, шахан үгүйсгэж байна. Монголд ч нийгэм, улс төрийн хувьд ийм байдал ажиглагдаж байна. Ядуурал, тэгш бус байдал ихэсч, боловсрол уг нөхцөлөөс гарахад туслахгүй, чадамжгүй байгаа нь боловсрол хүний болон нийгмийн хэрэгцээг хангахгүй байгаагийн илрэл. Монголд дөрвөн удаа хийгдсэн Азийн улс орнуудын хөгжил,

ардчилал, засаглалыг харьцуулсан Азийн барометр судалгаанд Монголчуудын төрд итгэх итгэл, тэр дундаа улс төрийн намд итгэх итгэл хамгийн бага түвшинд хүрсэн байна. Энэ нь инстүүцүүдэд үл итгэх хандлагын нэг илрэл бөгөөд манай улсад улс төрийн нам онолын, жинхэнэ хэв загварт орж төлөвшиж, зохион байгуулалтад орж чадаагүйтэй холбоотой. Улс төрд намаар дамжиж иргэд төлөөллөө хэрэгжүүлдэг. Намаар дамжиж эрх мэдэл, баялагийг хуваарилдаг. Нам дотоод ардчилалгүй байгаа нь өнөөдрийн улс төрийн бодит дүр зураг. Сайн муу, сайхан муухайгаа агуулж байдаг либерал ардчиллын онолоор ардчилал өө сэвээ засаад явах учиртай гэж үздэг учир энэ бүхэн бидэнд ил тод байна. Иргэний хөдөлгөөнүүдийн олон талт идэвхжил нэмэгдэж, эсэргүүцлийн хөдөлгөөнүүд оролцоонд суурилсан ардчилсан улс төрийг уян хатан байлгах шинэ ирээдүй рүү чиглүүлж байна. Эдгээр хөдөлгөөнүүд ихэвчлэн залуусаар удирдуулсан экологийн хөдөлгөөнөөс эхлээд цөөнхийн эрхийг хамгаалдаг иргэдийн тэмцэл хүртэл өргөн хүрээнд байна. Жишээлбэл, Грета Турнберг, Малала, #metoo зэрэг дээр нэмэгдээд сургалтын хөтөлбөрийг колончлолын бодлогоос ангигруулахад чиглэсэн хөдөлгөөнүүд ч багтана. Боловсрол нь бат бөх ардчилсан тогтолцоо, иргэдийн идэвх оролцоот төлөвшил бүхий Төр, Иргэний нийгэм ба Хувийн хэвшил гэсэн нийгмийн 3 тал зөвлөлдөх орон зай, утга учиртай оролцооны үйл явц, эв найртайгаар хоршин ажиллах практик туршлага. Мөн иргэдийн оролцоо, олон улсын харилцаа болон хамтын ирээдүйг хөхиүлэн дэмжих, баталгаажуулах үүрэгтэй.

**Технологийн шилжилтийн төсөөлшгүй их боломжууд**- Дижитал технологи, хэрэгсэл, платформ хүний эрхийг дэмжих, хүний нөөц чадварыг нэмэгдүүлэх, энх тайван, шударга ёс, тогтвортой байдал руу тэмүүлэх хамтын үйл ажиллагааг хөнгөвчлөх чиглэлд эргүүлж болно. Дижитал бичиг үсэг, болон хүртээмж бол XXI зууны үндсэн эрх гэдэг нь илэрхий бөгөөд эдгээр эрхийг эдлэхгүйгээр иргэний болон эдийн засгийн харилцаанд оролцоход улам хэцүү болж байна. Дижитал хуваагдлын үр дүнд улс орон хооронд, улс дотроо боловсролын боломж, дам үр дүнгийн зөрүү нэмэгдэж байна. Дэлхийг илүү тэгш хамруулсан, тогтвортой байлгахын тулд хүмүүний нөөц чадварыг дээшлүүлэхэд технологийг зориуд, идэвхтэй ашиглах шаардлагатай байна. Дижиталчлал, дижитал технологи 2 угаас зөрчилтэй. Дижитал технологийн зарим шинж чанарууд нь мэдлэг, мэдээлэл солилцоход тусалдаг шиг тодорхой хэдэн шинж чанарууд нь мэдлэгийн олон янз байдал, соёлын тэгш хамруулсан оролцоот байдал, ил тод байдал, оюуны эрх чөлөөнд ихээхэн аюул учруулж болзошгүй юм. Дижиталчлал, технологийн хөгжил, түүний амжилт, ялалт аюул занал учруулж буй мэдлэгийн хамгийн үнэ цэнтэй хэлбэрүүдийн нэг нь нийгэм билээ. Хуваалцах, холбогдох, харилцах суурь хэмээж буй ч ашиг олоход тулгуурласан ихэнх дижитал мэдлэг нь хэрэглэгч, худалдан авагч, эсвэл ажиглагч гэсэн хувь хүмүүсийн тусгаарлалтад тулгуурладаг бөгөөд ганцаардал, хувиа хичээсэн байдал, нарциссизмыг хөгжүүлдэг. Дижитал мэдлэг, төхөөрөмж, платформ, мөн мэдээлэл нэвтрүүлэх чадавх нь улс орнуудын хооронд болон улс орон дотроо маш тэгш бус тархсан байдаг тул мэдлэгийн эртний, хоцрогдсон гэх, богино настай, дахин давтагдашгүй хэлбэрийг үнэлж, түүнд итгэж найдаж буй хүмүүсийг үл тоомсорлодог. Жишээлбэл, дижитал хуваагдал нь өөрийн хүрээнээс гадуур ажилладаг хүнийг, уг хүрээний анализ, техникээс зайлсхийдэг хүнийг гадуурхдаг. Тиймээс энэ нь хүний эрхэд суурилсан, тэгш хүртээмжтэй зүйл биш.

**Аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгал, автоматчилалын нөлөө** – Ажлын байрны хувьсал болон хүн төвтэй ажил хөдөлмөрийн ирээдүйн чиг хандлага. Ажиллах хүчний оролцооны түвшин 1990 оноос хойш дэлхийн бүх бүс нутагт буурсан. Ирээдүйн боловсрол нь зөвхөн хүүхэд, залууст чиглэхгүй. Бүх насныхан гэмтэж, сүйдэж буй дэлхий хэмээх гараг дээр хамтдаа амьдарч сурахаас өөр аргагүй болно. Боловсрол нь хүмүүст урт хугацаанд үргэлжлэх нийгэм, эдийн засгийн сайн сайхан аж байдлыг өөртөө, гэр бүл, нийгэмдээ бий болгоход чиглэгдэх ёстой. Харамсалтай нь жендэрийн шударга бус байдлаас үүдэлтэйгээр боловсролд хамрагдалтын өсөлт эмэгтэйчүүдийн оролцоонд нөлөөлдөг хэдий ч амьжиргааны түвшин дээшлэх тусам эмэгтэйчүүд хөдөлмөрийн зах зээлээс сайн дураараа явж байдаг. Гэхдээ ихэнх судалгаанууд эмэгтэйчүүдийн ажлын байрны чанар муу байгаатай холбоотой гэж үздэг. Албан ёсоор “ажил” гэж тооцогддог, “бүтээмж” гэж хэмжигддэг зүйл нь асар чухал хөдөлмөрийг үнэгүйдүүлдэг. Энэ нь нийгэмд ач холбогдолтой боловч “эмэгтэйчүүдийнх” гэж үзэгдсээр байгаа, тухайлбал, асрах, халамжлах, цэвэрлэгээ хийх, хоол хийх, бусдад бие сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх, гэх мэт ахуйн (гэр орны

ажил) ажил. Хиймэл оюун ухаан, автоматжуулалт, робот техник зэрэг нь шинэ ажлын байр бий болгох боловч төдий чинээгээр олон хүнийг ажилгүй болгоно. Ажлын байраа алдсан хүмүүс ихэнхдээ шинэ боломж, шинэ технологийг ашиглахад хамгийн бага бэлтгэгдсэн хүмүүс байж магад. Мөн улс орнууд уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг авсан амлалтаа биелүүлэх зорилгоор нүүрсхүчлийн хийг багасгах, байгалийн нөөцийг хэрэглэсээр байгаа үйлдвэрүүдээ хаах тусам ажилгүй хүмүүс олноор бий болно.

**Хүний эрхийн зөрчил.** Олон улсын конвенц, тунхаглалууд гарч, тэдгээрийг олон орон соёрхон баталж байгаа ч бүс нутаг бүхэнд хүний эрхийн зөрчил улам гаарсаар. Дээрэнгүй үзэл, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзэл, гадаад иргэнийг үзэн ядах үзэл, шашны хэт туйлшрал зэрэг нь энх тайван, тэгш оролцоот нийгмийг бүтээхэд чөдөр тушаа болж, байгаль экологийн сүйрэл, уур амьсгалын өөрчлөлт нь хүн төрөлхтөн хийгээд бидний гараг дэлхийн оршин тогтнох эсэхт ч аюул учруулж буй билээ. Даяарчлал бидэнд олон талаар үр өгөөжөө өгсөн хэдий ч, дэлхийн хүн амын дийлэнх хэсэг ядуурал, өлсгөлөн, ялгаварлан гадуурхалт дунд амьдарч, тэгш бус байдал үндэсний хэмжээнд төдийгүй, дэлхийн хэмжээнд ч улам тэлжээ.

**Боловсролын үүрэг.** Эдгээр сорилт бэрхшээл биднийг бүх төрлийн хүчирхийллийн соёлыг бүх түвшинд үндсээр нь өөрчилж, дайнаас ангид байх, энх тайванч соёлыг дэлгэрүүлж, шударга, энэрэнгүй нийгэмд амьдрах, хүний эрх, хариуцлагатай байдлыг дэмжих, ялгаатай соёлыг хүндэтгэх үзлийг бэхжүүлж, зөвшилцөл хийх, эв санааны нэгдэлтэй байх, байгаль дэлхийтэйгээ зохицон дотоод амар амгаланг тэтгэн амьдрах соёлыг дэлгэрүүлэх шаардлагатай болсныг илтгэж байна. Сургуулиас ажил руу шилжих үед үүсдэг ур чадварын зөрүүг багасгах боломжгүй ч суралцахуйн агуулгыг өргөжүүлж, арга зүйг төрөлжүүлснээр дээрх бэрхшээлийг даван туулах боломжтой юм.

Боловсрол ирээдүйг өөрчлөхөд туслах ёстой юм бол өөрийнхөө өмнө буй шударга бус байдлыг арилгах замаар илүү тэгш хамруулсан байж, бодлого стратеги нь маргиналчлагдсан сурагчдыг, ялангуяа нийлмэл саад бэрхшээлүүдтэй тулгардаг сурагчдыг бодлогын төвд авч ирэн, дэмжих ёстой. Ингэвэл тэгш бус байдал болон боловсролоос гадуурхан хасч буй хүчин зүйлүүдийг бууруулж, таслан зогсоож чадна. Хувь хүн сурч мэдсэнээ, бүр албан бус боловсролын арга замаар болон амьдралын орчноос суралцсан ч гэсэн хүлээн зөвшөөрүүлэх, баталгаажуулах үндсэн эрхтэй. Өсөн тэлж буй нийгэм, эдийн засгийн тэгш бус байдал уур амьсгалын өөрчлөлт, биологийн төрөл зүйл цөөрөх, гараг дэлхийн хил хязгаараас давсан нөөцийн ашиглалт, ардчиллын хямрал, захгүй технологийн автоматжуулалт нь энэ цаг үеийн онцлог. Хувьсаж буй боловсролын үзэл агуулга, боловсролын нийгмийн шинэчилсэн гэрээ нь хүүхэд залуучууд, насанд хүрэгчид гээд бүх хүн дэлхий дээр бид холбогдсон байдаг бөгөөд бид хамтдаа үүний төлөө ажиллах нь зайлшгүй, нэн чухал гэдгийг баталж байна.

## 20 ДУГААР ЗУУНЫ БОЛОВСРОЛ

- Хүүхэд, залуучуудын заавал эзэмших албан боловсрол
- Тухайн улсын иргэний хөгжил, нийгмийн хөгжил

## ИРЭЭДҮЙН БОЛОВСРОЛ

- Нийтлэг байгаа бэрхшээл, асуудлыг улс орон, нийгмийн бүлгүүд хамтран шийдэх
- Тогтвортой, амар амгалан ирээдүйг бүтээх мэдлэг, инновацийг би болгох
- Нийгэм, эдийн засаг, байгаль орчны шударга ёсыг бий болгох

## 1.2 ДЭЛХИЙН ИРГЭНИЙ БОЛОВСРОЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Боловсрол, сургах зүйн ухааны эрдэмтэн, багш нарын үзэж буйгаар бол “Иргэн” хэмээх ухагдахуунд зөвхөн үндэстнийхээ амин чанарын үүднээс хандаж байгаа нь “иргэний боловсрол” олгох олон төрлийн аргуудыг хязгаарлаж буй шалтгаан юм. Олон улсын чиг хандлагад тулгуурлан “Дэлхийн иргэний боловсрол” хэмээх ойлголтыг боловсруулж хөгжүүлэгчид “иргэн” хэмээн ойлголтыг тухайлсан нэг улс үндэстнээс ахиулж, үгүйсгэж биш, даян дэлхийд хамааруулж, хувирган өөрчлөх боловсролын хэлбэрүүдийг бий болгож өгсөн.

Дэлхийн иргэний боловсролын тухай хэлэлцүүлэг 2012 оноос хойш эрчээ авч, олон улсын болон бүс нутаг, үндэстний хэмжээний хурал зөвлөгөөн, форум, семинаруудын голлох сэдэв байж, улмаар 2014 онд Мускат хотноо зохион байгуулагдсан “Боловсролыг бүх нийтэд!” олон улсын хурлаар дэлхий нийтийн сэдэв болсон. Түүнчлэн дэлхийн иргэний боловсрол болон 2030 он хүртэл баримтлах боловсролын бодлогын үзэл баримтлал хэрхэн холбогдож буйг 2015 онд БНСУ-ын Инчон хотноо ЮНЕСКО, НҮБ-ын Хүүхдийн сан, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Дүрвэгсдийн асуудал эрхэлсэн Дээд Комиссарын Газар, НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллага, Дэлхийн Банк зэрэг хамтран зохион байгуулсан Дэлхийн Боловсролын Форум дээр тайлбарлан таниулсан юм. Ийнхүү тэгш хамруулсан, чанартай, эрх тэгш боловсрол, насан туршийн суралцахуйн төлөөх Инчоны Тунхаглалд чанартай боловсрол нь *“иргэн хүнд эрүүл, бүрэн дүүрэн амьдрах, мэдээлэлтэйгээр шийдвэр гаргах, улс орон, олон улсын өмнө тулгамдаж буй асуудлыг тогтвортой хөгжил, дэлхийн иргэний боловсролын тусламжтайгаар шийдвэрлэх ур чадвар, үнэт зүйл, үзэл хандлагыг төлөвшүүлнэ”, түүнчлэн “хүний эрхийн боловсрол, сургалтын тусламжтайгаар 2015 оноос хойшх тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх”-эд чиглэнэ хэмээн тусгажээ.*

2015 оны есдүгээр сард НҮБ-ын Тогтвортой хөгжлийн дээд хэмжээний уулзалтын үеэр батлагдсан 2030 он хүртэл баримтлах Тогтвортой хөгжлийн зорилгууд нь Дэлхийн иргэний боловсролд голлох ач холбогдлыг өгсөн. ТХЗ 4 нь “тэгш хамруулсан, чанартай, эрх тэгш боловсрол, насан туршийн суралцахуйн боломжоор хангах”-ад чиглэнэ гэжээ. Дэлхийн иргэний боловсролын 4.7 дугаар зорилтод *“2030 он хүртэл суралцагч бүр тогтвортой хөгжил, тэнцвэртэй амьдралын хэв маяг, хүний эрх, жендэрийн тэгш байдал, энх тайванч, хүчирхийллийн бус соёл, дэлхийн иргэн зэрэг боловсролын хөтөлбөрүүдээр дамжуулан тогтвортой хөгжлийг дэмжих, мөн соёлын олон янзат байдал, тогтвортой хөгжилд үзүүлэх соёлын хувь нэмрийг үнэлж чадах тэрхүү мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байна”* хэмээн цохон тэмдэглэжээ.

### Дэлхийн иргэний боловсролын ач холбогдол

“Иргэн” хэмээх нэр томъёо нь аль нэг улс оронд харъяалагдах байдал, улс төрийн талбарт оролцох чадамжийг илтгэх тодорхойлолт, төлөв байдлыг илэрхийлдэг билээ. Ихэнх оронд иргэн хүн эх орныхоо өмнө улс төрийн үйл явцад оролцох, хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ, хууль эрхзүй, журам зохицуулалтын хүрээнд эдийн засаг, нийгэм, соёлын хувьд өөрийн тодорхой үүрэг, хариуцлага, итгэл найдвар хүлээдэг билээ. Иймд иргэний үнэт зүйл, үзэл хандлага, ур чадварыг тэтгэн хөгжүүлэх нь орчин үеийн боловсролын системийн нийтлэг зорилго.

Дэлхий нийтийн сорилт бэрхшээл дэлхий нийтийн хичээл зүтгэлийг шаардаж байна.

Улам бүр даяарчлагдан буй дэлхий ертөнцөд “иргэн” хэмээх ухагдахууныг аль нэг улс үндэстэнд харъяалагдах байдлаар тодорхойлох нь хангалтгүй болсон. Улс орнууд бол ахуй амьдралын олон шижмээр холбогдсон дэлхий хэмээх нэгэн улсын тосгод юм. Түүнчлэн шилжин суурьших, зөрчил мөргөлдөөн, боловсрол, эдийн засаг, соёлын солилцоо, аялал жуулчлал зэрэг шалтгаанаар шилжилт хөдөлгөөн хүн төрөлхтний түүхэнд өмнө гарч байгаагүй өндөр хэмжээнд хүрээд байна. Үүнийг даган давхар иргэншил бүхий иргэд ч олширчээ.

Дэлхийн иргэний боловсролын 2013 оны тайлангийн үр дүнд дэлхийн ард түмэн, газар нутаг улам

бүр харилцан хамааралтай, харилцан холбоотой болж буйг ухамсарлах, түүнчлэн “Делорын тайлан”-д тэмдэглэсэнчлэн “хамтдаа амьдрахад суралцах” шаардлага тулж ирээд байна. Харилцан холбоотой нийгэм нь соёл хоорондын ойлголцлыг сайжруулж, харилцан үр өгөөжтэй байдаг хэдий ч зөрчил мөргөлдөөн, хүчирхийлэл, үл итгэлцлийг гааруулахад ч нөлөөлөх нь бий. Жишээлбэл, эдийн засаг дахь гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэх нь нутгийн иргэдтэй зөрчил үүсгэх, газар нутгийг сүйтгэх үр дагавартай байж болох бол, харилцан холбоо сайжрах үед үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, хүний наймаа, хар тамхи, мансууруулах бодисын наймаа цэцэглэх хөрс суурь бүрдэх, түүнчлэн шилжин суурьшигчид, дүрвэгсэд, гадаад оюутнуудын тоо нэмэгдэх нь бусдыг дорд үзэх, ялгаварлан гадуурхах үзлийг хурцатгахад хүргэдэг билээ.

Бид хамтдаа амьдрахад суралцахаас гадна, дэлхий нийтийн өмнө тулгамдаж буй асуудалд нийтээрээ санаа зовниж, оролцож сурах хэрэгтэй боллоо. Бүхий л улс үндэстнийг багтаасан дэлхийн хэмжээний хамтын ажиллагаа нь уур амьсгалын өөрчлөлт зэрэг нийтлэг асуудлыг шийдвэрлэхэд нэн чухал юм.

### **Боловсрол ба Дэлхийн иргэн**

Боловсрол нь энх тайван, хүний эрх, тэгш байдлыг дэмжих, ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, тогтвортой хөгжлийг хангахад гол үүрэгтэй гэдгийг нийтээрээ ойлгон ухамсарлах болжээ. Дэлхий дахин нийтээрээ өөр хоорондоо улам бүр холбоо, хамааралтай болж буй өнөө үед боловсролоор дамжуулан үнэт зүйл, харилцааны ур чадвар, оюун санааны мэдлэгт сургах шаардлага тулгараад байна. Дэлхийн иргэний боловсрол нь “дэлхийн иргэн” хэмээх ойлголтыг газар нутгийн хил хязгаар, аль нэг улс орны иргэний харъяаллаас давуулан тодорхойлдог. ЮНЕСКО-гийн тодорхойлж буйгаар “дэлхийн иргэншил” гэдэг нь эрхзүйн ойлголт бус “дэлхий хэмээх нэгэн гэр бүлд харьяалагдах хүн ёсны хамтын ухамсрыг хэлнэ” гэжээ. Дэлхийн иргэн нь өөрийн улс орны иргэдийн эрх, сайн сайхны төлөө санаа тавихаас гадна дэлхийн бүхий л ард түмний эрх, эрх чөлөө, сайн сайхны төлөө санаа тавина гэсэн үг. Их Британийн нэгэн судалгаагаар “суралцагчид дайн, зөрчил мөргөлдөөн, ХДХВ, ДОХ-ын вирусын халдвар, ядуурал, агаарын бохирдол, хүний эрх гэх мэт орчин үеийн дэлхий нийтийн тулгамдсан асуудлуудыг таньж мэдэх, ойлгож ухамсарладаг байх шаардлагатай” гэсэн үр дүн гарчээ.

Цаашлаад, “дэлхийн иргэншил” хэмээх ойлголт нь иргэн хүн нийгмийн хэвшмэл дэг жаяг, хууль дүрмийг шүүмжгүйгээр дагаж мөрддөг идэвхгүй оролцогч байхын оронд улс төр, эдийн засаг, нийгэм, соёл гэх мэт нийгмийн бүхий л харилцаанд идэвхтэй, мэдээлэлтэй оролцогч байх үзэл санааг дэмждэг. Идэвхтэй иргэн гэдэг нь “хүний эрх, ардчилал, шударга ёсыг дээдлэх, ялгаварлан гадуурхах үзлээс ангид байх, ялгаатай байдал, жендэрийн тэгш эрх, тогтвортой хөгжлийг дэмжих үзэлд тулгуурлан илүү сайхан дэлхий, илүү сайн ирээдүйн төлөө олон нийтийн талбарт иргэний оролцоотой байх”-ыг хэлнэ.

Түүнчлэн “дэлхийн иргэн” хэмээх ойлголт нь аль нэг улс үндэстний иргэний харъяалал, иргэншлийг үгүйсгэж, орлож буй хэрэг биш гэдгийг анхаарах нь зүйтэй. Дэлхийн иргэний боловсролоор олгогдож буй үнэт зүйл, ур чадваруудыг дэлхийн төдийгүй өөрийн улс орон, орон нутгийн хэмжээнд ч жигд хэрэглэх боломжтой юм. Дэлхийн иргэний боловсролоор дамжуулан иргэд орон нутгийн төдийгүй үндэстний хэмжээний асуудлуудад идэвхтэй оролцож, дэлхий нийтийн асуудлууд улс орон, орон нутагт хэрхэн нөлөөлдөг тухай мэдлэгтэй болох юм.

### **Дэлхийн иргэний боловсрол гэж юу вэ?**

Энэхүү хэсэгт НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын (ЮНЕСКО) болон бусад төрөлжсөн байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд, хувирган өөрчлөх боловсролыг хэрэгжүүлэгч багш, сурган хүмүүжүүлэгчдийн боловсруулсан дэлхийн иргэний боловсролын зорилго, зорилтод үндэслэсэн түүний үнэт зүйл, зарчим, хэтийн төлөвийн ерөнхий чиг хүрээг зураглана.

ЮНЕСКО **дэлхийн иргэний боловсролыг** “шударга, энх тайван, хүлээцтэй, хүртээмжтэй, аюулгүй,

тогтвортой нийгмийг бүтээхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, үнэт зүйл, үзэл хандлагыг боловсролоор дамжуулан суралцагчид хэрхэн олгохыг багцалсан цогц загвар юм” хэмээн тодорхойлжээ. Энэ нь дэлхий нийтэд тулгамдаж буй асуудлуудыг нийгэм, улс төр, соёл, эдийн засаг, хүрээлэн буй орчны гэх мэт олон хэмжээст ойлгох, шийдвэрлэхэд боловсролын үүрэг, ач холбогдлыг ухамсарлан ойлгох өөрчлөлтийг тодорхойлж буй хэрэг. Түүнчлэн боловсрол нь суралцагчдын мэдлэг, сэтгэн бодох ур чадварыг хөгжүүлээд зогсохгүй, үнэт зүйл, харилцааны зөөлөн ур чадварууд, үзэл хандлагыг хөгжүүлэн төлөвшүүлснээр олон улсын хамтын ажиллагаа, нийгмийн өөрчлөлтийг авч ирэх боломжтой болох юм. Дэлхийн иргэний боловсрол нь:

- Орон нутаг, улс орон, дэлхийн хэмжээний нийгмийн хөгжлийн бүхий л асуудалд идэвхтэй, хариуцлагатай оролцох чадамжтай иргэнийг бэлтгэх;
- Олон янзын соёлыг хүндэтгэдэг, соёл хоорондын ойлголцлыг дэмждэг, соёл хоорондын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх чадамжтай иргэнийг бэлтгэх;
- Орон нутаг, улс орон, дэлхийн хэмжээний зөрчил мөргөлдөөний учир шалтгааныг шүүмжтэйгээр ойлгодог;
- Шударга, энх тайван, хүлээцтэй, хүртээмжтэй, аюулгүй, тогтвортой нийгмийг бүтээхэд хувь хүний болон бие хүний түвшинд оролцоход иргэдийг чадавхжуулах зэрэг багтана.

### **Дэлхийн иргэний боловсролыг хэрэгжүүлэх стратеги, зарчмууд**


Дэлхийн иргэний боловсролын (ДИБ) стратеги, сургах зүйн ухааны зарчмуудыг боловсрол судлалын эрдэмтдийн бүтээлүүд, ДИБ-ыг хэрэгжүүлж буй үйл явцаас тодорхойлон гаргах боломжтой. Жишээлбэл, Вернэр Винтерстэйнэр тэргүүтэй судлаачид (2015) ДИБ-ын дөрвөн үндсэн зарчмыг тодорхойлсон байдаг.

- Хүний эрх, үнэт зүйл, энх тайван, нийгмийн шударга ёсны чиг баримжаа
- Улс төрийн үйл ажиллагааны цогц чадамж, оролцоо
- Шүүмжлэлт эргэцүүлэл, дүн шинжилгээ
- Хэн нэгэн этгээд, аль нэг улсын хувьд түүхийн-шүүмжит байр суурь баримтлах

Энх тайвны боловсрол, Олон улсын харилцан ойлголцлын боловсролын гол зарчим, стратеги нь дараах зүйлсийг (Зураг 1-ийг үзнэ үү) өөртөө агуулсан байдаг.

- Бүхэллэг\цогц: Зөрчил мөргөлдөөн, хямралыг бүхэлд нь харах
- Харилцан ярилцах: Суралцахууд оролцох, харилцан ярих, бүтээх үйл явц
- Үнэт зүйлийг бүтээх: Энх тайванч ард түмэн, дэлхий ертөнц хэмээх үзэл санаанд тулгуурласан үнэт зүйлийг төлөвшүүлэх
- Шүүмжит эрхмэдэлжилт: Энх тайван, шударга, хүртээмжтэй, энэрэнгүй, нийцтэй, тогтвортой хөгжлийг хангасан нийгмийг бүтээхийн тулд иргэдийг хувийн болон нийгмийн түвшинд үйлдэл хийх чадамжтай болгох

**Зураг 1.** Энх тайвны боловсролын арга зүйн зарчмууд



Сургалтын олон төрөл, хэв маягийн арга стратеги, практикт үндэслэн ДИБ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримталдаг. Үүнд:

- ☞ Насан туршийн боловсролыг дэмжих
- ☞ Оролцоо, бүтээлч байдал, асуулт, туршилт, нийгэмд үйлчлэх ажилд суурилсан суралцахуйн ардчилсан хэв маягийг дэмжих
- ☞ Эцэг эхийн эрх мэдэлжилт, оролцоог дэмжих. Суралцагчид өөрийн чадавхыг бүрэн дайчилж дэлхийн иргэн болж төлөвшихөд эцэг эхчүүд сургууль, боловсролын байгууллагуудын нэгэн адил тэднийг суралцах таатай орчноор хангах үүрэгтэй.
- ☞ Хөгжил, хүний эрх, соёлын олон янз байдал, тэгш хамруулалт, нийгмийн болон эдийн засгийн шударга ёс, жендэрийн эрх тэгш байдал, тогтвортой хөгжил, амьдралын үнэт зүйлст тулгуурлан хүн бүрийн сайн сайхан байдлыг хүндэтгэх
- ☞ Өөрийн болон өөр бусад орны иргэдийн энх тайван, аюулгүй байдал, нийгэм, эдийн засгийн шударга байдал, хүний эрх, тогтвортой хөгжлийн төлөө орон нутгийн засаг захиргаа, улс орны засгийн газрын бодлого стратегит шүүмжтэйгээр дүн шинжилгээ хийх чадамж бүхий хариуцлагатай иргэн болгон төлөвшүүлэх

Дэлхийн иргэний боловсролыг хэрэгжүүлэхэд дараах стратегийг баримтлахыг мөн зөвлөдөг.

- ☞ ДИБ-ыг бүхий л хэлбэрийн боловсролын үйл ажиллагаанд түгээмэл хэрэглэх (албан, албан бус, гэрийн боловсрол, мэргэжлийн сургалт үйлдвэрлэл, насанд хүрэгчдийн бичиг үсэгт тайлагдах сургалт). Мөн албан болон албан бус, гэрийн боловсролын хоорондын уялдаа холбоог сайжруулах
- ☞ ДИБ-д хүүхэд залуусыг хамруулах, тэдний оролцоог дэмжих
- ☞ ДИБ-ыг сургалтын хөтөлбөрт оруулах эсвэл суралцахуйн бүхий л хүрээнд шингээх. Энэ нь тусгайлсан хичээл хэлбэрээр зааснаас илүү үр дүнтэй байдаг.
- ☞ Сургууль бүхлээрээ аргыг ашиглах, иргэний нийгмийн байгууллагууд, итгэл бишрэлд суурилсан болон бусад төрлийн төрийн бус байгууллагууд, боловсролын салбараас гадна орших өөр нэгдэл, байгууллагуудтай холбоо тогтоох
- ☞ ДИБ нь **мэдэхийн тулд, хийхийн тулд, оршихын тулд, хамтдаа амьдрахын тулд суралцах** гэсэн Делорын хорооны тайлангийн Боловсролын дөрвөн үндсэн баганад тулгуурласан байх
- ☞ Цахим хэвлэл, мэдээллийн боловсролыг суралцахуйн бүхий л хүрээнд оруулж өгөх, үзэн ядах, хэт туйлширсан мэдэгдлүүд цахим сүлжээ, нийгмийн сүлжээгээр тараахын эрч, нөлөөг шүүмжлэлт сэтгэлгээгээр ухамсарлаж сургах
- ☞ Хүний эрх, нийгэм, эдийн засгийн шударга байдал, соёлын олон янз байдал, жендэрийн тэгш эрх, тогтвортой хөгжлийн зарчмуудад тулгуурлан өнөөгийн болон ирээдүйн ард иргэдийн сайн сайхны төлөө суралцагчдыг бэлтгэх
- ☞ Энх тайван, аюулгүй байдал, нийгэм, эдийн засгийн шударга байдал, хүний эрх, тогтвортой хөгжлийн хүчин зүйлсийг сулруулж буй үндэсний дотоод, гадаад бодлогод дүн шинжилгээ хийж, өөрчлөхөд чиглэсэн иргэдийн хариуцлагыг дэмжих

## Дэлхийн иргэний боловсролын суралцахуйн ай, цогц чадамж

ЮНЕСКО 2015 оны “Дэлхийн иргэний боловсрол” удирдамжид суралцахуйн үндсэн гурван айг дараах байдлаар тусгасан байдаг.

**Зураг 2. ЮНЕСКО-гийн дэлхийн иргэний боловсролын суралцахуйн үндсэн ай<sup>5</sup>**

Суралцахуйн ай	Зорилго
<b>Танин мэдэхүйн</b>	Улс орнууд, тэдний ард түмний харилцан холбоо, хамааралтай байдал, орон нутаг, улс орон, бүс нутаг, дэлхийн хэмжээний асуудлуудыг шүүмжтэйгээр эргэцүүлэх, ойлгох мэдлэгийг олж авах
<b>Нийгэм-сэтгэл хөдлөлийн</b>	Нийтлэг үнэт зүйл, хариуцлага, энэрэх сэтгэл, эв санааны нэгдэл, ялгаатай, олон янз байдлыг хүндэтгэх зэрэг хүн төрөлхтөнд харъяалагдах мэдрэмжтэй болох
<b>Зан үйлийн</b>	Илүү энх тайван, тогтвортой хөгжил бүхий дэлхий ертөнцийг бүтээхийн тулд орон нутаг, улс орон, дэлхийн хэмжээнд үр нөлөөтэй үйлдэл хийдэг болох

Нийгэм-сэтгэл хөдлөлийн ай нь идэвхтэй сонсох, тодруулан лавлах, соёл хоорондын, аман бус, хүндлэл, энэрэл, нээлттэй сэтгэх болон цахим бичиг үсэгт тайлагдах зэрэг харилцааны ур чадварыг дотроо агуулдаг.

5 Global citizenship education: A Guide for Policymakers (2017), UNESCO and APCEIU

Энэхүү олон талт суралцахуйн айн тогтолцоо нь үр нөлөөтэй суралцахуй бол танин мэдэхүйн түвшнээс хальж, суралцагчийн нийгэм сэтгэл хөдлөл, зан үйлийн цогц чадамжийг хөгжүүлдэг гэсэн хувирган өөрчлөх боловсролын онол, практиктай нийцсэн. Эдгээр чадамжууд дээр нэмээд асуудлыг шүүмжтэйгээр ойлгох чадвар нь суралцагчийг хувь хүний зүгээс болон нийгмийн нэг хэсгийн хувьд өөрчлөлтөд чиглэсэн үйлдэл хийх боломжтой болгодог. ДИБ-ын заах аргагүй, суралцахуй нь хувирган өөрчлөх боловсролын үнэт зүйл, зарчмуудтай нийцэж байх ёстой. Жишээлбэл, ардчилсан, оролцоот, бүтээлч, лавлагаанд суурилсан суралцахуй нь үйл ажиллагаанд чиглэсэн нийгэм сэтгэл хөдлөл, зан үйлийн чадамжийг хөгжүүлж өгдөг.

ДИБ-ын загваруудын нэгэн адил суралцагчийн олж авч, хөгжүүлэх шаардлагатай мэдлэг, хандлага, ур чадварууд гэх зэрэг цогц чадамжийн талаарх харилцан адилгүй хандлагууд бий. Үүний нэг нь “21-р зууны цогц чадамж” хэмээх хандлага юм.

**Зураг 3. XXI ууны ур чадваруудыг тодорхойлсон нь**

Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллага (OECD)	Asia Society
<ul style="list-style-type: none"> <li>☞ мэдээлэлтэй харьцах (судалгаа хийх, асуудал шийдвэрлэх, мэдээллийг боловсруулах);</li> <li>☞ харилцах (харилцаа холбоо тогтоох, хамтран ажиллах, цахимаар харилцах);</li> <li>☞ ёс зүй, нийгэмд нөлөө үзүүлэх (нийгмийн хариуцлага, цахим иргэншил, хүрээлэн буй орчны төлөөх үйлдэл) зэрэг багтана</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>☞ хүн хоорондын харилцаа (харилцаа холбоо тогтоох, хамтран ажиллах, хариуцлагатай байх, зөрчил маргааныг шийдвэрлэх);</li> <li>☞ хувь хүний (уян хатан, санаачлагатай, олон янз байдалд талархалтай хандах, өөрийн сурсан зүйлсийг тунгаах чадвартай);</li> <li>☞ танин мэдэхүйн (шүүмжит сэтгэлгээ, мэдээллийн бичиг үсэгт тайлагдсан, учир шалтгааныг тунгаах, мэтгэлцэх, шинийг санаачлах)</li> </ul>

Дэлхийн иргэний боловсролын цогц чадамжийг тодорхойлсон өөр нэгэн чиг хандлага нь тогтвортой, энх тайванч дэлхийг бүтээх дэлхийн иргэншлийн үзэл санаатай уялдсан байдаг. Жишээлбэл, ЮНЕСКО-гийн арга зүйн удирдамжид суралцагчийг дараах байдлаар тодорхойлсон.

- Мэдээлэлтэй, шүүмжит сэтгэлгээнд нэвтэрсэн: Дэлхий нийтийн засаглалын систем, бүтэц зохион байгуулалт, тулгамдаж буй асуудлуудын талаар мэдлэгтэй; Олон улс болон улс орны өмнө тулгарч буй асуудлуудын харилцан уялдаа холбоог ойлгож ухамсарладаг; шүүмжтэйгээр асуух, дүн шинжилгээ хийх, байнгын идэвхтэй суралцахуйг эрхэмлэх зэрэг иргэний төлөвшлийн мэдлэг, ур чадварыг эзэмшсэн;
- Нийгэмтэй холбоотой, олон янз байдлыг хүндэтгэдэг: амин чанар, харилцаа, харъяалагдах байдлыг ойлгодог, хамтын үнэт зүйл, хүмүүнлэг үзлийг ойлгож ухамсарладаг, ялгаатай, олон янз байдлыг талархан, хүндэтгэх хандлагыг дэмждэг, нийтлэг болон олон янз байдлын цогц харилцааг ойлгодог;
- Ёс зүйтэйгээр оролцох, хариуцлага хүлээх: Хүний эрхийн зарчим, хүн болон байгаль, хүрээлэн буй орчныг хамгаалах үзэл хандлага, үнэт зүйлд тулгуурлах; хувийн болон нийгмийн хариуцлага, өөрчлөлт; нийгмийн оролцоотой байх, мэдээлэлтэй, ёс зүйтэй, энх тайванч үйл хэргээр дамжуулан илүү сайхан дэлхий ертөнцийг бий болгоход өөрийн хувь нэмрийг оруулах ур чадварыг хөгжүүлэх;

Оксфам байгууллагаас (Oxfam) ДИБ-оор олгох цогц чадамжийг дараах байдлаар тодорхойлсон нь дээр дурдсан 21-р зууны цогц чадамжуудтай ижил бөгөөд нийгмийн шударга ёс, хүний эрх, олон янзат байдал, тогтвортой хөгжил, оролцоо, тэгш хамруулах зарчмуудыг дэмжих мэдлэг, хандлага, ур чадваруудад түлхүү ач холбогдол өгсөн байна.

Тогтвортой хөгжлийн 4.7 зорилт болох тогтвортой хөгжил, жендэр, хүний эрхийн боловсролтой холбоотой дэлхийн иргэний боловсрол болон бусад агуулгуудын бие биенээ харилцан дэмжих, хамтран хөгжих боломжид тулгуурлаж байж цааш хөгжих шаардлагатай. “Хувирган өөрчлөх боловсрол” хэмээх нэгэн өргөн голд цутгаж буй олон жижиг горхины нэг төдийгүй тэрхүү олон цутгалан нь харилцан биенээ хүндэтгэж, тулгарсан сорилт, туршлагаа харилцан бие биедээ хуваалцдаг байхыг хэлнэ.

Зураг 4. Дэлхийн иргэний боловсролоор олгох цогц чадамж



ДИБ-ын тулгын чулуу болсон агуулга нь **иргэний боловсрол** билээ. Иргэний боловсрол нь ДИБ-ын тулгын чулуу бөгөөд ардчилсан нийгэмд, шударга ёс, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсыг эрхэмлэн дээдэлж, бусдын үзэл бодол, ахуйн соёлын ялгааг хүлээн зөвшөөрч, байгаль орчноо хайрлан хамгаалж, байгалийн нөөц баялгийг зөв зохистой ашиглан, уламжлалт зан заншлыг хойч үедээ өвлүүлэн үлдээх, нийгмийн олон талт харилцаанд тэнцвэртэйгээр оролцох чадвартай иргэн болж төлөвшүүлэх ач холбогдолтой насан туршийн боловсрол юм. ЮНЕСКО-гоос иргэний боловсролын хөтөлбөрөөр дамжуулан хүний эрх чөлөөг эрхэмлэн дээдэлж, аливаа зөрчил, эрсдэлээс сэргийлж, тэгш байдал, ардчилсан нийгэм дэх шийдвэр

гаргах үйл явцад иргэний оролцоог дэмжихэд анхаарч, дэлхийн иргэний боловсролын агуулгыг уг хичээлээр дамжуулан олгохыг зөвлөж байна.

Тухайн улсын зүгээс үндэстнийхээ амин чанарт тулгуурлан дэлхийн бүхий л хүн төрөлхтний идэвхтэй гишүүн байхын тулд суралцагчдын үйл хэрэг болгох чадамжийг тусгайлан анхаарах ёстой. НҮБ, Европын зөвлөлийн хүний эрхийн боловсрол, ардчиллын боловсрол, иргэний боловсролын агуулгын хүрээг цогц чадамжаар нь дараах байдлаар илэрхийлж байгаа нийтлэг хандлага байна. (Хүснэгт 1-г харна уу)

### Хүснэгт 1. Цогц чадамжууд

Нийгмийн хувьд олон янз бүлгүүдтэй харьцах	<ul style="list-style-type: none"> <li>• Бусадтай сайнаар харилцах чадвар</li> <li>• Хамтран ажиллах чадвар</li> <li>• Зөрчлийг удирдах, шийдвэрлэх чадвар</li> </ul>
Бие даан үйлдэх	<ul style="list-style-type: none"> <li>• “Том зураг”-аа харж үйлдэх чадвар</li> <li>• Амьдралаа төлөвлөх, хувийн төслүүдийг зохиох, хэрэгжүүлэх чадвар</li> <li>• Хэн нэгний эрх, ашиг сонирхол, хязгаарлагдмал байдал, эрэлт хэрэгцээг ойлгох, хамгаалах чадвар</li> </ul>
III. Хэрэгслүүдийг зорилготой ба олон боломжоор ашиглах	<ul style="list-style-type: none"> <li>• Хэл, дүрс тэмдэг, текстийг/эхийг ашиглах чадвар</li> <li>• Мэдлэг, мэдээллийг ашиглах чадвар</li> <li>• Технологийг хэрэглэх чадвар</li> </ul>



## БҮЛЭГ 2.

# МОНГОЛ ДАХЬ ДЭЛХИЙН ИРГЭНИЙ БОЛОВСРОЛЫН ӨНӨӨГИЙН ТОЙМ МЭДЭЭЛЭЛ

## БҮЛЭГ 2.

# МОНГОЛ ДАХЬ ДЭЛХИЙН ИРГЭНИЙ БОЛОВСРОЛЫН ӨНӨӨГИЙН ТОЙМ МЭДЭЭЛЭЛ

Манай улсад сургалтын хөтөлбөр ялангуяа, ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр хөгжиж ирсэн түүхэнд хамгийн ороо бусгаа, “адал явдалтай” судлагдахуун, сургалтын хөтөлбөр, сурах бичиг бол “Иргэний боловсрол” олгох агуулга, судлагдахуун байсан гэж хэлж болно. Учир нь энэ судлагдахуун хоёр удаа сургалтын хөтөлбөрт багтахдаа улс төрийн шийдвэрээр, тэр тусмаа улс төрийн эрх мэдэлтний шийдвэрээр орж, агуулга нь гэнэт тэс өөр болон өөрчлөгдөж, шүүхийн шийдвэрээр сурах бичиг нь хэрэглээнээс татагдаж, шинээр зохиогдохдоо ардчилал, хүний эрх, иргэний боловсролын агуулга нь хасагдсан зэрэг олон үйл явдал холбогддог.

ЕБС-ийн сургалтын хөтөлбөрт анх БСШУЯ-ны сайдын 2006 оны 236 дугаар тушаалаар Иргэний боловсрол хичээл орж эхлэн, улмаар Монгол улсын Ерөнхийлөгчийн “Иргэний боловсрол хичээлийн хөтөлбөрт уламжлалт зан заншил, арга билгийн ухааны үндсийг тусгах тухай” 2010 оны 103 дугаар зарлиг гарч, БСШУЯ-ны сайдын 2011 оны 281 дүгээр тушаалаар Иргэний боловсрол хичээлийг нийт ЕБС-иудад судалж эхэлсэн<sup>6</sup>.

Монгол Улс НҮБ-ын чуулганаар тунхагласан “Бичигтэн болгох 10 жил”-ийн эхлэл суурийг ЮНЕСКО-гийн хүрээнд тогтоолын төсөл боловсруулан тавьж байснаас гадна “Ардчиллын боловсролоор дамжуулан дэлхийн иргэнийг төлөвшүүлэх зорилтыг дэмжих” тухай тогтоолын төсөл санаачлан, бусад гишүүн орнуудын хамт боловсруулан ЮНЕСКО-гийн Ерөнхий бага хурлын 37 дугаар чуулганд оруулан 2013 онд батлуулсан байдаг.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2014 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/240 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар “Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр”-ийг баталж, 6 дугаар зүйлийн 6.1 ба 6.2-т “цөм хөтөлбөрийн хүрээнд сургалтыг дэмжих үйл ажиллагааны дор иргэний боловсрол, амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа, хичээлээс гадуурх үйл ажиллагаа ойлгоно” гэж сургалтын үйл ажиллагааны чиглэлийг баталсан. Нэр бүхий ТББ-ын нэхэмжлэлээр Ерөнхий боловсролын сургуулийн I-V ангийн “Иргэний боловсрол (ёс суртахууны унших эх)” сурах бичгүүдийг ЕБС-ийн сурах бичгийг зохиох, хэвлүүлэх, түгээх журмын дагуу, бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавигдах MNS5418:2008 стандарт шаардлагад нийцүүлэн дахин зохиож, хэрэглээнд нэвтрүүлэхийг БСШУСЯ-нд даалгасан шүүхийн шийдвэр<sup>7</sup> гарсан байна.

Мөн 2014 оноос эхлэн өнөөдрийг хүртэл хэрэгжиж байгаа цөм хөтөлбөрийн явцад гэнэт “Иргэний ёс зүйн боловсрол” хичээлийг БСШУС-ны сайдын “Хөтөлбөр шинэчлэн батлах тухай” 2019 оны А\390 дүгээр тушаалын дагуу хөтөлбөр, сурах бичгийг шинээр боловсруулан 2020-2021 оны хичээлийн жилээс эхлэн ЕБС-д судалж байна. Цөм хөтөлбөрийн хүрээнд боловсруулагдсан “Иргэний боловсрол” хичээлийн оронд өнөөдрийг хүртэл судалж байна.

2015 онд БСШУ-ны Сайдын А/458 дугаар тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн сургалт, үйл ажиллагаанд тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг тусган хэрэгжүүлэх үндсэн чиглэл,

6 “Иргэний ёс зүйн хичээлийн 6-12-р ангийн сурах бичигт хүний эрх, жендэрийн дүн шинжилгээ, ХЭҮК, 2023 он

7 ЗХАШШүүх, 2016, хууд. № 739

шаардлага” батлагдсан нь Боловсролын яам, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Швейцарийн хөгжлийн агентлагийн хамтран хэрэгжүүлсэн “Тогтвортой хөгжлийн боловсрол” төслийн үр дүн байлаа. 2016 оноос эхлэн Боловсролын хүрээлэн нь Олон улсын ойлголцлын боловсролын Ази-номхон далайн төв (APCEIU) байгууллагатай хамтран дэлхийн иргэний боловсролын хөтөлбөр боловсруулах, улмаар сургалтын хөтөлбөрт шингээх зорилготой төсөл хэрэгжүүлж эхэлсэн байна.

“Монгол улсын Тогтвортой хөгжлийн зорилго 4” хэрэгжилтийн ахиц дэвшлийн тойм үнэлгээ (2016-2021) тайланд дурдсанаар “дэлхийн иргэний боловсрол, жендерийн хэвшмэл ойлголт, хүйсийн тэгш байдал” зэрэг тогтвортой хөгжлийн боловсролд холбогдох түлхүүр нэр томъёог бодлогын болон сургалтын баримт бичигт бараг хэрэглээгүй байна. Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт “тогтвортой хөгжлийн боловсрол” тодорхой хэмжээнд тусгагдсан боловч дээд боловсролын сургалтын хөтөлбөр, ЕБ-ын сурах бичиг нь жендерийн мэдрэмжгүй байгааг анхаарах шаардлагатай. “Тогтвортой хөгжлийн гол үзэл санааг илэрхийлсэн тогтолцоот сэтгэлгээний чадвар (аливаа зүйлийн харилцан хамааралд таних, нийлмэл тогтолцоог задлан шинжлэх), урьдчилан тооцох чадвар (урьдчилан сэргийлэх), шүүмжлэлт сэтгэлгээ, хариуцлага хүлээх, ухамсартай зөв сонголт хийх, нийгэмд эв зүйтэй амьдрах зэрэг чадвар бүхий агуулга бага, суурь, бүрэн дунд боловсролын сурах бичгүүдэд тусгагдаагүй байгааг судалгааны үр дүн харуулж байна.” гэжээ.

БШУ-ны сайдын 2021 оны А/134 тоот тушаалаар батлагдсан ажлын хэсэг судлагдахуун бүрээр сурах бичиг, түүний дагалдах багцын (дасгалын ном, багшийн ном, хэрэглэгдэхүүн) өнөөгийн хөгжлийн төлөв байдалд дүгнэлт хийж тайлан гаргажээ.

Монгол улс Дэлхийн иргэний боловсролын агуулгыг ЕБС-ийн сургалтын хөтөлбөрт “Иргэний ёс зүйн боловсрол” хичээлийн агуулгаар олгож байгаа. “сургалтын хөтөлбөрийг ёс зүйн мэргэжлийн багш, судлаач боловсруулаагүйгээс болж, хөтөлбөрийн агуулга дахь ёс зүйн шинжлэх ухааны мэдлэгийн агуулга бараг ороогүй бөгөөд буддын шашны ёс зүй болон монгол ёс заншлын талаар голдуу бичсэнийг өөрчилж, сургалтын хөтөлбөрийг бүхэлд нь шинээр шинжлэх ухааны мэдлэгийн агуулгыг нэмж боловсруулах шаардлагатай гэж үзэж байна”<sup>8</sup> гэсэн дүгнэлтийг судлаачид хийжээ. Улмаар “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөр болон суралцахуйн зорилт нь өөрөө дэлхийн иргэн гэхээсээ илүүтэй үндэсний онцлог бүхий иргэнийг бэлтгэхэд чиглэсэн агуулгатай байгааг анхаарч, үндэсний уламжлалт ёс суртахууны сэтгэлгээ болон хүн төрөлхтний ёс суртахууны үнэт зүйлсийг хослуулсан агуулгатай байх нь зүйтэй”<sup>9</sup> гэж зөвлөмж өгчээ.

Иргэний ёс зүйн боловсрол 6-12 ангийн сурах бичигт “буддын философи, буддист сэтгэл судлал, шашны агуулга харьцангуй ихэнх хувийг эзлэж байна. Төв үзэл, арга билгийн ухаан, арга, арга ухаан, билиг, билиг ухаан, билиг оюун г.м. 23 дахь талд байгаа буддын гүн ухааны ойлголтууд иргэний ёс зүйд хэрхэн холбогдож байгааг анхаарах”, “XXI зууны иргэн хүнд байх ёс суртахууны үнэт зүйл, эрхэмлэл, төлөвшил болон орчин үеийн иргэний ёс зүйн боловсролд хувь нэмэр оруулах агуулгыг нэмэгдүүлэх”, “олон соёлын бодлогыг Монгол улсад мөрдөгдөж буй бүх сурах бичигт аль болох оруулах, XXI зууны иргэнд НҮБ, ЮНЕСКО-оос дэвшүүлж буй үзэл баримтлалыг сурах бичгээр дамжуулж ойлгуулах хэрэгтэй байна.” “Үндэстний цөөнх болон угсаатны цөөнхийн аж амьдрал, түүх соёл, улс орныхоо хөгжилд оруулсан хувь нэмрийг тусган харуулж, эв найртай, бие биенээ хүлээн зөвшөөрч, хүлцэн тэвчиж аж төрдөг болгоход орчин үеийн сурах бичгийн агуулгыг хандуулахад анхаарах” зэрэг зөвлөмжийг судлаачид нэмж өгчээ.

8 Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичигт хийсэн шинжилгээний дүнгийн тайлан, БШУЯ, АХБ, 2021 он.

9 Мөн тэнд

### **Бусад хичээлээр дэлхийн иргэний боловсрол олгож байгаа байдал**

Бага, суурь, бүрэн дунд боловсролын хүн орчин I-III, хүн байгаль IV-V, монгол ёс хүмүүжил, зураг технологи, дизайн технологи, монгол хэл, хөгжим, мэдээллийн технологи, хими, физик зэрэг сурах бичгийн агуулгыг баримтын, ухагдахууны, үйлийн, ахуйн, метакогнитив гэсэн мэдлэгийн төрлүүдэд суралцахаар жигд боловсруулсанаас гадна үйлийн мэдлэгийг түлхүү эзэмшүүлэхээр агуулгын шийдлийг хийсэн байна.

Бүрэн дунд боловсролын түвшний сурах бичгүүдэд баримтын болон ухагдахууны мэдлэгийг эзэмшүүлэх агуулга зонхилж, үйлийн мэдлэгийг эзэмшүүлэх агуулга цөөхөн байв. Бага, суурь, бүрэн дунд боловсролын байгалийн ухаан, хөгжим, зураг, дизайн технологийн сурах бичгүүдэд суралцагч өөрийгөө танин мэдэх, өөрийгөө хөгжүүлэх, ёс суртахууны агуулга бүхий сэдвүүдийг хангалтгүй тусгаж; монгол хэл, уран зохиол, англи хэл, орос хэл, монгол ёс, хүмүүжил, нийгмийн ухаан, түүхийн сурах бичгүүдэд дээрх агуулгыг хангалттай тусгасан нь суралцагчийн танин мэдэхүйн хөгжил, нас сэтгэхүйн онцлогт ерөнхийдөө тохирсон гэж үзэж байна.

Бага, суурь, бүрэн дунд боловсролын сурах бичигт сэргээн санах, ойлгох, хэрэглэх түвшний (доод эрэмбийн) чадварыг дэмжсэн даалгавруудыг түлхүү боловсруулж, задлан шинжлэх, үнэлэх, бүтээх түвшний чадварыг (дээд эрэмбийн) дэмжсэн дасгал даалгавар цөөн боловсруулсан байна.

Тогтвортой хөгжлийн гол үзэл санааг илэрхийлсэн тогтолцоот сэтгэлгээний чадвар (аливаа зүйлийн харилцан хамааралд таних, нийлмэл тогтолцоог задлан шинжлэх), урьдчилан тооцох чадвар (урьдчилан сэргийлэх), шүүмжлэлт сэтгэлгээ, хариуцлага хүлээх, ухамсартай зөв сонголт хийх, нийгэмд эв зүйтэй амьдрах зэрэг чадвар бүхий агуулга бага, суурь, бүрэн дунд боловсролын сурах бичгүүдэд тусгагдаагүй байгааг судалгааны дүн харуулж байна.

Суурь боловсролын монгол хэлний сурах бичгийн агуулгад ухагдахууны болон метакогнитив мэдлэг олгох агуулга жигд хэмжээтэй орсон. Монгол үндэстэн, ястны соёл, боловсрол, сэтгэлгээ, хүн хүний харилцааны ёс суртахууны үнэт зүйлийг агуулсан сэдвийг тодорхой хэмжээнд оруулсан. Суралцагчийн суралцах ёс зүйн хүмүүжил төлөвшил олгох сэдвүүдээс хамтарч ажиллах, байгаль орчноо хамгаалах, өөрийгөө хүмүүжүүлэх, ёс суртахууны төлөвшил эзэмшүүлэх сэдвийн агуулга маш цөөн орсон. Баримтын болон ахуйн мэдлэг олгох, үнэлэх, асуудал шийдвэрлэх арга барилд суралцах дасгал даалгавар болон олон сонголттой дасгал, даалгаврын тоо харьцангуй цөөн. Боловсролын талаарх дэлхийн чиг хандлага, тогтвортой хөгжлийн агуулга, иргэний зайлшгүй эзэмшсэн байх чадваруудыг хангалтгүй оруулсан.

Казах сурах бичгийн хувьд хос хэлний боловсролд ихээхэн анхаарч казак монгол хэлийг эн чацуу эзэмшсэн иргэн болгон төлөвшүүлэх, казах хэл, казахын уран зохиолоос бусад судлагдахууны сурах бичгийг монгол сурах бичгийг орчуулж хэрэглэх, орон нутгийн сургуульд тухайн нутгийн онцлог, тухайн ястны зан заншил, үнэт зүйлсийг хөтөлбөрт оруулж тусгайлан сургуулийн мэдлийн цагт оруулдаг болох шаардлагатай байна.

Физикийн хичээлийн X, XI ангийн сурах бичгийн агуулгад Дэлхийн чиг хандлага, тогтвортой хөгжлийн агуулга, суралцагчдын шүүмжлэлт сэтгэлгээний чадвар, нийгэмд эв зүйтэйгээр амьдрах чадвар сэтгэлгээг хөгжүүлэх даалгавруудын эзлэх хувийг нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

Эх сурвалж: Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичигт хийсэн шинжилгээний дүнгийн тайлан, БШУЯ, АХБ, 2021 он

Монгол улсын түүхэн сургамж, нийгэм, улс төрийн нөхцөл дор бүрэлдэн тогтсон өнөөгийн Үндсэн хуульт ардчилсан тогтолцоо нь боловсролоор дамжуулан Үндсэн хуулийн үнэт зүйлийг түгээн дэлгэрүүлэх учиртайг олон судлаачид онцолсон байдаг. Тухайлбал, Үндсэн хуулийн эхийг баригч Б.Чимидийн “Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс” номны уншлага 2024 онд зохион байгуулагдсан бөгөөд зарим илтгэлүүдээс онцольё.

Д.Гангабаатарын “Шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлал бүрэлдэн тогтсон тухайд” илтгэл<sup>10</sup>д “Үндсэн хуульт ёс, ардчилсан төрт ёс, хүний эрхийг дээдлэх үзэл санааны түүхэн уламжлалын нөлөөн дор шинэ ардчилсан Үндсэн хуулийн үзэл баримтлал бүрэлдсэн. Ардчилсан үндсэн хуулийн үзэл санаа нь 1920-1923 оны хооронд үүсэж, 1924- 1990 оны хооронд тасалдаж, эргээд 1990 оноос дахин сэргэсэн гэж ангилсан байна. Ардчилсан үндсэн хуулийн үзэл баримтлалыг зохиогч 1990-ээд онд хувьсгалаар огцом үүсэж бүрэлдээгүй, 1911 онд Богд хаант засгаа тунхагласны дараахнаас эхэлж, хувьслаар хуримталж төлөвшөөд дахин сэргэсэн гэж үзжээ.” Ерөнхий сайдын даалгавраар Цэвээн Жамсранов барууны ардчилсан улс орнуудын төрийн байгуулал, үндсэн хуулийн талаар судалж, “Улсын эрх” судалгааны тайлан бичсэн нь үндсэн хуульт ёсны үзэл санаа төлөвших эхлэл байсан. Түүнчлэн 1914 оноос Улсын Дээд, доод Хурал байгуулан ажиллаж эхэлсэн, 1921 онд “Үндсэн цааз дүрэм” тогтоолгохоор зарлан тунхагласан, 1922 онд Үндсэн хууль боловсруулах комисс байгуулсан, АНУ, Англи, Бельги, Голланд, Япон, ЗОУ-ын үндсэн хуулийг орчуулах зэрэг ажил хийж байсан нь зохиогчийн томъёолсноор үндэсний ардчилсан ухамсар буюу ардчилсан үндсэн хуулийн үзэл санаа төлөвшиж эхэлж байсныг харуулна. Харамсалтай нь геолитик, улс төрийн нөлөөн дор тухайн үеийн төр, нийгмийн зүтгэлтнүүдийн санаачилга тасалдахад хүрсэн билээ.

1924, 1940, 1960 оны Үндсэн хуулийн үйлчлэлийн хугацаанд ардчилсан үзэл санаа тасалдсан. 1924 оны Үндсэн хууль батлагдсанаар хэмжээт цаазат хаант засгаас бүгд найрамдах засагт шилжиж, шашны төрд үзүүлэх нөлөөг бууруулсан боловч нэг намын хэмжээгүй засаглал бүрдэх үндэс болсон. Нам ард түмнийг төлөөлж, тэдний өмнөөс шийдвэр гаргах замаар нийгмийг журамд хүргэнэ гэсэн үзэл санаанд тулгуурлаж байв. Нийгэм журмыг эрмэлзэх зорилго нь үе шаттайгаар намд төрийн эрх мэдлийг төвлөрүүлэх явдлыг зөвтгөх үндэслэл болсон. Гэхдээ энэ нь монголчуудын өөрсдийнх нь хүсэл зориг байгаагүй гэдэг нь 1924 оны 5 дугаар сард үндсэн хуулийн төсөл боловсруулах өөр комиссыг Коминтерны шууд оролцоотойгоор Зөвлөлт Оросын Үндсэн хуулийн хуулбарлаж, гурван сарын дотор боловсруулж баталснаас харагддаг. Дээрх 3 Үндсэн хуулийг Б.Чимид “... өмнөх үндсэн хуулиуд нь ХХ зууны эхээр үүсэж төлөвшин аядаж байсан Үндсэн хуулийн үндэсний ардчилсан үзэл баримтлалыг таслан хаажээ” хэмээн тодорхойлсон байдаг.

1990-ээд оны ардчилсан хувьсгалаар ардчилсан үндсэн хуулийн үзэл баримтлал дахин сэргэж, шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлал бүрэлдэн төлөвших үйл явц эхэлсэн. Монгол Улсын шинэ ардчилсан Үндсэн хуулийн үзэл баримтлал бүрэлдэн тогтоход нөлөөлсөн хүчин зүйлс нь бусад пост-социалист улс орнуудаас ялгаатай байсан ч нийтлэг төсөөтэй тал их байсан. Ардчилсан Үндсэн хууль руу шилжих шилжилтийн эхэн үед зүүн Европын улс орнуудад үзэгдсэн нэг нийтлэг асуудал нь социалист дэглэмд шилжихийн өмнөх үеийн талцал, хуваагдал, үндэстэн, ястан, шашин, соёлын зөрөлдөөн дахин сөхөгдөж эхлэх явдал байв.

Үндсэн хуулийн үзэл баримтлал бүрэлдэхэд бусад улсын шилдэг жишиг, сайн сургамж, нийтлэг үнэт зүйлсийг харгалзан үзсэн боловч шууд хуулбарлаагүй, бурханчлан дагалгүйгээр үндэснийхээ нөөц чадавхад түшиглэсэн Үндсэн хуулийн үзэл баримтлалыг боловсруулжээ. Эхлээд өөрсдийн чадавхад тулгуурлан судалж, Үндсэн хуулийн төслөө бүрэн боловсруулсны дараа уг төсөл дээрээ бусдын санаа, зөвлөмжийг сонсож эхэлсэн байдаг. 1991 онд 86 хоног хэвлэл мэдээллийн боломжит бүх хэрэгсэл, хурал, цуглааны хэлбэрээр явуулсан хэлэлцүүлэгт сонгогчдын 75 орчим хувь буюу 900 гаруй мянган хүн оролцож 200 гаруй мянган санал ирүүлсэн байна.<sup>43</sup> Хэлэлцүүлгийн явцад ард түмнээс ирүүлсэн

10 Д.Гангабаатар “Шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлал бүрэлдэн тогтсон тухайд” илтгэл, БЯРААГИЙН ЧИМИДИЙН УНШЛАГА ҮНДСЭН ХУУЛИЙГ ДЭЭДЛЭН ШҮТЭХ ЁС Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газар, 2024

саналын 44.3 хувийг нь ямар нэг байдлаар тусгасан байна. Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлал бол орчин үеийн Үндсэн хуулийн үзэл санаа, онолд тулгуурлан, өмнөх үеийн Монголын төрт ёсны түүхэн хөгжил, Үндсэн хуулийн түүхэн сургамж, уламжлал шинэчлэлийг харгалзан бүтээгдсэн хэмээн дүгнэжээ.

О.Мөнхсайханы “Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс” илтгэл<sup>11</sup> Үндсэн хуульд ардчилсан нийгэмд хүмүүс, нийгэмшлийн бүлгүүд өөрсдийн итгэл үнэмшилтэй байж, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэхийг хүлээн зөвшөөрдөг учраас улс төрийн плюрализм буюу ургалч үзэл нь уг нийгмийн салшгүй шинж. Монгол Улсын Үндсэн хуулийн оршилд манай ард түмний туйлын хүслэнг дараах томъёоллоор илэрхийлэн бататгасан. Үүнд,

Монголын ард түмэн бид:

- улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж,
- хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж,
- төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, -хүн төрөлхтөний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж,
- эх орондоо хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно. Үүний учир Монгол Улсын Үндсэн хуулийг даяар олноо зарлан тунхаглаж байна.

Үндсэн хуулийн оршилд зарлан тунхагласан “иргэний нийгэм”-ийг “амьдралын гүнд байсаар ирсэн төр, нийгмийн зөв оршихуйн үндэс” гэдэг талаас нь цухас тодорхойлжээ: “Иргэний нийгэм нь засаг төрийн байгууллагын эх үүсвэр байж, үйл ажиллагаанд хяналт тавьж, түүнийг өөрсдөдөө үйлчилдэг “зарц” болгож чадсан тийм ардчилсан цогц тогтолцоо болгон төлөвшүүлж, бэхжүүлэхийг л “цогцлуулан хөгжүүлэх” гэсэн нэр томъёогоор ард түмэн эрхэм зорилгоо болгожээ...” Иймээс, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл нь иргэний нийгэмд хүчин зүтгэнэ. Өөрөөр хэлбэл, төрийн албан хаагч хэн боловч “... “би хүмүүсийг захирч байна” гэж ойлгож ихэмсэг, дээрэлхүү, “цэвдэг хүйтэн” хандах биш, харин “тэдэнд үйлчилж, тусалж байна” гэж өгөөмөр сэтгэж дадахыг, өөрөөр хэлбэл урьдын захиргаадалтын арга барилаа үндсээр нь эргүүлэн энэрэнгүйжүүлэх буюу хүмүүнлэгжүүлэх нь төрийн албаны ёс зүй нийгмийн сэтгэл зүйн шинэтгэл болох ёстой” гэжээ.

Эндээс харвал **хүмүүнлэг** гэдэг нь хүнийг хүн гэдгээр хүлээн зөвшөөрч хүн гэж хүндэтгэх утгатай байна. Иймд Үндсэн хуулийн оршилд зарлан тунхагласан хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэх гэдэг бол Монгол Улсад хүн бүрийг хүн гэж хүлээн зөвшөөрч, хүний ёсоор хүндэтгэх (хүний нэр төр буюу “human dignity”-ийг хүндэтгэх) болон үндсэн эрхийг нь баталгаатай эдлүүлэхийг төрд үүрэгжүүлсэн, улмаар төрийн эрх мэдэл иргэдээс эх үүсвэртэй байж, иргэдийн хяналт дор хэрэгжиж, иргэдэд үйлчилдэг, ардчилсан дэглэм бүхий цогц тогтолцоог төлөвшүүлж бэхжүүлэх эрхэм зорилго юм.

Үндсэн хууль бол “ард түмний сонголт, хамтын бүтээл” гэдгийг боловсруулж баталсан үйл явцыг тоймлон харуулж, энэхүү “төрөлх” чанараараа “Монгол Улсын Үндсэн хууль бол манай ард түмний нийтээрээ дээдлэн шүтэж, ёсчлон сахих нийгэм, сэтгэл зүйн гүн үндэстэй” бөгөөд “түүнийг үеэс үед залгамжлан дээдэлж хэвшүүлбээс нэгэн зүйл үндэсний бахархал болно” гэжээ.

О.Мөнхсайхан бичихдээ, Үндсэн хуульд ардчилал нь оршин тогтноход төрийн эрх мэдэл хуваарилалт, хяналт, тэнцлийн нарийн тогтолцоо шаардлагатайгаас гадна түүнийг ойлгож дэмждэг итгэл үнэмшил, соёл, хандлага нэн чухал. Ардчиллыг иргэдийн олонх дэмжиж байгаа тохиолдолд л ардчилал урт хугацаанд тогтвортой, аюулгүй хэрэгжих боломжтой. Улс төрийн философич Жон Роулс ардчилсан нийгмийн талаарх хэд хэдэн фактыг танилцуулсны нэг нь: “улс төрийн идэвхтэй иргэдийн дийлэнх нь ардчилсан дэглэмийг сайн дураараа, чөлөөтэй дэмжих ёстой; үгүй бол тухайн дэглэм тогтвортой байж

11 О.Мөнхсайхан “Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс” илтгэл, БЯРААГИЙН ЧИМИДИЙН УНШЛАГА ҮНДСЭН ХУУЛИЙГ ДЭЭДЛЭН ШҮТЭХ ЁС Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газар, 2024.

чадахгүй.”<sup>12</sup> гэжээ.

Үндсэн хууль, ардчилал, хүний эрхийн боловсролын агуулга тодорхой хэмжээнд Ерөнхий боловсролын сургууль (цаашид “ЕБС” гэх)-ийн Түүх, Нийгмийн тухай мэдлэг, Иргэний боловсрол зэрэг хичээлийн хөтөлбөрт тусгагдаж ирсэн боловч агуулга, арга зүйн хувьд учир дутагдалтай. Жишээлбэл, Иргэний боловсрол, Иргэний ёс зүйн боловсрол хичээлүүдийн сурах бичгийн хүрээнд хийгдсэн хэд хэдэн судалгаанд “уг хичээлийн агуулгыг харвал ардчиллын үнэт зүйл, зарчмын талаарх агуулга дутмаг,” “иргэний ёс зүйн боловсрол сурах бичиг нь ёс суртахууны философийн өнөөгийн түвшинд нийцэхгүй төдийгүй ардчилсан улсын улс төрийн үнэт зүйл эзэмшүүлэхэд чиглэсэн агуулга хангалтгүй” гэж дүгнэжээ. Энэ хичээлийн сурах бичигт “хүний эрхэм чанар, хүний эрх, эрх чөлөө, ардчилал, тэгш байдал, хууль дээдлэх ёс зэрэг боловсролын сууринд байх ёстой эрхэмнэлүүдтэй холбох, агуулгад тусгах шаардлагатай.” Сурагчид либерал ардчилалд суралцах, түүний суурь зарчим, үнэт зүйлийн дагуу орчин үеийн улс төрийн асуудлыг хэлэлцэж дүгнэлт өгөх, үндэслэл бүхий шийдвэр гаргах чадвараа хөгжүүлэх боломж албан боловсролын тогтолцоонд хязгаарлагдмал байгааг хичээлийн хөтөлбөр, агуулгаас харж болно хэмээн онцолсон байна.

Боловсрол судлаачид 2011 онд Монгол улсын Үндсэн хуулиар баталгаажсан үнэт зүйлсийн цогцыг иргэний боловсролын агуулгад хэрхэн тусгаж буулгаж болохыг боловсролын агуулгыг тодорхойлох үндсэн хэмжигдэхүүн болох мэдлэг, чадвар, хандлагын багц үзүүлэлтээр тодорхойлох оролдлогыг хийж байжээ.

**Хүснэгт 2. Монгол улсын Үндсэн хуулийн үнэт зүйлс боловсролын агуулгад<sup>13</sup>**

Үнэт зүйлийн агуулга			
	Мэдлэг	Чадвар	Үнэлэмж, хандлага
Хүний эрх, эрх чөлөө	Хүний эрх ба үүргийн тухай ойлголт (хүний эрхийн ангилал, зарчим, үүрэг) Хувийн ба хамтын эрх Хүний эрхийн тодорхой хязгаарлалт, хариуцлага	Өөрийн эрхийг мэдэх, эдлэх, бусдаас шаардах Бусдын эрхийг хүндэтгэх, үүргээ биелүүлэх, Хуулийн дагуу эрхээ хамгаалах, зөрчигдсэн эрхээ сэргээх, түүний хамгаалалтын механизм	Хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн дээдлэх Хүний эрхийн зөрчлийг үл тэвчих
Бүрэн эрхт байдал	Монгол улсын бэлгэ тэмдэг Монгол улсын хил Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарь Монгол улсын эдийн засгийн болон өмчийн харилцаа	Монгол улсын төрийн бүрэн эрхт байдлын үндсийг тодорхойлох Төрийн бэлгэ тэмдэг, тайлбарлах Бэлгэ тэмдгийг зөв хэрэглэх	Эх орны бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолоор бахархах, бусад улсын бүрэн тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх
Эрх зүйт ёс	Иргэн, төрийн тэгш харилцаа Үндсэн хууль, хуулийг дээдлэх зарчим, үнэт зүйлс Эрх мэдлийн хуваарилалт Төрийн байгуулал, тэдгээрийн эрх зүйн үндэс, төрийн эрх мэдлийн хязгаарлалт	Иргэний эрхийг хамгаалсан Үндсэн хуулийн хамгаалалтыг тайлбарлах, өөрийгөө тайлбарлах Төрийн үйл ажиллагаа нь хуулийн хүрээнд байх, иргэд нь хуулийн өмнө адил тэгш эрхтэй болохыг ойлгох Төртэй тэгш эрхтэй харилцаж, түүний үйлчилгээг авч сурах	Хүн бүр эрх зүйн этгээд байж, улмаар хууль, шүүхийн өмнө эрх тэгш гэдгийг хүлээн зөвшөөрөх Төр нь Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх ёстойд итгэж үнэмших

12 “Үндсэн хууль манай сургуульд” (НУБ-ын Хүний эрхийн хороодын ерөнхий тайлбар болон сургалтын хөтөлбөр), МУИС Үндсэн хуулийн эрхзүйн хүрээлэн, 2022 он

13 ЕБС-ийн Иргэний боловсролын агуулгад хийсэн үнэлгээ, мониторинг, ННФ, 2011 он

Ардчилал	Ардчиллын үнэт зүйлс, тэгш эрх, шударга ёс, иргэдийн оролцоо, сонгууль, ил тод байдал, тайлагнах  Хэл соёл, уламжлал, ёс заншил, шашин шүтлэг, Нүүдлийн соёл, иргэншил, Эрдэм ухаан, түүх соёлын дурсгалт зүйлс	Сонгуульд оролцох Үзэл бодлоо илэрхийлэх Эвлэлдэн нэгдэх Шийдвэр гаргах үйл явцад зохистой хэлбэрээр оролцох Эцэг эх, ахмад хүмүүсийг хүндэтгэн харилцах Байгаль орчинд ээлтэй амьдрах, хамгаалах	Ардчиллын үнэт зүйлд итгэж үнэмших, түүнийг үйл ажиллагааныхаа хэм хэмжээ болгох Үндэсний соёл, иргэншил, ахуйн хэв маягийг хүндэтгэх, хамгаалах Үндэсний дэвшилтэт уламжлалыг өвлөх Бусдын шашин шүтлэг, соёлд хүндэтгэлтэй хандах
----------	---	--	--

“Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл 2023 онд Монгол улсын Хүний эрхийн үндэсний комиссын захиалгаар “Иргэний ёс зүйн хичээлийн 6-12-р ангийн сурах бичигт хүний эрх, жендэрийн дүн шинжилгээ”-г хийж гүйцэтгэсэн. Уг дүн шинжилгээний явцад “Иргэний ёс зүйн боловсрол” хичээлийн сурах бичиг нь дэлхийн иргэний боловсролын агуулгыг хангалттай тусгаагүй нь илэрсэн бөгөөд одоо хэрэглэгдэж буй сурах бичгийг эргүүлэн татаж, “Сургалтын хөтөлбөрийн шинэчлэл”-ийн хүрээнд дэлхийн иргэний боловсролын агуулгаар шинэчлэн боловсруулах хэрэгцээ шаардлага үүссэн болохыг дахин сануулсан юм.

“Иргэний ёс зүйн хичээлийн 6-12-р ангийн сурах бичигт хүний эрх, жендэрийн дүн шинжилгээ” -нд дараах анхаарал татсан дүгнэлтүүдийг хийсэн байна. Үүнд,

- Иргэний ёс зүйн боловсрол хичээлийн сурах бичиг, сургалтын хөтөлбөрийн агуулгад буддын шашны агуулга анги ахих тусам өргөжин, суралцагчийн нас, сэтгэхүйн онцлогт нийцээгүй буддын философийн онолын нэр томъёог ашиглаж, сургаалыг номлосон нь Хүүхдийн эрхийн тухай конвенцийн “оролцогч улсууд хүүхдийн, түүний эцэг, эх буюу хууль ёсны асран хамгаалагчийг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэс, угсаа, нийгмийн гарал, эд хөрөнгө, эрүүл мэнд, төрсөн болон бусад байдлаас үл шалтгаалан аливаа хэлбэрээр алагчилахгүй энэхүү Конвенцид заасан бүх эрхийг харьяалалдаа байгаа хүүхэд бүрийн хувьд хүндэтгэн хангана.” ИБУТЭТОУП-ын 18.4-р зүйлийн “Энэхүү пактад оролцогч улс эцэг эхийн болон зохих тохиолдолд хууль ёсны асран хамгаалагчдын үр хүүхдэдээ хувийн үзэл итгэлийнхээ дагуу шашны болон ёс суртахууны хүмүүжил олгох эрх чөлөөг хүндэтгэх үүрэг хүлээнэ”, Монгол Улсын Үндсэн хуулийн 9.2-т “төрийн байгууллага шашны ... үйл ажиллагаа эрхлэн явуулж болохгүй,” 16.15, 16.6-д Монгол улсын иргэн бүр “шашин шүтэх, эс шүтэх,” “итгэл үнэмшилтэй байх” эрх чөлөөтэй, 14.1-т хүн бүр “хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна,” 14.2-т “Хүнийг ... шашин шүтлэг ...оор нь ялгаварлан гадуурхаж үл болно,” 1.2-т “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зөрчим мөн” зэргийг зөрчсөн явдал мөн. Улсын сургуульд шашны ерөнхий түүх, ёс зүй зэрэг хичээлийг төвийг сахисан, бодит, шүүмжлэлт, олон ургальч байдлаар заахыг зарим улс орнууд зөвшөөрдөг байна. Учир нь эцэг эх, асран хамгаалагч нь хүүхдээ өөрийн итгэл үнэмшлийн дагуу шашин, ёс суртахууны боловсрол эзэмшүүлэх эрх чөлөөтэй байх эрхийн баталгаатай шууд холбоотой. Эцэг эх, асран хамгаалагчийн хүсэлд нийцсэн ялгаварлан гадуурхахгүй, чөлөөт бусад хувилбаруудыг тусгаагүй бол тодорхой шашин, итгэл үнэмшлийн талаарх сургалтын хөтөлбөрийг багтаасан нийтийн боловсрол нь ИБУТЭОУП-ын 18.4-т нийцдэггүй байна. Ёс зүйн боловсролыг шашны боловсролтой хэрхэн холбох ба зааглах тухай асуудал бол аливаа улс орны ёс зүйн боловсролын бодлого дахь тулгамдсан асуудлын нэг.
- Иргэний ёс зүйн боловсрол хичээлийн хөтөлбөр, сурах бичгийн агуулга нь Монголын үндэсний амин чанар -ыг Чингис хаан, буддын шашин хэмээн хэт явцууруулж дүрсэлжээ. Уламжлалт баяр ёслол (наадам, цагаан сар, шагай наадаан, сур харваа, морь уралдаан болон бусад баяр ёслол, тоглоом

наадгайг сурагчдын өдөр тутмын үйл ажиллагаагаар дамжуулан орчин үежүүлж, тайлбарлаж, турших боломжийг олгосон бүтээлч даалгавар дутмаг), бичиг үсгийн соёл (хадны сүг зургаас эхлээд дөрвөлжин, соёмбо, монгол бичиг, крилл бичигт хэрхэн шилжсэн зэрэг үүх түүх, хэрэглээнд нийцсэн бүтээлч даалгавар дутмаг), шашин хоорондын ойлголцол найрслын гайхалтай түүх (Хархорин хотод олон шашны сүм хийдүүд байсан, өөр хоорондоо найрсан ойлголцож аж төрдөг байсан, шашны эх зохиолуудыг монгол хэлээр орчуулж таниулж байсан зэрэг), монгол аж төрөх ёс, монгол гэрийн уламжлал, хэв маяг, хэлбэрүүдийг орчин цагийн соёлын агуулгад нийцүүлж уламжлалыг оруулахаас илүүтэй анги бүрт Чингис хаантай холбоотой түүхэн агуулга багтаасан нь сурагчдын эрэлт хэрэгцээнд нийцээгүй (Монголын түүх хичээлийн агуулгатай давхцсан) байна.

- Гэр бүл төлөвлөлт, хувь хүний ёс суртахууны үнэт зүйлс, нийгмийн үнэт зүйлстэй уялдан хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлыг агуулсан хичээлийн агуулга, арга зүй, даалгаврууд хомс, сурагчдын бүтээлч сэтгэлгээ, шүүн тунгаах сэтгэлгээг тэлсэн, сорьсон, оролцоог хангасан дасгал, даалгавар дутагдалтай болсон нь уг хичээлийн ач холбогдлыг багасгах, үгүйсгэх эрсдэлийг дагуулж байгаа онцолж байна.
- 6-12 дугаар ангийн Иргэний ёс зүйн боловсрол хичээлийн сурах бичиг нь ардчилал, хүний эрх, иргэний оролцоо, жендэрийн олон талт байдал болон соёлын олон янзат байдлын талаарх агуулга хангалтгүй.
- Иргэний ёс зүйн боловсрол сурах бичигт текст болон зураглалын хувьд жендэрийн тэгш байдал хангалттай биш. Зурган дүрслэлийн 60-70 хувийг эрэгтэй дүр эзэлж байсан бол эмэгтэй дүр 30-40 хувийг эзэлж байна. Текстийн хувьд ялгаагүй эрэгтэй дүр, эрэгтэй тайлбар дийлэнх хувийг эзэлсэн хэвээр байна. Эрэгтэй хүн, эрэгтэй хүүхдийг ухаалаг, тууштай, хөдөлмөрч байдлаар дүрсэлсэн бол эмэгтэй хүн, охин хүүхдийг халамжлагч, уян зөөлөн сэтгэлтэй гэсэн жендэрийн хэвшмэл байдлаар дүрсэлжээ. Зурган дүрслэлүүдийн хувьд тодорхой жишээгээр эрэгтэй, эмэгтэй аль аль дүрийг хамтад нь оруулж дүрслэх оролдлого гарсан боловч хангалттай байж чадсангүй. Эрдэмтэн, тэмцэгч, баатар, түүхэн дүрүүдэд эрэгтэй дүрүүдийг ашигласан нь эмэгтэй хүмүүс түүхэн үйл явдал, шинжлэх ухааны нээлт, утга уран зохиолд байр суурь эзэлж байгаагүй мэт “үл ухамсарласан өрөөсгөл” хандлагаар бичсэн.
- Нийгмийн цөөнх, ялгаатай бүлгүүдийг огт дүрслээгүй бөгөөд хөгжлийн бэрхшээл, үндэс угсаа, жендэр, бэлгийн цөөнх бүлгийг дүрсэлсэн зураглал, текст, жишээ байхгүй.
- Жендерийн эрх тэгш байдлын тухай хуулийн 12.5-д “Ерөнхий боловсролын сургууль, сургалтын бусад байгууллагад хэрэглэдэг ном, сурах бичиг болон сургалтын хэрэглэгдэхүүн нь жендерийн эрх тэгш байдлыг үгүйсгэсэн агуулгатай байж үл болно.” гэсэн заалт бий. Харамсалтай нь сурах бичигт “Манай ард түмэн ямар хөвгүүн, охиныг сайн эсвэл муу хэмээн үздэг байсан бэ?”, “Тоть шувууны сургааль” дахь Эрхэм сайн хөвгүүний ёс, үүрд муу хөвгүүний ёс, сайн охины ёсон, асар муу охины ёсон хүйсийн хэвшмэл байдлыг тодотгон дүрсэлж, хөвгүүнийг ухаалаг, эрдэм номд шамдах ёстой харин охидыг сайн сайхан гоо зүстэй, уян зөөлөн, номхон дөлгөөн байх хэрэгтэй зэргээр илэрхийлсэн. Зурган дүрслэлд “хөвгүүд өөр хоорондоо зодолдож байгаа”, “ээж нь хүүхдээ загнаж байгаа”, “эмэгтэй хүүхэд хов ярьж байгаа”, “эрэгтэй дүр нохой зодох, охин дээрэлхэх, чавхаар шувуу харвах, бусдын эд зүйл сүйтгэх гэх мэт эрэгтэй, эмэгтэй хүний талаарх жендерийн хэвшмэл ойлголтыг бэхжүүлдэг хандлага илт тодорхой дүрслэгдсэн нь Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийг зөрчсөн хэмээн үзэж байна. Мөн мэргэжлүүдийг илэрхийлсэн зураг, дүрслэл нь эмч, багш- эмэгтэй, цагдаа- эрэгтэй гэсэн жендерийн хэвшмэл байдлаар дүрслэгдсэн хэвээр байна.
- Иймээс Иргэний ёс зүйн боловсрол хичээлийн хөтөлбөр, сурах бичгийг албан боловсролын тогтолцооноос нэн даруй татаж, тус хичээлийн агуулгыг шинэчлэн боловсруулах шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрсэн байна.

Хүүхдийг бие хүн болгон төлөвшүүлэх, нийгэмшүүлэхэд зайлшгүй шаардлагатай иргэний боловсрол, эрүүл мэнд, бэлгийн боловсрол, амьдрах ухааны гэх мэт хичээлүүдийн хөтөлбөр хангалттай сайн боловсруулагдаагүй, багш нарт энэ чиглэлээр зайлшгүй байвал зохих ур чадвар суралцаагүй байна.

Иргэний ёс зүйн боловсролыг бүхэлд нь монгол өв соёл, уламжлал, заншил, буддын мэдлэг ухаанаар тодорхойлон гаргасан нь агуулга болон арга зүйн хувьд алдаатай болжээ<sup>14</sup>. Одоо мөрдөгдөж байгаа сургалтын цөм хөтөлбөрт нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн цогц боловсролын агуулга хангалтгүй тусч, товч мэдлэг олгохоор хязгаарлагдсан бөгөөд хувь хүнд хэрэгтэй ур чадвар, зан үйл, нийгэм соёлын харилцааны асуудлууд<sup>15</sup> орхигдсон гэж бусад судлаачид, иргэний нийгмийн байгууллагууд мөн үзсэн байдаг.

Төрийн болон бусад байгууллага, хувь хүн иргэний боловсролыг дэмжих чиглэлд албан бусаар олон арга хэмжээ авч хэрэгжүүлж ирсэн. Тухайлбал, иргэний боловсролын хөтөлбөрийг сайжруулах, сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах, ЕБС, их дээд сургуулийн багш нарын иргэний боловсролын мэдлэг, арга зүйг дээшлүүлэх чиглэлээр “Иргэний боловсрол төв” ТББ 30 гаруй жил ажиллаж байна. “Нээлттэй нийгэм форум” ТББ ч энэ чиглэлд 20 гаран жил хөтөлбөр хэрэгжүүлж ирсэн. Мөн, сүүлийн жилүүдэд УИХ-ын Тамгын газар “Парламентын боловсрол” төсөл хэрэгжүүлж энэ чиглэлийн видео, гарын авлага, сургалтын хөтөлбөр гарган түгээж байна. Олон төрлийн ном, сурах бичиг, гарын авлага сайн дураар хэвлэгджээ. Түүнчлэн, 2022 онд МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн Үндсэн хуулийн мэдлэг, хүний эрхийн боловсрол олгох зорилготой “Үндсэн хууль манай сургуульд” төсөл хэрэгжүүлж, 8 сэдвээр сургалтын хөтөлбөр, материал боловсруулж, ахлах ангийн сурагчид, оюутнууд болон иргэдэд сургалт орж байна. Харамсалтай нь, ардчиллын боловсролын энэ бүх санаачилга ЕБС-ийн албан ёсны хөтөлбөр, сурах бичиг, багшлах боловсон хүчний бодлого руу хангалттай хүрч, бүрэн тусаж чадалгүй өдий хүрчээ.

Онцлох эх сурвалжуудыг нэрлэвэл,

- Ерөнхий боловсролын сургуулийн иргэний боловсролын сургалтад хийсэн үнэлгээ, мониторинг, ННФ, 2011 он
- “Ерөнхий боловсролын сургуулийн Иргэний боловсролын сургалтын хөтөлбөр, түүний хэрэгжилт” Судалгааны тайлан, Иргэний боловсролын төв, НҮБХХ, 2012 он
- Education for Democracy: Curriculum Framework, Community of Democracies, 2013
- “Ардчиллын боловсрол” Сургалтын хөтөлбөр, МУБИС ба ИБТ, 2014 он
- “Global Citizenship Education Topics and Learning objectives”, UNESCO, 2015 (Орчуулга)
- “Дэлхийн иргэний боловсрол: мониторингийн тайлан”, Боловсролын хүрээлэн, 2017 он
- Global Citizenship Concepts in the Curricula of Four Countries, UNESCO IBE, APCEIU, 2017
- “Шударга ёсны боловсрол”, ЭЗХАХБ, 2018 он
- “Ардчилсан боловсрол, иргэний оролцооны талаарх агуулгад хийсэн дүн шинжилгээ”, Хүүхдийг ивээх сан, 2020 он,
- “Ардчиллын тухай өсвөр үеийнхний төсөөлөл” Судалгааны тайлан, Хүүхдийг ивээх сан, 2020 он
- “Ардчиллын үнэт зүйлс” Сургалтын дэлгэрэнгүй хөтөлбөр, Хүүхдийг ивээх сан, НҮБ-ын Ардчиллын сан, 2021 он
- “Парламентын боловсрол” гарын авлага, УИХ-ын Тамгын газар, ШХА, 2021 он
- Бодолтой, ойлгож мэдэрдэг, хэрэгжүүлдэг Дэлхийн иргэн болцгооё, Сурагчдад зориулсан ажлын дэвтэр, APCEIU, MOE of the Republic of Korea, 2021 (Орчуулга)
- “Үндсэн хууль Манай сургуульд” Сургалтын хөтөлбөр, МУИС, Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн, 2022 он

Монгол улс 2020-2023 онд Боловсролын хуулийн шинэчлэлийг хийхдээ боловсролын оролцогч талуудтай зөвшилцөж, олон талын оролцоотой боловсруулан баталсан сайн туршлагатай. УИХ-аар 2023 оны 7 сарын 9-нд батлагдсан Боловсролын тухай багц хуулиар “Монгол Улсын боловсролын зорилго нь хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, насан туршдаа суралцаж, ажиллах, ёс суртахуунтай, сайн зан чанартай иргэнийг төлөвшүүлэхэд оршино” гэжээ. Улмаар боловсрол бол улс орны хөгжлийн тэргүүлэх салбар гэдгийг хүлээн зөвшөөрч, бодлого, үйл ажиллагаандаа баримтлах үндсэн зарчмыг:

14 “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөр, агуулгад хийсэн шүүмжлэлт зарим эргэцүүлэл”, М.Отгонбаяр, Б.Дагзмаа, МУИС, 2022 он

15 Бэлгийн цогц боловсрол: Нотолгоонд суурилсан нөлөөллийн баримт бичиг, МОНФЕМНЕТ үндэсний сүлжээ, 2016 он

- үндэсний болон хүн төрөлхтний нийтлэг соёл, үнэт зүйл, өв уламжлал, шинжлэх ухааны дэвшилтэт чиг хандлагад тулгуурласан байх;
- тэгш хүртээмжтэй, ялгаварлан гадуурхахгүй, нээлттэй байх;
- насан туршийн суралцахуйг дэмжсэн байх;
- улс төр, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
- хүний эрх, эрх чөлөө, төрт ёс, түүх, соёлын уламжлал, үнэт зүйлсийг нандигнан өвлөсөн, ардчилсан, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахисан байх зэргээр тодорхойлжээ.

Улмаар бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт заавал тусгах агуулгыг батлахдаа,

- хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйл;
- хүний эрхийн боловсрол, жендэрийн эрх тэгш байдал;
- иргэний ёс зүйн болон зан төлөвийн боловсрол;
- эрүүл мэндийн боловсрол;
- хүмүүнлэг иргэн, тогтвортой хөгжлийн боловсрол тусгасан нь Дэлхийн иргэний боловсролын хууль, эрхзүйн орчныг баталгаажуулсан явдал байлаа.

Монгол Улсын Үндсэн хуульд хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгосон бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 7-д Монгол Улсын иргэний “сурч боловсрох эрх”-ийг баталгаажуулан хуульчилсан. Түүнчлэн, 2015 онд Нэгдсэн Үндэстний байгууллагын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулганаар хэлэлцэж баталсан “Тогтвортой хөгжлийн зорилго-2030” хөтөлбөрт “Бүх түвшинд эрх тэгш, тэгш хамруулсан, чанартай боловсрол олгох, бүх нийтийн насан туршдаа суралцах боломжийг дэмжих” зорилгыг боловсролын салбарт дэвшүүлжээ.

Хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийн нэг чухал хэмжээс нь хүний хөгжил бөгөөд улс орны засаглал, нийгэм, эдийн засгийн хөгжлийн гол цөм, хөдөлгөгч хүч нь болохын хувьд Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ыг баталж, хүн төвтэй хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд энэ бодлогын 2.1-д “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ” гэсэн зорилтыг дэвшүүлсэн байна.

Боловсролын хуулийн шинэчлэлийн хүрээнд батлагдсан Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд “Сургалтын хөтөлбөр нь үзэл баримтлалтай байна” гэж зааж, түүнийг Боловсролын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлж, Засгийн газар батлахаар хуульчилсан нь сургалтын хөтөлбөрийн чанар, тогтвортой байдлыг хангах эрх зүйн нэн чухал зохицуулалт болсон. Улмаар Засгийн Газрын 2024 оны 04 сарын 24 өдрийн Дугаар 176 тушаалаар Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал” батлагдаж, үүнд үндэслэн сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаа эхэлсэн билээ.

### **Сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд монгол суралцагчийн эзэмших чадамжийг дараах байдлаар тодорхойлжээ.**

Сургалтын хөтөлбөрөөр сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын зорилгод нийцсэн мэдлэг, чадвар, хандлага, төлөвшлийн цогц чадамжийг Монгол суралцагчид эзэмшүүлэх бөгөөд чадамж нь дараах суурь болон ерөнхий чадамжаас бүрдэнэ.

<b>Суурь чадамж</b>	<ul style="list-style-type: none"><li>- Эх хэл, бичиг үсэг</li><li>- Математик</li><li>- Шинжлэх ухаан (байгалийн ба нийгмийн)</li><li>- Компьютерын ухаан ба цахим технологи</li><li>- Англи хэл болон бусад гадаад хэл</li><li>- Биеийн болон сэтгэл зүйн эрүүл мэнд, сайн сайхан байдал</li></ul>
<b>Ерөнхий чадамж</b>	<ul style="list-style-type: none"><li>- Бүтээлчээр, шүүн тунгаах сэтгэлгээ</li><li>- Суралцах арга барил</li><li>- Харилцаа, хамтын ажиллагаа</li><li>- Нийгэм, сэтгэл хөдлөлийн хөгжил</li><li>- Тогтвортой хөгжил</li><li>- Үндэсний болон дэлхийн өв соёл</li></ul>



### БҮЛЭГ 3.

**ДЭЛХИЙН ИРГЭНИЙ БОЛОВСРОЛ:  
БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭЛТ,  
САЙН ТУРШЛАГУУД**

## **БҮЛЭГ 3.**

# **ДЭЛХИЙН ИРГЭНИЙ БОЛОВСРОЛ: БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭЛТ, САЙН ТУРШЛАГУУД**

Дэлхийн иргэний боловсролын талаарх бодлого гэдэг нь сургалтын хөтөлбөр, заах арга зүй, багш бэлтгэх болон багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтууд, үнэлгээний аргад бүхэлд нь шингээх стратеги төлөвлөгөө байдаг. Дэлхийн иргэний боловсролын талаарх бодлого нь албан сургалтаас гадна бүх шатны, бүх төрлийн суралцахуйн үйл явцыг хүлээн зөвшөөрч, дэмждэгээрээ онцлогтой. Монгол улс сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд судлагдахуун тус бүрт ДИБ-ын агуулга, арга зүйг тусгах нь Үндсэн хуулийн “хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгмийг цогцлоох” үндэс суурь болох билээ.

### **3.1 Үйл ажиллагааны тэргүүлэх талбар 1: Бодлогын шинжилгээ, боловсруулалт**

Дэлхийн иргэний боловсролын ямар ч бодлого цөмдөө шинэ хэв загвар тогтоох, аль эсвэл суралцагч, багш нарын суралцахуйн үйл явцыг илүү чанартай, өргөн хүрээнд өрнүүлэх замаар өөрчлөлтийг авч ирэх чадамжид суурилсан байдаг. Иймд, шударга ёс, тэгш эрх, эрхэм чанар, тэгш хамруулалт, хүндлэл гэх зэрэг ДИБ-ын үнэт зүйлс нь ДИБ-ын талаарх бодлого боловсруулах үйл явцад ч тусгалаа олсон байх хэрэгтэй бөгөөд энэ нь хамтын ажиллагаанд суурилсан, нээлттэй, төрөл бүрийн үзэл хандлага, түүх замнал, туршлагыг өөртөө багтаана гэсэн үг юм. Ялангуяа залуус, эмэгтэйчүүд, үндэстний болон хэлний цөөнх иргэд, нийгэм эдийн засгийн статус доогуур болон болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэх мэт бодлого боловсруулах үйл явцын гадна үлддэг бүлгийн хүмүүстэй ойр хамтран ажиллах нь зүйтэй. Тэр дундаа залуус ДИБ-ын үнэт зүйлс, үзэл санааг дэмжин дэлгэрүүлэх гол хүч болдог гэдгийг мартаж учиргүй.

ДИБ-ын бодлого боловсруулах үндсэн алхам бол одоо байгаа боловсролын бодлого, зорилт, сургалтын хөтөлбөр ДИБ-ын бодлоготой уялдаж, харилцан бие биенээ дэмжих агуулга байгаа эсэхийг нягтлах. Түүнчлэн одоо байгаа орон нутаг, үндэстний хэмжээний бодлогын хэрэгжилт, нөөц бололцоо, тогтолцоонд ДИБ-ыг дэмжих боломж, механизм байгаа эсэхийг судалж үзэхийг эн тэргүүнд үздэг. Ингэхдээ өнөөгийн үндэстний бодлогын орчны давуу болон сул тал, боломж болон дутагдалтай тал юу вэ гэсэн ерөнхий асуултуудыг чиг болгох зүйтэй.

ДИБ-ын үзэл санааг бодлого, төлөвлөлт, сургалтын хөтөлбөртөө тусган боловсруулсан (Хайрцаг 1-ийг үзнэ үү) бусад орнуудын жишээг үзэж болох бөгөөд тэдний сайн туршлагатай ч мөн танилцах нь зүйтэй.<sup>16</sup>

<sup>16</sup> Global citizenship education: A Guide for Policymakers (2017), UNESCO and APCEIU, p 27

## **Хайрцаг 1. ДИБ-ын үзэл санааг бодлого, төлөвлөлт, сургалтын хөтөлбөртөө багтаасан улс орнуудын жишээ**

Боловсролын талаар баримтлах үндэсний бодлого нь улс орны хэмжээнд энх тайван, харилцан ойлголцлыг дэмждэг бөгөөд ийм бодлого бүхий улс оронд Афганистан, Австрали, Индонез, Малайз, Мьянмар, Балба, Бүгд Найрамдах Солонгос Улс, Шри Ланка, Тайланд зэрэг улс багтаж байна.

<http://unesdoc.unesco.org/images/0022/002272/227208E.pdf>

Колумб улсад иргэний цогц чадамжийг сайжруулахын тулд, мөн зөрчил мөргөлдөөнийг энх тайвнаар шийдвэрлэх, иргэдийн шүүмжлэлт сэтгэлгээ, ёс зүй, хүндлэлт байдлыг дэмжих зорилготойгоор боловсролын талаар баримтлах үндэсний бодлогоо загварчлан боловсруулжээ. Иргэний цогц чадамж нь дөрвөн үндсэн зорилттой, үүнд: иргэний болон хүний эрхийн боловсролыг тогтолцоо, зарчмын тухай ойлголтоор дамжуулан олгох; өөрийн шүүмжит байр суурийг илэрхийлж сурах; үйлдэлдээ хариуцлагатай байх, ардчилсан нийгмийг бүтээхэд өөрийн гэсэн хувь нэмрийг оруулдаг байх; бусадтай энх тайвнаар зэрэгцэн амьдрах зэрэг багтжээ.

<http://evaluacion.educacionbogota.edu.co/>

Австрали улсад Боловсрол, ажил эрхлэлт, сургалт, залуучуудын асуудал эрхэлсэн зөвлөлөөс Залуу Австраличуудад зориулсан Боловсролын зорилт буюу Мелбурны Тунхаглалыг гаргажээ. Энд ДИБ-ын тухай ил тод дурдаагүй боловч улс орон, олон улсын хэмжээнд үйлдэлдээ хариуцлагатай, мэдээлэлд нэвтэрсэн, идэвхтэй иргэдийг төлөвшүүлэхийн ач холбогдлыг тунхагласан байдаг (Мелбурны Тунхаглалыг үзнэ үү.) Түүнчлэн ДИБ-ын агуулгыг анги, сургуулийн орчин, сургалтын хөтөлбөрт нэвтрүүлэх үндсэн чиглэл бий бөгөөд "Олон улсын хандлага: Австралийн сургуулиудын Олон улсын боловсролын үндсэн чиглэл" хэмээх цогц цахим баазтай аж.

[http://www.globaleducation.edu.au/verve/\\_resources/GPS\\_web.pdf](http://www.globaleducation.edu.au/verve/_resources/GPS_web.pdf)

Афганистаны Боловсролын талаар баримтлах Үндэсний Гуравдугаар Стратеги Төлөвлөгөөнд "Афганистаны нийгэм-эдийн засгийн хөгжил, ард түмний нэгдмэл байдлыг хангах үүднээс боловсролын тогтолцоогоор дамжуулан мэдлэг, чадвар бүхий иргэдийг бэлтгэх нь зүйтэй" хэмээн тусгажээ.

[http://planipolis.iiep.unesco.org/sites/planipolis/files/ressources/afghanistan\\_nesp\\_iii\\_2015-2020\\_draft.pdf](http://planipolis.iiep.unesco.org/sites/planipolis/files/ressources/afghanistan_nesp_iii_2015-2020_draft.pdf)

Кени улсын Суурь боловсролын хөтөлбөрийг суралцагч нэг бүрийг оролцоотой, чадавхжсан, ёс зүйтэй иргэн болгон төлөвшүүлж, иргэний боловсрол нь тэдний үндсэн суурь чадамж байх ёстой гэсэн үндсэн чиглэлээр загварчлан боловсруулсан байдаг.

<http://www.kicd.ac.ke/images/downloads/CURRICULUMFRAMEWORK.pdf>

ДИБ-ын талаар бодлого боловсруулахад баримтлах нэг чухал алхам бол одоо байгаа бодлогод ДИБ-ын агуулгыг шингээж өгөх, аль эсвэл шинэ бодлого боловсруулахын чухам алиныг хийх ёстойг тодорхойлох. Аль ч тохиолдолд ДИБ-ыг боловсролын бодлогод хэвшүүлэх зорилго, хэвшүүлэхгүй байснаар гарах үр дүн, үр дагаврыг сайтар тунгааж үзэх нь зүйтэй. Түүнчлэн ДИБ-ын бодлого боловсруулахдаа аль

бодлого бидний амьдарч буй дэлхий ертөнцийг илүү сайн сайхан болгоход хувь нэмрээ оруулж, аль нь ингэж чадахгүй байна вэ, мөн ДИБ-ын үзэл санааг хэн манлайлж, хэн эсэргүүцэх вэ гэх зэрэг тодорхой үндэслэлүүдээ гаргах хэрэгтэй.

Багш сурган хүмүүжүүлэгч, судлаач, улс төрч, нийгмийн болон шашны бүлгийн тэргүүн, иргэний нийгмийн болон хэвлэл мэдээллийн байгууллагууд гэх мэт ДИБ-ын үзэл санааг дэмжих, эсвэл эсэргүүцэж болзошгүй манлайлагч, шүүмжлэгч талуудтай нээлттэй, хамтран ажиллах арга замыг баримтлах нь цаашид дэмжлэг авах, эсэргүүцэлтэй тулгарахад ач холбогдолтой билээ. Түүнчлэн ДИБ-ыг хэрхэн хэрэгжүүлж, хяналт тавьж, үнэлж дүгнэх талаар энэ бүхнийг тус бүрчлэн хэн хариуцахыг нарийн тодорхойлсон төлөвлөгөө боловсруулах нь чухал.

Хүснэгт 7 болон дараах хүснэгтүүд дээр тэргүүлэх үйл ажиллагааны чиглэл тус бүрт тохирсон стратеги, түүнийг хэрэгжүүлснээр гарах үр дүнг тодорхойлон бичсэн байгаа. Зөвлөмж болгож буй стратеги нь ДИБ-ын агуулгыг боловсролын салбарын одоо байгаа бодлого, нөөц боломж, чадавхтай хэрхэн уялдуулан боловсруулах талаар чиглүүлэх зорилготой юм.

#### Хүснэгт 4. Бодлогын судалгаа, боловсруулалт

	<b>Хэрхэн ? - Зөвлөмж болгож буй Стратеги</b>	<b>Юу? - Хүлээж буй үр дүн</b>
ДИБ-ын үзэл санааг ухуулан таниулах, түгээн дэлгэрүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>- ДИБ-ын үзэл санааг дэмжих, манлайлах хүмүүсийг олж тогтоох, хөгжүүлэх, дэмжих</li> <li>- ДИБ-ын ойлголтыг түгээн дэлгэрүүлэх, мэдээлэлжсэн, хариуцлагатай иргэдийг төлөвшүүлэхэд түүний гүйцэтгэх эерэг үүргийг таниулах</li> <li>- Өөрчлөлтийг авчрах баг бүрдүүлж дэмжих</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- ДИБ-ын бодлого боловсруулах үйл явцыг дэмжиж, манлайлах баг бүрдэнэ</li> <li>- ДИБ нь иргэдийг төлөвшүүлэх эерэг хөрөнгө оруулалт гэдгийг таньж мэднэ</li> <li>- Одоо байгаа бодлогод шингээх, эсвэл шинээр бодлого боловсруулах, тайлбарлан таниулах үйл явцад зориулсан ДИБ-ын тодорхой, баттай үндэслэл гарна</li> <li>- ДИБ-ын бодлогын багийнхан манлайлагч, дэмжигчдийн тусламжтайгаар бодлогын асуудлуудыг хариуцаж боловсруулна.</li> </ul>
Үндэсний нөхцөл байдлыг зураглах	<ul style="list-style-type: none"> <li>- Боловсролын талаар баримтлах үндэсний бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, сургалтын үйл ажиллагаанд ДИБ-ын агуулга орсон байгаа эсэхийг тодорхойлох. Жишээлбэл, иргэний боловсрол, математик, шинжлэх ухаан, байгаль орчин, хэл судлалын хичээлүүдэд ДИБ-ын агуулгаас тусгагдсан эсэхийг нягтлан шалгах.</li> <li>- Албан бус боловсролын аргаар, хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар дамжуулан ДИБ-ыг дэмжих боломж байгаа эсэхийг тодорхойлох</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Албан болон албан бус боловсрол, сургуулийн бодлого, хөтөлбөрт ДИБ-ын агуулга туссан байдлыг тодорхойлно</li> <li>- ДИБ-ын агуулгыг албан болон албан бус боловсрол, хичээлээс гадуурх хөтөлбөрт оруулах боломж, хийдлийг илрүүлнэ</li> </ul>
Олон улсын туршлага болон судалгааны бүтээлүүдтэй танилцах	<ul style="list-style-type: none"> <li>- Бусад орны болон олон улсын түвшний бодлого, санаачилгуудтай танилцаж, хамгийн найдвартай, сайн жишиг туршлагыг олж илрүүлэх</li> <li>- Мэргэшил, туршлага бүхий олон улсын байгууллага, боловсролын байгууллагуудыг олж илрүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Олон улсын түвшний сайн туршлага, бодлого, хөтөлбөрийн жишиг загвартай болно</li> </ul>

Оролцогч талуудтай зөвлөлдөх	<ul style="list-style-type: none"> <li>- Харилцан адилгүй оролцогч талуудын хэрэгцээг тусгасан зөвлөлдөх, төлөвлөх үйл явцыг зураглах. Зөвлөлдөх үйл явцыг дэмжихэд шаардлагатай арга, хэрэгслийг тодорхойлох</li> <li>- Зөвлөлдөх үйл явцын гадна үлдэх магадлалтай хүмүүсийг тодорхойлж тэдэнтэй хэрхэн холбогдож оролцуулах талаар анхаарах</li> <li>- Иргэний нийгмийн болон боловсролын байгууллагууд, мэргэжлийн холбоод, залуучуудын байгууллагууд, нийгмийн бүлэг холбоодыг манлайлагчид, эцэг эхчүүд, хэвлэл мэдээллийн байгууллагууд болон бусад оролцогчдын дэмжлэг, хамтын ажиллагааг идэвхжүүлэх</li> <li>- Зөвлөлдөх үйл явц нь хүндлэх, нөхөрлөх, харилцан ярилцах, хамтран ажиллах, тэгш оролцоог хангах гэх зэрэг ДИБ-ын үндсэн зарчмуудыг хангасан байх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Гол оролцогч талууд бүгд оролцож, зөвлөлдсөн байна</li> <li>- Үйл явцын гадна үлдэж болзошгүй бүлгийг оролцуулсан байна</li> <li>- Зөвлөлдөх үйл явц нь нөхөрлөл, харилцан яриа, хамтын ажиллагааг дэмжиж, үйл хэрэг болгох сэдэл, урам зориг төрүүлэхүйцээр зохион байгуулагдсан байна</li> <li>- ДИБ-ын үндэслэлийг шалгаж, бодлогын цар хүрээг тодорхойлж, бодлогын бичиг баримтын эхний нооргийг боловсруулж, сайжруулсан байна</li> </ul>
Бодлогын зорилт, хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргах	<ul style="list-style-type: none"> <li>- Бодлогын зорилтоо тодорхой, хэмжигдэхүйц байдлаар гаргах</li> <li>- Бүхэллэг/цогцоор харах арга барил бүхий хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, нөөц боломж, бааз суурь, тогтвортой байдлыг нь хангах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Тодорхой зорилтууд бүхий ДИБ-ын бодлого, хэрэгжүүлэх төлөвлөгөө бэлэн болсон байна</li> </ul>
Бодлого, хэрэгжилтийн төлөвлөгөө батлуулах	<ul style="list-style-type: none"> <li>- Бодлого болон хэрэгжүүлэх төлөвлөгөөг үндсэн болон бусад оролцогч талуудад өгөх</li> <li>- Бодлогоо таниулах, ялангуяа ДИБ-ын дэмжигч, манлайлагчдаар дамжуулан дэлгэрүүлэх</li> <li>- Бодлогоо дэмжүүлэх, батлуулах үйл явцыг эрэлхийлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- ДИБ-ын агуулгыг нэгтгэж нэвтрүүлэх нь боловсрол, суралцахуйн бүхий л хүрээнд гарч буй дэвшил хэмээн хүлээн зөвшөөрөгдөнө</li> <li>- ДИБ-ын бодлого албан ёсны хувьд ч, олон нийтийн хувьд ч хүлээн зөвшөөрөгдөн батлагдана</li> </ul>

### 3.2 Үйл ажиллагааны тэргүүлэх талбар 2: Сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийх, боловсруулах

ЮНЕСКО-гийн Олон улсын боловсролын товчооны тодорхойлсноор “сургалтын хөтөлбөр гэдэг бол суралцагчид юуг, хэзээ, хэрхэн сурах вэ гэсэн асуултын дагуу боловсруулагдсан, заах аргагүй, суралцахуй, үнэлгээний тогтолцоо бүхий мэдлэг, ур чадвар, үнэт зүйлсийг төлөвшүүлэхэд чиглэсэн ухамсартай, системтэй сонголтын үр дүн юм”<sup>17</sup> гэжээ. Иймд, ДИБ-ын агуулгыг үндэсний сургалтын хөтөлбөрт тусгах нь нэн чухал юм.

ДИБ-ын бодлого боловсруулах үйл явцын нэгэн адил сургалтын хөтөлбөр боловсруулахдаа одоо хэрэгжиж байгаа үндэсний сургалтын хөтөлбөрүүдэд дүн шинжилгээ хийх хэрэгтэй бөгөөд ДИБ-ын агуулга орсон хэсгүүд болон сайжруулах боломж, дутагдалтай зүйлсийг олж тогтоож сургалтын хөтөлбөрийн өөрчлөлтийг төлөвлөх, тайлбарлан таниулахад дөхөмтэй болно. Жишээлбэл, ДИБ-ын тогтвортой хөгжлийн агуулгууд шинжлэх ухааны хөтөлбөрт, энх тайвны агуулга түүхийн хөтөлбөрт, хамтын ажиллагааг дэмжих боломжийг спорт, урлагийн хичээлээр, цахим иргэний боловсролыг мэдээлэл зүйн хичээлээр олгохоор аль хэдийн тусгасан байж болох билээ.

17 Global citizenship education: A Guide for Policymakers (2017), UNESCO and APCEIU, p 30

ЮНЕСКО-гийн Дэлхийн иргэний боловсрол: Сэдвүүд болон Суралцахуйн Зорилтууд (GCED: Topics and Learning Objectives) хэмээх 2015 оны хэвлэл нь үндэсний хэмжээнд сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийх, шинээр боловсруулахад тохиромжтой эх сурвалж болж чадна. Энд ДИБ-ын суурь цогц чадамжуудаас гадна албан ёсны боловсролын 5-18 насны сурагчдын түвшин бүрт тохирсон сэдэв, үндсэн чиглэлүүдийг багтаасан болно. Сургалтын хөтөлбөр боловсруулах өөр нэгэн ашиглууштай эх сурвалж нь IBE болон APCEIU-аас боловсруулсан матриц бөгөөд энд ДИБ-ын сургалтын хөтөлбөрийн агуулгыг төрөлжүүлсэн байдаг. Хайрцаг 2-т сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийх, боловсруулахад хэрэглэж болохуйц эх сурвалжуудаас жишээ болгон байрлууллаа.

Үндэсний сургалтын хөтөлбөрт ДИБ-ыг дараах байдлаар оруулж болно. Үүнд,

1. Одоо байгаа хичээлүүдийн агуулгаар олгох (иргэний боловсрол, математик, нийгэм болон хүрээлэн буй орчин судлал, эрүүл мэнд гэх мэт) тухайлсан хичээлүүдэд нэгтгэх,
2. Сургууль бүхэлдээ хэрэгжүүлэх буюу суралцахуйн бүх хүрээ болон сургуулийн соёлд нэвтрүүлэх байдлаар ДИБ-ыг олгож болно.

Эдгээрийн сүүлийнх болох ДИБ-ыг боловсролын байгууллага, суралцахуйн бүх хүрээ, сургалтын хөтөлбөр буюу "хүүхдийн сургууль дээр сурч буй бүхий л зүйлс"-д нэвтрүүлэх нь хамгийн үр дүнтэй арга зам болно.

ДИБ-ыг бүхэл сургуулийн хэмжээнд хэрэгжүүлэх аргын хувьд зорьж буй суралцахуйн үр дүн, цогц чадамж нь хүн бүрийн үүрэг хариуцлага болох юм. Түүнчлэн сургуулийн үнэт зүйлийг бий болгоход сургуулийн захиргаа, багш сурган хүмүүжүүлэгчид, сургуулиас гадна орших оролцогч талууд (эцэг эх, асран хамгаалагчид, төрийн болон төрийн бус байгууллагууд гэх мэт), мөн суралцагчдыг хамруулах нь тэдний дуу хоолойгоо хүргэх, тэмцэх чадварыг хөгжүүлэхэд чухал үүрэгтэй юм. Эдгээр нь орон нутаг, улс орон, олон улсын түвшинд идэвхтэй иргэн байх үндсэн чадваруудыг эзэмшүүлэх ач холбогдолтой.

### **Хайрцаг 2. Сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийх, боловсруулахад зориулсан зөвлөмжийн жишээнүүд**

"Багш нар иргэний болон хүний эрхийн боловсролыг хэрхэн дэмжих вэ: Чадваруудыг хөгжүүлэх нь" хэмээх Европын Зөвлөлөөс 2009 онд гаргасан энэхүү хэвлэлд ардчилсан иргэний болон хүний эрхийн боловсролыг сургуулийн орчин, нийгмийн илүү өргөн хүрээлэлд өдөр тутмын амьдралд нэвтрүүлэх зорилгоор багш нарт шаардлагатай суурь чадваруудыг тодорхойлж өгсөн. Энэхүү гарын авлага нь боловсролын төрөл бүрийн салбар, түвшинд ажиллаж буй багш нар болон багш бэлтгэж буй их дээд сургуулиудад багшлахын өмнөх болон дараах сургалтуудад зориулагдсан болно.

<http://www.worldcat.org/title/how-all-teachers-can-support-citizenship-and-human-rights-education-a-framework-for-the-development-of-competences/oclc/3179293152>

НҮБ-ын БШСБ-ын Боловсрол Төлөвлөлтийн Олон улсын Институт (ИИЕР), Аюул, Зөрчил мөргөлдөөний үед боловсролын салбарыг хамгаалах хөтөлбөр (PEIC) болон IBE-ээс хямралын үеийн боловсролын агуулгыг боловсруулах, төлөвлөхөд зориулсан Сургалтын хөтөлбөрийн дүн шинжилгээ хэмээх гарын авлагыг эрхлэн гаргасан. Энэхүү гарын авлагыг зөрчил мөргөлдөөн, гамшигт нэрвэгдсэн газрын "боловсролын тогтолцооны эргэн сэргэх чадварыг сайжруулах, иргэд болон боловсролын байгууллагын аюулгүй, нэгдмэл байдлыг дэмжих зорилгоор" бүтээсэн болно.

<http://www.unesdoc.unesco.org/images/0023/002348/234815e.pdf>

Онтариогийн Бага сургуулийн багш нарын холбоо нь Онтарио мужийн захиргаатай хамтран Дэлхийн иргэний боловсрол хэмээх сургалтын баазыг бий болгожээ. Энэхүү бааз нь багш нар ганцаарчлан болон бүлгээр ажиллах боломж бүхий хэсгүүдээс бүрдсэн бөгөөд Дэлхийн боловсролын нийгэмлэг дэх тэдний оролцоо болон мэргэжил нэгтгүүддээ өгсөн санал зөвлөгөөн дээр үндэслэн боловсруулжээ.

<http://www.etfo.net/globaled/Educating4GlobalCitizenship.pdf>

Герман улс Тогтвортой хөгжлийн боловсролд зориулсан сургалтын хөтөлбөрийн үндсэн чиглэлийг баталжээ. Энэхүү үндсэн чиглэл нь үндэсний стратегийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, дэлхий нийтийн сорилттой цаг үед боловсролоор дамжуулан тогтвортой хөгжлийн үндсийг тавих зорилготой аж.

[https://www.eineweltfueralle.de/fileadmin/user\\_upload/Orientierungsrahmen/or\\_abschlussentwurf\\_din\\_a\\_4\\_final](https://www.eineweltfueralle.de/fileadmin/user_upload/Orientierungsrahmen/or_abschlussentwurf_din_a_4_final)

Сургалтын хөтөлбөрийг шинээр боловсруулахдаа эхлээд багш, суралцагчидтай хамтран туршиж үзэх маш чухал бөгөөд ингэснээр агуулга, суралцахуйн үйл явцын хувьд ДИБ-ын зарчим, заах аргазүй, арга барилтай нийцэж буй болон үр нөлөөтэй буй эсэхийг нягтлах боломжтой болдог. Түүнчлэн бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх явцад хяналт тавих, сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийх зэрэг ажлын уялдааг харгалзан үзэх нь зүйтэй (2.5-р хэсгийг үзнэ үү.) ДИБ-ын суралцахуйн зарим үр дүн, ялангуяа нийгмийн сэтгэлзүйн талбар дахь суралцахуйн үйл явцыг стандарт үнэлгээний аргаар үнэлэхэд бэрхшээлтэй бөгөөд өөрийн үнэлгээ, суралцагчдын үнэлгээ, цуглуулбар болон бусад тусган дүгнэх үнэлгээний аргуудыг хэрэглэх нь зохимжтой<sup>18</sup>. Энэ нь суралцахуйд зориулан үнэлэх нь хэмээх үзэл санаанд тулгуурласан арга барил бөгөөд шүүмжит, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, асуудал шийдвэрлэх зэрэг танин мэдэхүйн талбарт мөн өөр үнэлгээний аргуудыг хэрэглэдэг.

ДИБ-ын агуулгыг одоо байгаа сургалтын хөтөлбөрөөр дамжуулж эсвэл шинээр хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх нь цаг хугацаа, байнгын тогтвортой хичээл зүтгэл шаардсан ажил юм. Тогтмол дүн шинжилгээ хийх, холбоотой санал сэтгэгдлийг хүлээн авах, үнэлгээ хийж байх нь сургалтын хөтөлбөрийн загвар, агуулгыг улам сайжруулахад тустай.

### Хүснэгт 5. Сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийх, боловсруулах нь

	Хэрхэн ? - Зөвлөмж болгож буй стратеги	Юу ?- Хүлээж буй үр дүн
Сургалтын төлөвлөгөөг зураглах нь	<ul style="list-style-type: none"> <li>- Албан ёсны сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийж, ДИБ-ын агуулга орсон, нэмж тусгах боломжтой эсэхийг тодорхойлно. Үүнийг сургалтын хөтөлбөр боловсруулах чиглэлээр мэргэшсэн багш, сурган хүмүүжүүлэгчид хийх хэрэгтэй.</li> <li>- ДИБ-ын үндсэн чадваруудыг зааж сургахад дэмжлэг болоход шаардлагатай заах аргазүйн зөвлөмжийг тодорхойлох</li> <li>- ДИБ-ын албан ёсны сургалтын хөтөлбөрийг дэмжих албан бус болон гэрийн боловсролын хөтөлбөр, үйл ажиллагаатай уялдуулан зураглах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- ДИБ-ын агуулгатай холбоотой одоо байгаа сургалтын хөтөлбөрүүдийн бүрдэл хэсгүүд, суралцахуйн талбарууд, сэдвүүд, зорилт, үр дүн, үнэлгээ зэргийг багтаасан сургалтын хөтөлбөрийн зураглал, дүн шинжилгээ</li> <li>- ДИБ-ын агуулгыг эзэмшүүлэхийн тулд суралцахуйн ялгаатай үе шат, түвшинд тохирсон заах аргазүйг тогтоох</li> <li>- ДИБ-ын агуулгыг дэмжин дэлгэрүүлэх зорилго бүхий албан бус, гэрийн боловсрол, хичээлээс гадуурх үйл ажиллагааны зураглал</li> </ul>

18 Global citizenship education: A Guide for Policymakers (2017), UNESCO and APCEIU, p 32

Оролцогч талуудтай зөвлөлдөх	<ul style="list-style-type: none"> <li>- Сургалтын хөтөлбөрийн зураглал, төлөвлөлтийн ололттой тал, гарч буй саналын талаар гол оролцогч талуудтай зөвлөлдөх</li> <li>- ДИБ-ыг сургалтын хөтөлбөрт бүрэн нэвтрүүлэхийг дэмжих зорилгоор соёл хоорондын ойлголцол, жендэрийн тэгш байдал, хүний эрх, шударга ёс, тогтвортой хөгжлийн боловсролын чиглэлээр ажиллаж буй иргэний нийгмийн байгууллагууд, энх тайванч байдал, шударга ёс, шашин хоорондын яриа ойлголцлыг дэлгэрүүлэн ажиллаж буй итгэл бишрэлд суурилсан байгууллагуудтай хамтын ажиллагааг бэхжүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Сургалтын хөтөлбөрийн загвар, агуулгыг боловсруулах зорилгоор хийсэн ДИБ-ын суурь чадваруудын тодорхойлолт, суралцахуйн үйл ажиллагааны үр дүн, зөвлөлдөх үйл явцын үр дүнг харилцан зөвшөөрнө</li> <li>- ДИБ-ыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх байгууллагуудтай нягт хамтын ажиллагаа бэхжинэ</li> </ul>
Сургалтын хөтөлбөрийг сайжруулах эсвэл шинээр боловсруулах	<ul style="list-style-type: none"> <li>- ДИБ-ын агуулгыг сургалтын хөтөлбөрт нэгтгэх зорилгоор сургалтын хөтөлбөр боловсруулах чиглэлээр мэргэшсэн мэргэжилтнүүд, багш бэлтгэх их дээд сургуулиудтай хамтран ажиллах</li> <li>- ДИБ-ыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх нарийвчилсан удирдамж гаргах, ингэхдээ багшийн үүрэг чиглүүлэгч, туслагч байх хэрэгтэйг онцгойлон тэмдэглэх</li> <li>- Суралцахуйн үйл явц, үр дүнд үнэлгээ хийхэд тохиромжтой аргуудыг тодорхойлох</li> <li>- Шаардлагатай тохиолдлуудад сурах бичиг зохиогчид болон бусад төрлийн сургалтын материал бүтээгчидтэй зөвлөлдөх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- ДИБ-ын сургалтын ай, сэдэв, суралцахуйн зорилтууд, үр дүн, үнэлгээний арга зэргийг нарийн тусгасан сургалтын хөтөлбөрийн загвар бэлэн болно</li> <li>- ДИБ-ын суралцахуйн үндсэн аинууд (танин мэдэхүйн, нийгмийн сэтгэлзүйн, зан үйлийн) сургалтын хөтөлбөрт анги түвшин бүрт бүрэн тусгагдсан байна</li> <li>- ДИБ-ын үндсэн чадваруудыг заах аргазүй болон суралцахуйн аль алинд дэмжин сайжруулах аргазүйн зөвлөмж бэлэн болно</li> </ul>
Сургалтын хөтөлбөр, жишээ хичээлийг туршиж	<ul style="list-style-type: none"> <li>- Одоо байгаа сургалтын хөтөлбөрт оруулж байгаа эсвэл шинэ хөтөлбөр гаргаж байгаагийн алинд ч ДИБ-ын сэдэв, бүлэг хичээл болон нэгж хичээлүүдийг туршиж, чанарын болон тоон судалгааны аргаар үнэлгээ хийх хэрэгтэй</li> <li>- Шаардлагатай тохиолдлуудад засварлан сайжруулах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Суралцахуйн тодорхой, бодит зорилт, үр дүн бүхий ДИБ-ын сургалтын хөтөлбөрийн загвар бэлэн болно</li> <li>- Сургалтын хөтөлбөрт дүн шинжилгээ хийсэн мэргэжилтнүүд болон боловсруулахад оролцсон оролцогч талууд сургалтын хөтөлбөрийн агуулга, загварт бүрэн дүүрэн сэтгэл хангалуун байж, хэрэгжүүлэхэд бэлэн болсон байна</li> </ul>
Шинэ хөтөлбөр танилцуулах	<ul style="list-style-type: none"> <li>- ДИБ-ын хөтөлбөрийг уулзалт, семинар, багш бэлтгэх сургалт, мэргэжил дээшлүүлэх сургалтууд дээр боловсролын бодлого, хөтөлбөр боловсруулагчид, менежерүүд, сургагч багш, сургуулийн удирдлагууд, багш сурган хүмүүжүүлэгчид, сургалтын материал бүтээгчдэд танилцуулах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- ДИБ-ын хөтөлбөр батлагдаж, боловсролын байгууллагуудад нэвтэрнэ</li> <li>- Оролцогч талууд ДИБ-ын сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлэх бүрэн мэдлэг, чадвартай болсон байна</li> </ul>
Сургалтын хөтөлбөр, заах аргазүйг үнэлэх	<ul style="list-style-type: none"> <li>- Сургалтын хөтөлбөрийн бүтэц, агуулга болон түүнийг хэрхэн нэвтрүүлж буй байдалд тогтмол, системтэй үнэлгээ хийх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- ДИБ-ын зарчим, зорилгод нийцсэн суралцагчдын амьдрал, хэрэгцээ шаардлага, боловсролын түвшин бүрт тохирсон чанартай сургалтын хөтөлбөр бэлэн болно</li> </ul>

### 3.3 Үйл ажиллагааны тэргүүлэх талбар: Чадавх бэхжүүлэх

Боловсролын салбарын бодлого боловсруулагчид, манлайлагчид, багш нар ДИБ-ын үндсэн зарчмууд нь багш, суралцагчдын суралцахуйн үйл ажиллагааг хэрхэн баяжуулж, чанаржуулж байдгийг ухамсарлан ойлгох хэрэгтэй. ДИБ-ын зарчмууд нь тэднийг ажлын арга барил, ойлголт, үнэт зүйл хийгээд ертөнцийг үзэх үзлээ эргэн нягтлахыг<sup>19</sup>, мөн сурган хүмүүжүүлэгчид өөрсдийгөө суралцагч, дэлхийн иргэн хэмээн харахыг шаарддаг билээ. Энэ нь сурган хүмүүжүүлэгчид өөрсдөө амьдарч буй дэлхий ертөнцөө танин мэдсэн, шүүмжлэлт сэтгэлгээнд суралцсан, нийгэмтэйгээ хөл нийлүүлэх чадвартай, олон янз байдалд хүндлэлтэй ханддаг, ёс зүйн хариуцлагатай байх хэрэгтэй гэсэн үг юм<sup>20</sup>.

Багш нар өөрсдийн хандлага, зан үйлээр дамжуулан боловсролын байгууллагын соёл, үнэт зүйлсийг бий болгож, суралцагчдаа дамжуулж байдаг. Сургуулийн соёл, үнэт зүйлс нь албан ёсны сургалтын хөтөлбөрөөс гадуур суралцахуйн үйл явцад нөлөөлж байдаг бөгөөд үүнийг зарим тохиолдолд “далд сургалтын хөтөлбөр” хэмээн нэрлэх нь ч бий. Иймд, багш, сургуулийн захиргаа нь хүний эрх, шударга ёс, энх тайван, хүндлэл, тэгш оролцоог эрхэмлэдэг үнэт зүйлстэй сургуульд ДИБ хөгжин цэцэглэнэ<sup>21</sup>.

Багш нарыг ДИБ-ын заах аргазүйд сургаж, улмаар өдөр тутмын хичээл практикт сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлснээр тэдэнд хүний эрх, шударга ёс, хүндлэл, эрх тэгш оролцоо зэрэг үнэт зүйлсийг төлөвшүүлэн дэлгэрүүлээд зогсохгүй, тэдний чадавхыг бэхжүүлж, ялгаварлан гадуурхах үзэл, хүчирхийлэлд анхаарал хандуулахад чухал ач холбогдолтой. Хичээлийн танхимд нэг багш асар их өөрчлөлтийг авчирч чадах ч хүндлэлд суурилсан, энх тайванч, тэгш хамруулах соёлыг дэлгэрүүлэхийн тулд бүхэл сургуулийн загварыг авч нэвтрүүлэх шаардлагатай юм.

ДИБ-ын агуулгад багш нарын чадавхыг бэхжүүлэх нь нэн чухал. Байнгын, чанартай мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрийн нэг хэсэг болохын хувьд ДИБ-ын зарчим, практикийн сургалт нь хувирган өөрчлөх боловсролын талаар мэдлэггүй багш нарт зайлшгүй хэрэгтэй. Түүнчлэн ДИБ-ын зарчмуудад суурилсан мэргэжил нэгтнүүдийн хамтын ажиллагаа, ажиглалт, ментор, үйл явц зэргээс суралцах гэх мэт мэргэжлийн суралцах соёлыг бий болгох нь чухал бөгөөд энэ нь суралцагчдыг нийгмийн хариуцлага, оролцоонд төлөвшүүлэхэд тустай.

ДИБ бидний анхаарлыг цогц асуудлуудад хандуулдаг тул мэргэжлийн сургалт нь төрөл бүрийн мэдээллийн хэрэгсэлд шүүмжит сэтгэлгээгээр хандаж, шүүмжтэйгээр үнэлгээ хийж сурах чадварыг төлөвшүүлж өгөх ёстой. Багш нарыг улс орны хэмжээнд олон янзат нийгмийн бүлгүүдтэй ойртуулан танилцуулж, эсвэл олон улсын солилцооны хөтөлбөрт оролцуулах замаар ялгаатай соёл, заах аргазүйд нэвтрүүлэх нь тэдний орон нутаг, улс орон, олон улсын асуудлуудын талаарх мэдлэг, ойлголтоо нэмэгдүүлэхэд тус дөхөмтэй юм. Энэ төрлийн мэргэжил дээшлүүлэх сургалт нь соёл хоорондын ойлголцол, дэлхийн иргэний боловсролыг ойлгож мэдэх “дөт зам” болж чадна.

Сургуулиуд болон багш бэлтгэх их, дээд сургуулийн захиргаа, удирдлагуудад мэргэжлийн туслалцаа үзүүлэх нь мөн чадавх бэхжүүлэхэд тустай. Сургуулиуд авч хэрэгжүүлж болох чадавх бэхжүүлэх төрөл бүрийн санаачилга, ашиглах материалын бааз бий. (Хайрцаг 3-ыг үзнэ үү.)

19 UNESCO, 2014

20 UNESCO, 2015

21 UN, 2015

### Хайрцаг 3. ДИБ-ын хүрээнд чадавх бэхжүүлэх бааз, санаачилгуудын жишээ

Гүнзгийрүүлсэн сургалтын шинэ сургах зүй (New Pedagogies for Deep Learning NPDL) нь Австрали, Колумби, Канад, Испани, Сингапур, АНУ, Уругвай зэрэг орнуудын судалгаа, хөгжлийн хамтарсан төсөл юм. Энэхүү төсөл нь иргэний боловсрол гэх мэт 6 үндсэн чадваруудын хүрээнд сургуулиудыг янз бүрийн төсөл, судалгаа болон мэргэжлийн сургалтын хөтөлбөрүүдэд хамруулдаг.

TakingItGlobal нь суралцагчдын хувирган өөрчлөх боловсрол эзэмших үйл ажиллагааг тэтгэхэд технологийн хэрэглээг дэмжих зорилготой цахим хуудас юм.

<https://www.tigweb.org/tiged/>

Австрали улсын Викториа дахь Боловсрол, Сургалтын хэлтсээс Internationalising Schooling: A How to Guide for Schools хэмээх гарын авлагыг боловсруулан гаргажээ. Энэхүү цахим гарын авлагыг багш, сургуулийн удирдлага хамтран боловсруулсан бөгөөд сургалтын үйл ажиллагаандаа олон улсын арга барилыг нэвтрүүлэх гэж буй сургуулиудад хэрэгтэй стратеги, оновчтой санаанууд багтаасан аж. Мөн ДИБ-ыг орон нутгийн хэмжээнд хэрхэн нэвтрүүлж болохыг харуулжээ.

<http://www.education.vic.gov.au/about/programs/learningdev/Pages/connected.aspx>

Melton Foundation нь Melton Fellows хэмээн нэрлэгддэг, дэлхий даяар ДИБ-ыг дэмжин, дэлгэрүүлэхээр ажиллаж буй 500 гаруй залуусыг хамруулсан тэтгэлэгт хөтөлбөр юм. Иргэд болон байгууллагуудын хувьд өнөөгийн харилцан хамааралтай дэлхий ертөнцийн цогц ярвигтай асуудлуудыг шийдвэрлэх арга зам бол ДИБ юм хэмээн эдгээр залуус үздэг аж.

<http://meltonfoundation.org/global-citizenship/>

### Хүснэгт 6. Чадавх бэхжүүлэх

	Хэрхэн ? - Зөвлөмж болгож буй стратеги	Юу ? - Хүлээж буй үр дүн
Багш нарын ДИБ-ын талаарх мэдлэгийг сайжруулах	<ul style="list-style-type: none"> <li>- ДИБ-ыг нэвтрүүлснээр заах аргазүй болон суралцахуйн үйл ажиллагаанд өөрчлөлт авчрах боломжийн талаар таниулах</li> <li>- Багш болохоор бэлтгэгдэж буй болон багшийн мэргэжлээр ажиллаж буй хүмүүст ДИБ-ын агуулгыг заах мэдлэг, чадвар, чадавхийг сайжруулах зөвлөгөө, дэмжлэгийг өгөх (Education First, 2015)</li> <li>- ДИБ-ын агуулгыг албан бус сургалтын үйл ажиллагаагаар түгээж байгаа багш нарыг ДИБ-ын мэргэжлийн сургалтад оролцуулах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Багш нар ДИБ-ын зарчмуудыг заах аргазүй, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа, суралцагчид болон өөр бусад өргөн хүрээлэлтэй харилцахдаа баримталдаг болно.</li> <li>- Суралцагчид албан ёсны бус “далд” сургалтын хөтөлбөрөөр мөн суралцдаг болохыг багш нар ойлгосон байна.</li> <li>- Албан болон албан бус боловсролын идэвхтэй хамтын ажиллагаа нь ДИБ-ын агуулгыг эзэмшүүлэх боломжийг улам нэмэгдүүлнэ.</li> </ul>
Мэргэжлийн сургалт, хөгжлийн үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> <li>- ДИБ-ын агуулгад багш нарыг сургахдаа 70:20:10-ын зарчмыг баримтлах нь зүйтэй. Багш хөгжлүүлэх сургалтын 70 хувь нь ажлын байранд багаар ажиллах явцад, 20 хувь нь менторын тусламжтай, 10 хувь нь албан ёсны сургалт, хичээлүүдийн үр дүнд бий болдог байна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Багш болон суралцагчдын хүч чадавхийг дэмждэг, тэгш хамруулалт, хамтын үйл ажиллагааны жишиг болсон үр нөлөөтэй сургалтын орчин бүрдэнэ.</li> <li>- Мэргэжлийн сургалтын шинэ жишиг тогтоно.</li> </ul>

Албан ёсны болон албан бус сургалтын хөтөлбөр дэх багшийн хөгжлийн сургалтыг сайжруулах нь	<ul style="list-style-type: none"> <li>- Багшийн мэргэжлийн хөгжлийн сургалтаар ДИБ, хувирган өөрчлөх боловсролын зарчмуудыг дэмжин дэлгэрүүлж, ялангуяа багш сурган хүмүүжүүлэгчдийн ардчилсан оролцоог хангах нь зүйтэй</li> <li>- Боловсролын байгууллагын удирдлагуудад зориулсан удирдахуйн ухааны оролцоонд тулгуурлах арга барил олгох мэргэжлийн болон чиглүүлэх сургалтуудыг чанаржуулах</li> <li>- Шүүмжит сэтгэлгээний ур чадварыг багш хөгжүүлэх сургалтын нэг хэсэг болгох</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хүний эрх, жэндэрийн тэгш байдал, энх тайвны боловсрол, байгаль, хүрээлэн буй орчны тогтвортой байдлын боловсрол, зөрчил мөргөлдөөнийг шийдвэрлэх, соёл хоорондын ойлголцол зэрэг ДИБ-ын онцлог агуулгууд сургалтын хөтөлбөрт багтаж, цаашлаад илүү энх тайванч, хүртээмжтэй сурах орчинг бүрдүүлэхэд тустай байна.</li> <li>- Багш нар төрөл бүрийн мэдээллийн хэрэгслээр түгээгдэж буй агуулгад шүүмжтэй хандах чадвар, чадавхийг эзэмшсэн байх ба суралцагчдыг мэдээллийг шүүмжтэйгээр хүлээн авч боловсруулж сурахад тусална.</li> </ul>
Хувирган өөрчлөх боловсролын заах аргазүй, арга барилыг дэлгэрүүлэх нь	<ul style="list-style-type: none"> <li>- Мэдээллийн технологи, хамтын үйл ажиллагаа, шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэх чадамжтай суралцагч төвт, оролцоонд тулгуурласан арга барилыг дэмжин дэлгэрүүлэх</li> <li>- Сургууль болон орон нутгаас санаачлан хэрэгжүүлж буй нийгмийн болон байгаль, хүрээлэн буй орчны сайн сайханд тустай хариуцлагатай үйл хэрэгт суралцагчдын оролцоог дэмжих</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хүртээмжтэй, оролцоотой, хамтын ажиллагаанд тулгуурласан суралцах орчин бүрдэнэ</li> <li>- Сургууль болон нийгмийн амьдралын холбоос бий болно. Суралцагчид эзэмшсэн мэдлэг, хандлага, ур чадвараа нийгмийн хүрээлэлдээ ажил хэрэг болгон хөрвүүлэх боломжтой болно.</li> </ul>
Дотоод, гадаадын солилцооны хөтөлбөрт багш нарыг хамруулах	<ul style="list-style-type: none"> <li>- Багшийн хөгжилд зориулсан сургалтын нэг хэсэг болгох үүднээс багш, сурган хүмүүжүүлэгчдийг орон нутаг, улс орон, олон улсын солилцооны хөтөлбөрт хамруулах нь ялгаатай соёл, нийгмийн бүлгүүдтэй, ялангуяа эмзэг, буурай бүлгийнхэнтэй танилцаж, таньж мэдэх, холбогдох боломжийг бий болгох нь зүйтэй.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Багш нар ДИБ-ын хүрээнд зохион байгуулагддаг олон улсын сургалтуудад оролцоно (ARCEIU, ЮНЕСКО, НУБ-ын Хүүхдийн сан гэх мэт)</li> <li>- Дотоод гадаадын солилцооны хөтөлбөрт хамрагдсан багш нар багшийн хөгжлийн үйл ажиллагаа болон ДИБ-ын агуулгыг эзэмшүүлэх ажилд манлайлан оролцоно.</li> </ul>

## НЭМЭЛТ. ДЭЛХИЙН ИРГЭНИЙ БОЛОВСРОЛ БА ХИЧЭЭЛ ХООРОНДЫН УЯЛДАА<sup>22</sup>

Дэлхийн иргэний боловсрол нь сургуулийн сургалтын хөтөлбөрийг бүхий л хүрээнд баяжуулдаг бөгөөд Дэлхийн иргэний боловсролоор олгох цогц чадамж (Зураг 3) -ийг олгоход хичээл тус бүр чухал хувь нэмэр оруулдаг. ЕБС-ийн зарим хичээлээр дамжуулан дэлхийн иргэний боловсролын агуулгыг харилцан ашигтай байдлаар хөгжүүлэх зарим арга замуудыг санал болгож байна.

### Дүрслэх урлаг

- Хүний амин чанар, хүн төрөлхтөн, ялгаатай байдал, олон янзат байдал, зөрчил мөргөлдөөн хийгээд шударга ёс зэрэг дэлхий нийтийн асуудал, сэдвүүд нь урлагт хэрхэн илэрхийлэгддэг болохыг судлах,
- Өөр ялгаатай үзэл бодол, байр суурь, итгэл үнэмшил, үнэт зүйлсийг танин мэдэх,
- Соёлын ялгаатай байдлыг урлаг, эд өлгийн зүйлийн мэдэх, хэрэглэх, харьцах замаар суралцах боломжийг олгох,

22 Education for Global Citizenship (A guide for schools), OXFAM

## Иргэний боловсрол

- Нийгмийн шударга ёс, хүний эрх, нийгмийн эв эе, дэлхий дахины харилцан хамаарлын асуудлаар ярьж хэлэлцэх, үйлдэл хийхэд суралцах,
- Мэдээлэлтэй, хариуцлагатай үйлдлээр дамжуулан шударга бус байдал, тэгш бус байдал, ялгаварлан гадуурхалтыг сөрөх боломжийг олгох,
- Олон талт ялгаатай байдал, амин чанар, харъяалагдах мэдрэмжийн асуудлыг судлах,
- Эрх мэдэл ба засаглалын талаар сурч мэдэх, эрх мэдлийн тэгш бус харилцааны шалтгаан, үр дагаварт дүн шинжилгээ хийх,

## Математик

- Математикийн үзэл баримтлал, үйл явцыг дэлхийн хэмжээнд тулгамдаж буй асуудал, тоо баримтын тусламжтайгаар дүрслэн харуулах боломжийг олгох,
- Бодит асуудал, өгөгдөлд математикийг ашиглах, хэрэглэх (жишээлбэл, хүний хөгжлийн индекс, жендэрийн индекс),
- Математикт янз бүрийн соёлын нөлөөг авч үзэх боломжийг олгох,
- Өгөгдөл мэдээллийг ашиглах, харуулах, гуйвуулах талаарх шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэх

## Дизайн, технологи (хүнсний багтаана)

- Дизайн, технологийн дэлхийд болон амьдралын чанарт үзүүлэх нөлөөллийг судлах
- Бараа, бүтээгдэхүүний дизайн дахь тогтвортой төгжлийн асуудлыг шийдвэрлэх
- Бүтээгдэхүүний нийгэм, хүрээлэн буй орчин, эдийн засаг, технологийн хам нөхцөл, тогтвортой байдлыг харгалзан үзэх,
- Хүнс, хоол тэжээлд нөлөөлж буй нийгэм, эдийн засаг, байгаль орчин, улс төрийн хүчин зүйлс болон хүнсний тогтолцооны ёс зүй, тогтвортой байдлын асуудалд дүн шинжилгээ хийх

## Газарзүй

- Дэлхий даяарх хүмүүсийн амьдралд нөлөөлж буй асуудлуудыг судалж, асуулт тавьж, шүүмжлэлтэй хандах,
- Дэлхийн дахины харилцан уялдаа холбоо, хамаарал, тогтвортой хөгжлийн тухай ойлголтоо өргөжүүлэн гүнзгийрүүлэх,
- Газарзүйн үндсэн ур чадварыг сайжруулахын тулд бодит ертөнц дэх анхаарал татахуйц асуудал, өгөгдөл мэдээлэлтэй холбох,
- Хүмүүс хоорондын, газар нутаг, хүрээлэн буй орчны болоод соёлын ялгаа, ижил төстэй байдлыг олж мэдэх, нийгэм, байгаль орчин, эдийн засаг, улс төрийн асуудлуудын талаар ялгаатай үнэт зүйл, хандлагыг судлах замаар олон талт ялгаатай байдал, амин чанартай холбоотой асуудлыг шийдвэрлэх,

## Түүх

- Дэлхийн түүхийн цаг хугацаан дахь үйл явдал, хүмүүс, газар нутаг, соёл, хүрээлэн буй орчны ялгаа, ижил төстэй байдал, хүн төрөлхтний түүхийн уялдаа холбоо, харилцан хамаарлыг судлах,
- Эрх мэдэл хийгээд эрх ямбаны талаарх асуудлыг авч үзэж, түүхийг өөр өөрөөр тайлбарлаж буй учир шалтгаанд шүүмжлэлтэй хандах,
- Хувь хүний болон хамтын үйл ажиллагааны ач холбогдол, иргэний болон нийгмийн хариуцлагын асуудлыг авч үзэх,
- Тэгш бус байдал, өрөөсгөл хандлага, зөрчил мөргөлдөөн, дарлал зэрэг сэдвүүдийг судалж, түүхэн жишээг орчин үеийн үйл явдал, туршлагатай холбож судлах,

## Компьютерын ухаан

- Бодит асуудлуудыг ойлгож, шийдвэрлэхийн тулд тооцоолох сэтгэлгээ, хэрэглээний болон бүтээлч чадварыг хөгжүүлэх
- Дэлхий нийтийн өмнө тулгамдсан асуудлын талаарх бодит мэдээллийг ашиглан дата мэдээллийг бүртгэх, өгөгдөл боловсруулах, өгөгдлийн загварчлах, хянах
- Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хувь хүн, олон нийт, нийгэмд үзүүлэх нөлөөлөл, түүний дотор МХХТ-ийн хүртээмж, ашиглалтын нийгэм, эдийн засаг, ёс зүйн үр дагаврыг (жишээлбэл, даяаршил, ядуурал, тэгш бус байдал, ардчилал, ялгаатай байдал, зөрчил мөргөлдөөнд үзүүлэх нөлөө гэх мэт) авч үзэх,
- Шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэх, цахим мэдээллийн боловсролыг олгох

## Гадаад хэл

- Хүмүүс, газар нутаг, соёл, хэл хоорондын ижил төстэй болон ялгааг харгалзан амин чанар, олон янзат байдлын асуудлыг судлах,
- Хэлнүүд тасралтгүй хөгжиж, бие биенээсээ зээлж байдаг дэлхийн дахины харилцан уялдаа холбоог ухамсарлах, ойлгох,
- Янз бүрийн соёл, тэдний ертөнцийг үзэх үзлийн талаарх мэдлэгээ нэмж, талархан үзэх
- Унших, бичих, ярианы хэлний чадварыг хөгжүүлэхийн зэрэгцээ дэлхий нийтийн тулгамдсан асуудлуудыг судлах боломжийг олгох,
- Нэг хэлээр ярьдаг тивүүд, үндэсний болон бүс нутгийн янз бүрийн хам нөхцөлийг судлах (жишээлбэл, Баруун Африк, Латин Америк, Испани хэл, угсаатан, ястан, овгуудын хэл зэрэг)

## Хөгжим

- Хувийн амьдрал дахь хэн байх, хаана харьяалагдах талаарх мэдрэмжийг дуу хөгжмөөр илэрхийлэх,
- Нийгмийн шударга бус байдлыг эсэргүүцэж, эерэг өөрчлөлтийн алсын харааг сурталчлахад хөгжим хэрхэн ашиглагдсантай танилцаж мэдэж авах,
- Төрөл бүрийн хөгжмийн уламжлал хийгээд нийтлэг элементүүдийн өөр хоорондын уусгалт, харилцан уялдаа холбоог судлах замаар дэлхий дахины ялгаатай байдал, харилцан уялдаа холбоог үнэлэх чадварыг хөгжүүлэх,

## Нийгмийн ухаан

- Орон нутаг, үндэсний болон олон улсын хөгжлийн асуудлуудыг судлахдаа нийгэм, улс төр, байгаль орчин, эдийн засгийн талаас судлах,
- Нийгэм, ардчилал болон эрх мэдлийн харилцаа бүрэлдэн тогтох асуудлыг судлах, дэлхийн уялдаа холбоо, хамаарлыг ойлгож мэдэх,
- Өөрийн улс орон болон гадаад улс орон дахь тэгш байдал, нийгмийн шударга ёсны байдлыг холбож ойлгох
- Нийгмийн ухааны хичээлд идэвхтэй оролцоонд тулгуурлан шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлж, мэдээлэлтэй үнэт зүйл, хандлагыг төлөвшүүлэх,

## Биеийн тамир

- Багаар ажиллах замаар хамтын ажиллагааны ур чадвар хийгээд харилцан хамаарлыг үнэлэх ур чадварыг хөгжүүлэх,
- Шударга тоглох, бие биенээ хүндэтгэх, сэтгэл хөдлөл болон зөрчилдөөнийг зохицуулах чадварыг хөгжүүлэх,
- Соёл, жендэр, арьсны талаарх хэвшмэл ойлголтыг эсэргүүцэх, спорт ба ялгаатай байдлын хоорондын хамаарлыг судлах,
- Зөрчилдөөн, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах, жендэрт суурилсан хүчирхийлэл зэрэг асуудлыг судлах боломж олгох.

### 3.4 Үйл ажиллагааны тэргүүлэх талбар 4: Мэдлэг бүтээх, хуваалцах, түгээн дэлгэрүүлэх нь

Улс хоорондын харилцааг бэхжүүлэх нь ДИБ-ын онолыг тодорхой ойлгох, мэдлэг хуваалцах, практик үйл ажиллагааг сайжруулах, олон улсын хамтын ажиллагаа, ойлголцлыг бэхжүүлэх ач холбогдолтой<sup>23</sup>.

ДИБ-д анхааран ажилладаг орон нутаг, улс орон, олон улсын маш олон байгууллагууд байдаг. Олон улсын түвшинд Сургалтын хөтөлбөр, заах аргагүйн Дэлхийн Зөвлөл, Энхтайвны Боловсролын Хороо, Европын Дэлхийн Боловсролын Сүлжээ, Соёл хоорондын Боловсролын Олон улсын Холбоо, Дэлхийн Байгаль, хүрээлэн буй орчны Конгресс, Хүний Эрхийн Боловсролын Олон улсын Эвсэл зэрэг байгууллагууд энэ чиглэлээр ажиллаж байна. Эдгээр байгууллага, сүлжээ нь ДИБ-ыг хэрэгжүүлэх, дэлгэрүүлэхэд мэдлэг, заах аргагүй, сайн туршлага, бодлогын өмгөөлөл зэрэгт найдвартай эх сурвалж болж чадна.

ДИБ-ын агуулгыг амжилттай нэвтрүүлж хэрэгжүүлсэн түүхүүдийг цуглуулж, бусадтай хуваалцах, мөн хамтарсан төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэх нь бусад орны багш, суралцагчдын идэвх сонирхлыг төрүүлэх, соёл хоорондын ойлголцол, залуусын манлайлал, дэлхийн иргэншлийг бэхжүүлэх ач холбогдолтой.

ДИБ-ын үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлж, амьдрал, зан үйлд нэвтрүүлэх гол хүч нь хүүхэд, залуус юм. Залуучуудын байгууллагуудтай хамтын ажиллагааг бэхжүүлж, тэднийг ДИБ-ыг таниулах, өөрчлөлт авчрах үндсэн хүч хэмээн харах нь ДИБ-ыг тогтвортой, амжилттай хэрэгжүүлэх үндэс болдог. Жишээ дурдвал, The Global Digital Citizen Foundation болон iEARN хэмээх байгууллагууд нь ашгийн төлөө бус үйл ажиллагаа явуулдаг бөгөөд хүүхэд, залуус, сургуулиудыг ДИБ-той холбоотой төсөл хөтөлбөр, форумуудад хамрагдах боломжоор хангадаг. The British Council, Oxfam-ын дэмжлэгтэй дэлхийн залуусын сүлжээ, UNESCO, APCEIU зэрэг байгууллагууд дэлхий даяар аж төрж буй хүүхэд залуусыг хоорондоо холбогдон харилцах боломжийг олгодог. (Хайрцаг 4-ийг үзнэ үү.) ДИБ-ын бодлого, сургалтын хөтөлбөрөөр дамжуулан мэдээллийн технологи, боломжтой тохиолдолд олон улсын солилцооны хөтөлбөр, эгч дүү сургууль болох, олон улсын төсөл хөтөлбөрт оролцуулах зэргээр суралцагчдыг бусад орны үе тэнгийн хүүхэд залуустай холбогдох, хамтрах, санаа бодол, мэдлэг, мэдээллээ хуваалцах боломжоор хангах нь зүйтэй.

#### Хүснэгт 7. Мэдлэг бүтээх, хуваалцах, түгээн дэлгэрүүлэх нь

	Хэрхэн ? – Зөвлөмж болгож буй стратеги	Юу ? – Хүлээж буй үр дүн
Үндэсний болон олон улсын сүлжээг олж тодорхойлж хамтран ажиллах	<ul style="list-style-type: none"> <li>- Хувирган өөрчлөх боловсролтой холбоотой, ДИБ-ыг шууд болон шууд бусаар дэмжин ажилладаг дотоод, гадаадын байгууллагуудыг олж тодорхойлж, холбогдох</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Дотоод болон гадаадын ДИБ-той холбоотой мэдлэг, мэдээлэл хуваалцах үйл явцад идэвхтэй оролцоно.</li> </ul>
Туршлага хуваалцах сүлжээг бий болгох	<ul style="list-style-type: none"> <li>- ДИБ-ын агуулгыг эзэмшүүлэх, санаа бодлоо хуваалцах зорилготой багш нарт зориулсан орон нутаг, улс орон, олон улсын хэмжээний сүлжээг бий болгох.</li> <li>- Туршлага болон хэрэглэгдэхүүнээ хуваалцах зорилготой албан ёсны болон албан бус үйл ажиллагааг дэмжих</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Багш нар идэвхтэй харилцаж, хамтран ажилласнаар ДИБ-ыг орон нутаг, улс орон, олон улсын хэмжээнд илүү өргөн хүрээнд, илүү системтэйгээр эзэмшүүлэх боломж бүрдэнэ.</li> <li>- Санаа бодол, туршлага, хэрэглэгдэхүүний бааз, ололт амжилт, сайн туршлага, сорилт зэргээ харилцан хуваалцана.</li> </ul>

23 UNESCO, 2016

Түвшин, салбар бүрт хамтрах	<ul style="list-style-type: none"> <li>- Орон нутаг, улс орны хэмжээнд тулгамдаж буй асуудлуудад анхаарал хандуулахын зэрэгцээ ДИБ-ыг дэмжих зорилгоор нээлттэй харилцаа, хамтын ажиллагааг идэвхтэй байлгах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- ДИБ нь энэ талын сонирхолтой, мэргэшсэн, янз бүрийн оролцогч талуудын харилцан яриа, хамтын ажиллагаан дээр үндэслэн бий болдог.</li> </ul>
Олон улсын хэмжээний төсөл, хамтын ажиллагааг тогтвортой дэмжих	<ul style="list-style-type: none"> <li>- Олон улсын хэмжээний төслүүдийг дэмжих зорилготой Мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХХТ)-ийн мэргэшсэн багийг бий болгох</li> <li>- Суралцагчид олон улсын онлайн, виртуал төсөл хөтөлбөрүүдэд оролцохдоо МХХТ-ийг ашиглах</li> <li>- Өөр улс орны сургуулиудтай хамтын ажиллагаа тогтоож, харилцаа, хамтарсан төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэхэд чиглүүлж өгөх</li> <li>- Багш, суралцагчдыг өөрсдийн үйлдэл, хамтын ажиллагаагаа эргэн цэгнэх боломжоор хангах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- ДИБ-ыг дэмжих, хөгжүүлэх чиглэлээр багш, суралцагчид үе тэнгийнхэн, мэргэжил нэгтнүүдтэйгээ холбогдоно.</li> <li>- Хүүхэд залуус, багш сурган хүмүүжүүлэгчид, сургууль болон нийгмийн өргөн хүрээлэлд шууд үр дүнтэй нөлөөлөх олон улсын сүлжээний төсөл, үйл ажиллагаанд боловсролын байгууллагууд идэвхтэй оролцоно</li> <li>- Туршлага, сайн жишгийг орон нутаг, олон улсын хэмжээнд хуваалцана</li> </ul>

#### **Хайрцаг 4. Мэдлэг бүтээх, хуваалцах, түгээн дэлгэрүүлэх жишээ**

*Oxfam UK Education нь олон улсын талаар судлах, суралцах маш өргөн хүрээний шинэлэг санаа, сургалтын хэрэглэгдэхүүний баазтай. Эдгээрээс анги танхимд төдийгүй нийт сургуулиараа авч хэрэгжүүлэх боломжтой бөгөөд ДИБ-ын агуулгыг дэмжсэн хэрэглэгдэхүүнүүд мөн багтсан.*

<http://www.oxfam.org.uk/education>

*iEARN нь дэлхийн 140 гаруй орны 30 гаруй мянган сургууль, хүүхэд залуучуудын байгууллагыг эгнээндээ нэгтгэсэн ашгийн бус байгууллага бөгөөд суралцагчдыг өөрийн орондоо төдийгүй дэлхийн өнцөг булан бүрт амьдран суугаа үе тэнгийн сурагчидтайгаа хамтран төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх боломжийг олгодог. Багш, суралцагчид интернэт болон өөр бусад харилцаа холбооны технологийг ашиглан хамтран ажиллах боломжтой юм. <https://iearn.org/>*

*The British Council нь Connecting Classrooms хэмээх онлайн порталтай бөгөөд үүгээр дамжуулан сургуулиуд дэлхийн өнцөг булан бүрт үйл ажиллагаа явуулж буй сургуулиудтай холбогдох боломжтой.*

<https://schoolsonline.britishcouncil.org/linking-programmes-worldwide/connecting-classrooms/spotlight/Lebanon>

*APCEIU нь 2000 онд байгуулагдсан цагаасаа эхлэн ДИБ болон энх тайвны төлөөх олон улсын ойлголцлын боловсролыг дэмжих зорилгоор багш, сурган хүмүүжүүлэгчдэд зориулан маш олон сургалтуудыг зохион байгуулаад байна. APCEIU-гээс эрхлэн ажиллуулж буй UNESCO-гийн Мэдээллийн төвд дээрх сургалтуудын үр дүнд боловсруулан гаргасан ДИБ болон хувирган өөрчлөх боловсролын агуулга бүхий төслүүд, заах аргагүй, суралцахуйн хэрэглэгдэхүүний бааз бий.*

<https://gcedclearinghouse.org/>

### 3.5 Үйл ажиллагааны тэргүүлэх талбар 5: Хяналт, үнэлгээ

*“Үнэлгээний эцсийн зорилго нь суралцагчдын суралцахуйн үйл явц, үр дүнг сайжруулах явдал юм”<sup>24</sup>.*

Хяналт, үнэлгээ нь суралцахуй, заах аргагүйн үйл явцыг сайжруулахад чиглэл өгөх зорилготой бөгөөд ялангуяа, гарсан үр дүн суралцахуйн зорилттой ямар хэмжээнд нийцэж буйг үнэлэн тодорхойлох үүрэгтэй билээ. Үнэлгээ нь суралцахуй, заах аргагүйн аль алины үр нөлөө, боловсролын чанарыг сайжруулахад чухал үүрэгтэй. ДИБ-ын үнэлгээний стратеги нь багш, суралцагчдын аль алиныг оролцуулах ба суралцахуйн үйл явц, үр дүн, нөхцөл байдалтай холбоотой асуудлуудыг гаргаж тавьдаг (Зураг 3-ыг үзнэ үү.)

ДИБ-д тестээр шалгах, шалгалт авах гэх мэт уламжлалт аргуудаас гадна өөр бусад үнэлгээний аргыг зэрэгцүүлэн хэрэглэх нь тохиромжтой. Эдгээрт,

- Гүйцэтгэлийг шат шатанд нь үнэлэх,
- Сурсан зүйлсээ эргэцүүлэх,
- Чанарын болон явцын гэх мэт үнэлгээний аргууд багтах бөгөөд эдгээр аргууд нь ДИБ-ын чадваруудыг эзэмшсэн эсэхийг тодорхойлоход уламжлалт үнэлгээний аргуудаас илүү үр дүнтэй байдаг<sup>25</sup>.

ДИБ-ын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх явцад төрөл бүрийн оролцоо, харилцан яриа, бүтээлч заах аргазүйд суурилсан явцын үнэлгээ, тест, шалгалтад суурилсан эцсийн үнэлгээний аргуудыг оруулж өгөх нь чухал.

ДИБ-ын танин мэдэхүйн айн үнэлгээ нь дэлхийн хэмжээний асуудлуудын талаарх мэдлэгээ нэмэгдүүлэх, мөн шүүмжтэйгээр сэтгэн бодох, дүн шинжилгээ хийх чадваруудыг үнэлнэ. Нийгэм-сэтгэлзүйн айд соёлын хувьд ялгаатай хүмүүст нээлттэй хандах, бусдад туслах эрмэлзэл, энэрэн нигүүлсэх чадвар зэргийг үнэлнэ. Зан үйлийн айн хувьд идэвхтэй иргэний төлөвшлийг харуулах буюу сайн дурын ажилд оролцох, хүний эрх, жендэрийн тэгш байдлыг хамгаалах, иргэний нийгмийн үйл хэрэгт оролцох, нийгмийн шударга ёс, байгаль, хүрээлэн буй орчныг хамгаалах хөдөлгөөнд оролцох зэрэг чадваруудыг үнэлнэ<sup>26</sup>.

**Зураг 5. Дэлхийн иргэний боловсролыг үнэлэх нь**

#### Үйл явц

Заах аргазүй, суралцахуйн үйл ажиллагаанд нэвтэрсэн байдал, суралцахуйн оролцоо, гэх мэт

#### Үр дүн

Хувийн болон багийн мэдлэг, үр чадвар, үнэт зүйлс, үзэл хандлага, амжилт, гэх мэт

#### Нөхцөл байдал

Сургалтын хөтөлбөрүүд, заах аргазүй, суралцахуйн хэрэглэгдэхүүнүүд, байгууллагын бодлого, заах аргазүйн чадварууд, захиргааны тууштай дэмжлэг, хэрэглэгдэхүүнүүд, суралцах орчин, орон нутаг дах харилцаа холбоо, гэх мэт

24 UNESCO, 2013

25 UNESCO, 2015

26 UNESCO, 2014

Багш нар заах аргагүйн чанар, суралцахуйн орчин, сургалтын хөтөлбөрийг хэрхэн хүргэж байгаадаа дүгнэлт өгөх замаар өөрсдийн ажилд хяналт тавьж, үнэлгээ өгөх боломжтой. Ингэхдээ мэргэжил нэгт багш нараар хичээл заах үйл явцаа ажиглуулан дүгнүүлж, хичээлийн төлөвлөгөөгөө хуваалцаж, суралцагчдаас санал сэтгэгдлийг нь хүлээн авч, мөн өөрийгөө үнэлэх зэрэг аргуудыг хэрэглэж болно. Багш болохоор бэлтгэгдэж буй оюутнууд, мэргэжлээрээ ажиллаж буй багш нарт зориулсан мэргэжлийн сургалтаар дамжуулан ДИБ-ын заах аргагүй, сургалтын хөтөлбөрийн үнэлгээ хийх чадваруудыг олгож байх нь зүйтэй.

ДИБ-ын суралцахуй болон эзэмшүүлэх үйл явц, үр дүнд хяналт тавихаас гадна, ДИБ-ын бодлогын зорилтуудаас зөрж буй үйл явцыг ч мөн үнэлж үзэх хэрэгтэй. Зарим тохиолдолд богино болон урт хугацааны бодлого, хэрэгжилтийн үйл явцыг тайлагнахдаа өөрийн үйл ажиллагааг дүгнэх аргуудыг хэрэглэсэн байдаг. Жишээ дурдвал, Австралийн Викториа дахь Боловсрол, Сургалтын Хэлтсийн Суралцагчдын үр дүнг сайжруулах Үйлийн хүрээ нь үүсэн бий болохоос аажмаар хөгжих, нэвтрүүлэн шингээх, сайжруулан гаршуулах гэсэн дарааллаар институтчлэх үйл явцыг хянаж үздэг байна<sup>27</sup>.

Эдийн засгийн Хамтын ажиллагаа, Хөгжлийн байгууллагаас (OECD) Олон улсын суралцагчдын сурлагын амжилтын үнэлгээний (PISA) хүрээнд 2018 оноос хойш баримтлах олон улсын цогц чадамжийн үнэлгээг боловсруулан гаргадаг. Ингэснээр, “Даяаршиж буй дэлхий ертөнц, соёлын олон янз байдал бүхий нийгэмд суралцагчид амьдралд, ажил төрөл эрхлэн аж төрөхөд хэр сайн бэлтгэгдэж байна вэ”, “Боловсролын байгууллагууд өөрсдийнхөө болон сургуулийн орчны соёл, жендэрийн өрөөсгөл үзэл хандлага, хэвшмэл ойлголттой хэрхэн тэмцэж байна вэ” гэх мэт бодлогын асуултуудад хариулах боломжтой болох юм. Олон улсын сурлагын амжилтын үнэлгээний бусад айнуудын нэгэн адил үнэлгээ хийх үйл ажиллагаа нь нөхцөл байдлын үлгэрчилсэн даалгавар дээр тулгуурласан байдаг. Үлгэрчилсэн даалгаварт 15 настай сурагчид ангидаа болон ердийн амьдрал дээр мэдэрч, ойлгох зүйлсийг багш бэлтгэж туршина гэсэн үг юм. Жишээлбэл, суралцагчид кэйстэй уншиж танилцаад тухайн кэйсийг цогцоор нь тунгааж, тал бүрийн оролцогчдын олон өнцгөөс нөхцөл байдлыг эргэцүүлэн бодож, шийдэл гаргах чадамжид нь үнэлгээ өгөх асуултуудад хариулдаг байна. Суралцагчид, багш сурган хүмүүжүүлэгчид, сургуулийн захиргаа холбогдох асуултуудад хариулах ба ингэснээр ялгаатай соёл бүхий хүмүүст хандах суралцагчдын хандлага, тухайн багшийн ялгаатай соёл бүхий сурагчдаас бүрдсэн ангид үр нөлөөтэй багшлах бэлтгэл, сургуулийн сургалтын хөтөлбөр, хамтран суралцах орчин зэргийг хэрхэн сайжруулах, эсвэл юу саад болж буй тухай асуудлуудыг олж тогтоох боломжтой.

ЮНЕСКО нь гишүүн орнуудаа 1974 онд гаргасан “Хүний эрх, энхтайван, ардчилал, олон улсын ойлголцол, хүлцэн тэвчих боловсролын тухай”<sup>28</sup> зөвлөмжийн дагуу албан ёсны, албан бус, гэрийн боловсролын хүрээнд хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрийнхөө тухай дөрвөн жил тутамд тайлагнахыг хүсдэг.<sup>29</sup> Зөвлөмжийн өмнөх хувилбар (1974) нь улс орнуудын доторх олон тооны үйл ажиллагаа болон олон улсын санаачилгыг хэрэгжүүлэхэд хүргэсэн. Тухайлбал, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн вант улсад улс орон даяар дэлхийн талаарх мэдлэгийг бэхжүүлэх “Дэлхийн судлал” хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн бол Турк, Чехословак улсууд багш бэлтгэх туршилтын төслүүд хэрэгжүүлж, Герман, Египет улсуудад сургуулиудад хүний эрхийн сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлсэн байна. 1974 оны зөвлөмж нь Америкийн Нэгдсэн Улс дахь олон улсын хүний эрхийг заах, Япон, Финлянд, Ливанд олон улсын харилцан ойлголцлын боловсролыг хөгжүүлэх, Зимбабве улсад энх тайван, хүний эрхийн боловсролыг дэмжих агуулга сургалтын хөтөлбөртөө нэмж оруулахад хүргэсэн.

Энэхүү зөвлөмжийг хянан сайжруулж, 2023 онд баталсан ба ТХЗ 4.7-гийн эрхзүйн үндэслэл хэмээн үзэж байна. (Төвч танилцуулгыг ХАВСРАЛТ 1-ээс харна уу.)

27 DET, 2016

28 Education for Human rights, Peace, Democracy, International Understanding and Tolerance

29 Global citizenship education: A Guide for Policymakers (2017), UNESCO and APCEIU, p 42

НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллагын Ерөнхий бага хурлын тогтоолын дагуу Хүний эрх, үндсэн эрх чөлөөний талаарх олон улсын ойлголцол, хамтын ажиллагаа, энх тайвны боловсрол, боловсролын талаарх 1974 оны зөвлөмжийг сайжруулан боловсруулахад зөвлөх үүрэг хүлээсэн “Олон улсын шинжээчдийн бүлэг”-т Боловсрол эвслийн удирдах зөвлөлийн гишүүн, Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн Гүйцэтгэх захирал Б.Батжаргал ажилласан.

**Хүснэгт 8. Хяналт, үнэлгээ**

	<b>Хэрхэн ? – Зөвлөмж болгож буй стратеги</b>	<b>Юу ? – Хүлээж буй үр дүн</b>
Одоо хэрэглэгдэж буй үнэлгээний стратегид дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> <li>- ДИБ болон бусад холбогдох өөрчлөлтийн бодлого, сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийх арга хэрэгсэлд тавих шалгуурыг орон нутаг, улс орон, олон улсын хэмжээнд тодорхойлон зураглах (Олон улсын иргэний боловсрол, Суралцахуйд хяналт тавих олон улсын нийгэмлэг, PISA 2018 Дэлхийн цогц чадамжийн үнэлгээ, Ардчилсан соёлыг дэлгэрүүлэх чадваруудын Европын зөвлөл)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хувийн болон хамтын ахиц дэвшлийг хэмжих үнэлгээний үзүүлэлт, арга хэрэгсэл, үйл явцын хэмжүүрийг тодорхойлно.</li> <li>- Явцын болон эцсийн үнэлгээг багтаасан үнэлгээний гол шалгуур, аргууд бэлэн болно.</li> <li>- ДИБ-ын бодлого, хэрэгжилтэт хяналт тавих боломж бүрдэнэ.</li> </ul>
Суралцагчийн ахиц амжилтыг сургалтын хөтөлбөрийн зорилтот үр дүнтэй харьцуулах	<ul style="list-style-type: none"> <li>- ДИБ-ын үнэлгээний аргуудыг хэрэглээнд оруулах, ингэхдээ ДИБ-ын гүйцэтгэлийг үнэлэх нь захиргааны хувьд нэмэлт ажил болно гэдгийг урьдчилан тооцох хэрэгтэй.</li> <li>- Суралцахуйн үр дүнд гарч буй дэвшилд анхаарч, суралцагч бүрийн хэрэгцээнд тохируулан сургалтын хөтөлбөр, заах аргагүй, суралцахуйн арга барилыг тогтмол сайжруулах.</li> <li>- Зааж буй болон сурч буй зүйлст үнэлгээ хийх тохиромжтой аргыг сонгон хэрэглэх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Үнэлгээний арга нь сургалтын зорилго, заах аргагүйтэй нийцсэн байх ба суралцагч бүрийн хэрэгцээ шаардлагад тохирсон байна.</li> <li>- Боловсролын байгууллагууд, багш нар ДИБ-ыг хэрэгжүүлэх үйл явцаа тодорхой тайлагнах бөгөөд энэ нь тэдэнд нэмэлт ажил болохгүй.</li> <li>- Үйл явц, ахиц дэвшлийг багш болон сурагчдад мэдээлнэ.</li> </ul>
Бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх чиглэлээр дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> <li>- Бодлогын зорилтуудын хэрэгжилтийг үнэлэх тодорхой шалгуурыг боловсруулах.</li> <li>- Сургууль, боловсролын байгууллага, боловсролын үйлчилгээ үзүүлэгчид ДИБ-ын агуулгыг эзэмшүүлж буй үйл явцдаа өөрийн үнэлгээний аргуудыг хэрэглэн хяналт тавьж байх (DET, 2016).</li> <li>- Сайн жишгийг баримтжуулж, хуваалцах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Сургууль, боловсролын байгууллагууд ДИБ-ын зорилтуудыг хэрэгжүүлж буй үйл явцаа хэмжих тодорхой шалгуурууд бэлэн болно.</li> <li>- Бодлогын хэрэгжилтийн үйл явц, тулгарч буй асуудлууд, эдгээрийг хэрхэн сайжруулах талаар сургууль, боловсролын байгууллагууд, боловсролын удирдах байгууллагууд тодорхой дүр зурагтай болно.</li> </ul>
Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээнд оролцох	<ul style="list-style-type: none"> <li>- Үнэлгээний шалгуур, үзүүлэлтүүд, тайлагнах үйл явцыг ДИБ-ын цогц чадамж, шалгуур үзүүлэлтүүдэд нийцүүлэх</li> <li>- Олон улсын үнэлгээнд оролцох. Сүүлийн үеийн дэвшилтэт арга, сайн туршлагаас суралцаж байх үүднээс олон улсын болон бусад төрлийн санаачилгуудад тасралтгүй оролцох.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Үйл явцын тайлан нь олон улсын гол хэмжүүрт нийцнэ.</li> <li>- Олон улсын туршлага, үнэлгээний үйл явцаас суралцахад шамдана.</li> </ul>

## Хайрцаг 5 Хяналт, үнэлгээний жишээ

Голландын Иргэншил, олон улсын хамтын ажиллагааны зөвлөлдөх төвөөс 1,500 гаруй багш, 300 гаруй сургуулийн захирлуудыг оролцуулан тэдний ДИБ-ын агуулгыг эзэмшүүлэхэд гаргаж буй хүчин зүтгэлийг асууж судалжээ. Суурь боловсролын сургуулийн багш нарын 80 хувь, бүрэн дунд боловсролын багш нарын 74 хувь нь ДИБ-ын агуулгыг эзэмшүүлэх нь чухал боловч үүнийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд саад болж буй хамгийн том хүчин зүйл нь ДИБ-ын тухай мэдээлэл хомс байгаа байдал юм хэмээн хариулжээ.

<https://www.ncdo.nl/sites/default/files/NCDO%20Teachers%20Global%20Citizenship.pdf>

Global Framework of Learning Domains-д үр дүнг сайжруулахтай холбоотой 7 суралцахуйн хүрээний хэмжүүрийг онцолсон байдаг. Эдгээрээс унших, бичих гэх мэт суралцахуйн хүрээний хяналт, үнэлгээ аль хэдийн хийгдэж байгаа боловч “дэлхийн иргэн” хэмээх хүрээний хувьд үнэлгээний хэмжүүрүүдийг сая л боловсруулж эхлээд байгаа ажээ. “Дэлхийн иргэн” болж төлөвшихийн тулд суралцагчид байгаль, хүрээлэн буй орчны талаар ойлголт, мэдлэгтэй, асуудлыг хамтын хүчээр шийдвэрлэх, мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашиглах чадвартай, нийгмийн хариуцлагатай байх гэсэн үндсэн чадваруудыг эзэмшсэн байх хэрэгтэй гэжээ.

[https://issuu.com/schneiderw/docs/global\\_framework\\_measuring\\_learning\\_\\_634338507be264](https://issuu.com/schneiderw/docs/global_framework_measuring_learning__634338507be264)

IEA нь үндэсний судалгааны хүрээлэнгүүд, эрдэмтэд, шинжээчдийг нэтгэсэн олон улсын ашгийн бус сүлжээ бөгөөд дэлхий нийтийн боловсролыг таньж мэдэх, сайжруулах, үнэлэн дүгнэх зорилгоор ажилладаг. Дэлхийн 60 гаруй орон, 100 гаруй боловсролын байгууллага энэхүү сүлжээний үйл ажиллагаа, судалгаанд идэвхтэй оролцдог. Тус сүлжээнээс Олон улсын иргэний боловсролын судалгаа гэх мэт цуврал судалгааг эрхлэн явуулдаг бөгөөд үүнд хүүхэд залуусын мэдлэг, итгэл үнэмшил, хандлага, зан үйлийн талаар мэдээлэл цуглуулан тэдний иргэний үүрэгт бэлтгэгдсэн байдал, түүнчлэн байгууллагын нөхцөл байдал, иргэний боловсролын агуулга бүхий сургалтын хөтөлбөр, багшийн чадавхи, туршлага, сургалтын орчин зэрэгт үнэлгээ хийдэг байна. Энэхүү судалгааг IEA, Австралийн Боловсрол Судлалын Зөвлөл, Италийн Laboratorio di Pedagogia Sperimentale болон бусад оролцогч орнуудын үндэсний судлаачид хамтран удирдан явуулдаг болно. Оролцогч орнууд нь Бельги, Болгар, Чили, Тайвань, Колумби, Хорват, Дани, Доминикан, Эстони, Финланд, Герман, Хонг Конг, Итали, Солонгос, Латви, Литив, Мальта, Мексик, Голланд, Норвеги, Перу, ОХУ, Словени, Швед зэрэг болно.

<http://www.iea.nl/>





## БҮЛЭГ 4.

**СУРГУУЛЬ БҮХЭЛДЭЭ ДЭЛХИЙН  
ИРГЭНИЙ ХАНДЛАГА, АРГА ЗҮЙ  
СОЁЛЫГ ТӨЛӨВШҮҮЛЭХ НЬ**

## БҮЛЭГ 4.

# СУРГУУЛЬ БҮХЭЛДЭЭ ДЭЛХИЙН ИРГЭНИЙ ХАНДЛАГА, АРГА ЗҮЙ СОЁЛЫГ ТӨЛӨВШҮҮЛЭХ НЬ

Дэлхийн иргэний боловсролыг сургуулийн бүхий л үйл ажиллагаа, соёлд нэвтрүүлэх нь суралцагчдад хамгийн их үр өгөөжтэй. Учир нь сургууль нь суралцагчдын амьдралынхаа ихэнх хугацааг өнгөрүүлдэг орчин, орон зай учир сургуулийн амьдрал, багшлахуй, суралцахуйн үйл явцаар дамжуулан дэлхийн иргэний боловсролын агуулга, мэдлэг, ур чадвар, үнэт зүйлсийг төлөвшүүлснээр ДИБ-ын зорилгод хүрч очих нь хялбар байх болно. Сургуулийг бүхэлд нь харах хандлага, арга зүйн ач холбогдлыг OXFAM-ын World Shaper<sup>30</sup> санаачлага болон Эмнести Интернэшнлийн “Хүний эрхэд ээлтэй сургууль”, Иргэний боловсрол төвийн “Иргэн төсөл” зэрэг туршлагауд бидэнд харуулж байна.

Oxfam World Shaper сургуулиудын ашигладаг үйл ажиллагааны хүрээ нь сургууль бүхлээрээ ажиллах хандлага арга зүйг сургуулийн төлөвлөлтөд эхнээс нь ашигласнаар дэлхийн иргэний боловсрол олгоход түлхэц болж болохыг батлан харуулдаг.

Сургуулийн ёс зүй	Сургалтын хөтөлбөр	Оролцоо	Багшийн хөгжил	Шилжилт	Хамт олныг бэхжүүлэх
Дэлхийн иргэний боловсрол танай сургуулийн соёлд бий эсэхийг шалгаарай. Сургуулийн алсын хараа, ёс зүйн дүрэм журам, хөгжлийн төлөвлөгөө, шийдвэр гаргах үйл явцад суралцагчид гол оролцогч байдаг.	Сургалтын хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлж буй үе шат, үйл ажиллагаа, судалж буй хичээлүүдээр дамжуулан дэлхийн иргэний боловсролыг олгож байдаг.	Суралцагчдад сургалтын хөтөлбөр болон хичээлээс гадуурх бүхий л үйл ажиллагаануудаар дамжуулан дэлхийн иргэний боловсролын төслүүдэд оролцох эсвэл манлайлах боломжийг нь олгодог.	Багш нарт дэлхийн иргэний боловсролын төсөл, хөтөлбөрүүдийн оролцоог дэмжсэн, шүүмжлэлт хандлага арга зүйг бий болгодог талаарх ойлголтыг хөгжүүлж, тэдэнд хөгжих цаг төлөвлөж өгдөг.	Дэлхийн иргэний боловсролыг СӨБ-оос эхлэн ЕБ-д өргөжүүлэн судалж, ДИБ-ын үнэт зүйл, ур чадварыг дээд боловсрол, ажлын байран дахь байр, насан туршийн боловсролын суурь болгодог.	Дэлхийн иргэний боловсролыг ашиглан орон нутгийнхаа иргэдийг оролцуулах арга замыг боловсруулж, хүй олныг холбогдох үйл ажиллагаанд урьж оролцуулдаг.

Сургуулийг бүхэлд нь дэлхийн иргэний боловсролын соёлтой болгон хувирган өөрчлөхөд томоор сэтгэхээс эхлэх авч жижиг жижиг, удирдаж болохуйц алхмуудаас эхэлдэг. Уг санаачлагыг сургуулийн удирдлагын баг дэмжих нь үр дүнтэй. Уг үйл ажиллагаанд багш, суралцагчид, эцэг эх, асран хамгаалагчдын утга учиртай оролцоог дэмжин, сургуулийн бодлого, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй холбон зохион байгуулж болдог.

30 Education for Global Citizenship (A guide for schools), OXFAM

## 4.1 МОНГОЛ УЛСЫН САЙН ТУРШЛАГА

### ХҮНИЙ ЭРХЭД ЭЭЛТЭЙ СУРГУУЛЬ<sup>31</sup>



НҮБ-ын Хүний Эрхийн Боловсролын Дэлхийн Хөтөлбөрийн зорилтын хүрээнд Олон Улсын Эмнести Интернэшнл байгууллагаас 2009 оноос “Хүний Эрхэд Ээлтэй Сургууль” (ХЭЭС) хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлж ирсэн. Хүний эрхийн үнэт зүйлийг түгээн дэлгэрүүлж, сургуулийн удирдлага, багш эцэг эх, сурагчдын тэгш оролцоог хангах замаар сургуулийн бүхий л орчин дахь хүний эрхийн зөрчлийг арилгаж, хүний эрхийг дээдэлсэн, харилцан бие биенээ хүндэлдэг орчныг бүрдүүлэх зорилготой. ХЭЭС хөтөлбөр нь ЭИ-ийн хувьд дэлхий дахинаа хүний эрхийн боловсролыг хүртээмжтэй болгож, үндэсний боловсролын тогтолцоонд нэвтрүүлэх том боломж билээ. ХЭЭС хөтөлбөрийн туршилтын шатанд 2009 оны 9-р сараас 2011 оны 7-р сарын хооронд 14 орны 15 сургууль хамрагджээ. Монгол улсад ХЭЭС хөтөлбөрт Нийслэл Улаанбаатар болон Дархан-Уул, Орхон, Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай аймгийн 33 ЕБС нэгдсэн.



Хүний эрхэд ээлтэй сургууль гэдэг нь хүний эрхийг гол үйл хэрэг, зохион байгуулалтын зарчим болгож хүний эрхэд сургах, суралцах, хэрэгжүүлэх, хүндлэн хамгаалдаг хамт олон юм. Хүний эрхэд ээлтэй сургууль нь сургалтаар дамжуулан хүний эрхийн боловсролыг олгохоос гадна сургуулийн бүхий л үйл ажиллагаанд хүний эрхийг хүндэтгэхийг нэвтрүүлж “сургууль нийтээрээ” “эрхэд суурилсан” хандлагыг бий болгоход сургуулийн төлөвлөгөө, үйл ажиллагааг чиглүүлдэг.

Монголын Эмнести Интернэшнл 2010 оноос хойш “Хүний эрхийг нэгж хичээлийн хөтөлбөрт нэгтгэх нь” ур чадварын уралдааныг “Хүний эрхэд ээлтэй сургууль” хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулж байна. ЕБС-ийн хичээлийг амьдрал, хэрэглээнд илүү ойртуулах, суралцахуйн үйл явцад хүний эрхийн үзэл санааг нэгтгэх идэвх санаачилгыг өрнүүлэх, багш нарын арга зүйг дэмжих зорилготой тус нээлттэй уралдаанд уралдаанд нийслэл, аймаг, сумын багш нар оролцож хичээл зааж ур чадвараа сорьдог.

### АЮУЛГҮЙ СУРГУУЛЬ АРГАЧЛАЛ<sup>32</sup>

МОНФЕМНЕТ үндэсний сүлжээ 2014 оноос эхлэн “Аюулгүй сургууль” аргачлалыг ЕБС-ууд дээр хэрэгжүүлж байна. Нийт 15 ЕБС хамрагдсанаас 14 нь орон нутагт байрладаг.

Аюулгүй сургууль аргачлал нь хүүхэд нэг бүрийн оролцоог нэмэгдүүлж, багш нарын бүтээлч заах арга барилыг дээшлүүлж, сургуулийн хамт олон хамтдаа суралцан хөгжихөд ээлтэй орчин бүрдүүлэхийг зорьдог. Уг аргачлал нь нийгмийг эерэгээр өөрчлөхөд хамгийн их нөлөө үзүүлэх, найдвартай суваг нь сургууль хэмээн үздэг. Хандлага, сэтгэлгээний өөрчлөлтийг бий болгох гол хүч нь сургуульд буй тул аливаа ялгаварлан гадуурхал, хүчирхийллээс ангид хүмүүнлэг нийгмийг бүтээхэд энэ аргачлал тусалдаг.

Сургуулиуд нь хүмүүнлэг, ардчилсан, хүүхдийн эрх, жендэрийн тэгш эрхийг хангасан бичил орчныг

31 [www.amnesty.mn](http://www.amnesty.mn)

32 [www.monfemnet.org](http://www.monfemnet.org)



бүрдүүлж, сурлагын амжилтыг дээшлүүлэхийн зэрэгцээ хүүхдүүдэд үнэнч, шударга, энэрэнгүй сэтгэлтэй, бүтээлч, чөлөөтэй, хариуцлагатай, өөртөө итгэлтэй, бусдад тусархаг хүн болон төлөвшихөд нь тус болж чадна. Мөн багш, ажилчдынхаа ч мэргэжлийн болон хувийн хөгжлийг дэмжиж, хүчирхийллээс ангид хүчтэй орон зайг бүрдүүлж чадна.

**Аргачлалын онцлог:** Сургуулийн хэрэгцээ, онцлог, сургуулиудын гаргаж буй санаачилгуудаас шалтгаалж аргачлал нь сургууль бүр дээр өөр өөрөөр хэрэгждэг. Аргачлал нь тоглоом болон оролцоонд тулгуурлаж, нэмэлтээр урлагаар дамжуулан багш сурагчдын хооронд ярилцлага, хэлэлцүүлэг өрнүүлж, бие биенээсээ харилцан суралцах боломжийг олгон сурагчид өөрсдөө бие даан аливааг эргэцүүлэн бодож, задлан шинжлэх, бүтээлчээр сэтгэх орон зайг бий болгодог.

Ингэснээр хүүхэд НЭГ бүрийн оролцоо нэмэгдэж, багш нарын бүтээлч заах арга барил дээшилж сургуулийн хамт олон ХАМТДАА хөгжиж суралцахад ээлтэй орчин бүрддэг.

### “АЮУЛГҮЙ СУРГУУЛЬ” АРГАЧЛАЛЫН ХҮРЭЭ

Багшийн бүтээлч хамтын ажиллагааг дэмжих	Суралцахад ээлтэй орчин бүрдүүлэх	Сургуулийн засаглалыг бэхжүүлэх
Багш олон талт оролцооны аргад суралцан, хичээл үйл ажиллагаанд аргачлалын арга зүйг тусган ажилладаг.	Сургуулийн материаллаг болон сэтгэлзүйн орчныг сайжруулахад сургуулийн хамт олонд агуулга, аргазүйн дэмжлэг үзүүлж хамтран ажилладаг	Сургуулийн материаллаг болон сэтгэлзүйн орчныг сайжруулахад сургуулийн хамт олонд агуулга, аргазүйн дэмжлэг үзүүлж хамтран ажилладаг

### ИРГЭН ТӨСӨЛ<sup>33</sup>

Иргэний Боловсролын Төв ТББ (ИБТ) нь анх 1992 онд Төв Азийн хөгжлийн сан нэртэйгээр байгуулагдсан. 1995 оноос иргэний боловсролын сургалт, үйл ажиллагаа явуулж эхлэн 1997 онд одооны нэрээр ХЗДХЯ-нд бүртгүүлсэн. ИБТ нь иргэний боловсрол, төрийн бус байгууллагын менежмент, экологийн боловсрол

33 www.cce.mn



зэрэг чиглэлээр сургалт семинар зохион байгуулах, сургалтын хөтөлбөр боловсруулах, ном, сурах бичиг, гарын авлага хэвлэн нийтлэх, мэргэжлийн зөвлөгөө өгөх, үндэсний болон олон улсын хурал, семинар зохион байгуулах зэрэг үйл ажиллагаа явуулдаг.

### Үйл ажиллагааны үндсэн чиглэлүүд:

- Иргэний боловсролын хөтөлбөр
- Экологийн боловсролын хөтөлбөр
- Орон нутгийн иргэдийн оролцооны хөтөлбөр
- Залуучуудын хөгжлийн хөтөлбөр

Иргэний Боловсролын Төв 1996 оноос эхлэн “Иргэн төсөл”-ийг Монгол улсад хэрэгжүүлж эхэлсэн. Энэ хугацаанд Улаанбаатар хот болон 16 аймгийн нийт 250 гаруй ЕБС-ийн 1600 гаруй багш, 9000-аад сурагчийг хамруулжээ. “Иргэн төсөл”-д оролцогчид орон нутаг, сургууль дээрээ тулгамдсан асуудлаа тодорхойлох, судалгаа мэдээлэл цуглуулах, багаар ажиллах, асуудалд нотолгоо баримттай хандах, төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж дуу хоолойгоо хүргэх, олны өмнө асуудлаа тайлагнах, зэрэг олон ур чадварт суралцжээ.

## ИРГЭН ТӨСЛИЙН САЙН ТУРШЛАГУУД

- Оролцогч:** Ховд аймаг, Цаст-Алтай цогцолбор сургуулийн “Өөрчлөлтийн давалгаа” клуб
- Багш:** Б.Гэгээнжаргал
- Сонгосон асуудал:** Сургуулийн цайны газрын хоол хүнсний амт чанар эрүүл ахуйн шаардлага хангахгүй байна.
- Үр дагавар:** Багш, сурагчид амт чанаргүй цөөн төрлийн хоолоор эрүүл ахуйн стандарт шаардлага хангаагүй орчинд хооллоход хүрч байсан.

**Асуудлаа шийдвэрлэсэн арга:** Сургуулийн захиргаанд цайны газрын үйлчилгээ, хоол хүнсний амт чанар шаардлага хангахгүй байгааг дэмжсэн багш, сурагч, эцэг эхийн гарын үсгийн хамт шаардлага хүргүүлж, цайны газрын эзэн, Иргэн төслийн клуб, сургуулийн захиргаа гэсэн гурван талын уулзалт хэлэлцээр хийж, үр дүнд нь хамтран ажиллахаар шийдвэр гаргасан юм. Цайны газар шаардлагыг хүлээн авч цайны газрын зааландаа засвар хийж, хоолны цэсээ өөрчилсөн. Улмаар дараагийн хичээлийн жилд цайны газрын түрээслэгчээ сольсон

- Оролцогч:** Дорнод аймгийн Баян-Уул сумын “Улзын ундрага” баг
- Багш:** Б.Хандсүрэн
- Сонгосон асуудал:** Баян-Уул суманд хогийн сав хүрэлцэхгүй байна.

**Үр дагавар:** Сургууль, сумын орчинд ангилдаг хогийн сав байхгүйн улмаас хүн бүрийн эрүүл аюулгүй орчинд сурч хөдөлмөрлөх эрх зөрчигдөж, байгаль дэлхий бохирдож, өвчин гаргах, амьтан ургамал устгах эрсдэлтэй байна.

**Асуудал шийдвэрлэх ангийн бодлого:** Сум хөгжүүлэх сан, “УЛЗЫН ХӨГЖИЛ ОНӨААТҮГ”-ийн төсвөөр асуудлыг шийдвэрлэхэд сурагчид нөлөөлнө.

**Асуудлаа шийдвэрлэсэн арга:** 9-11 ангийн “Илтгэх урлаг” клубын 25 сурагчид 380 сурагчаас, 295 эцэг эх, 82 багш ажилчид нийт 757 хүнээс судалгаа авч боловсруулж, анализ дүгнэлт хийж сумын ИТХ, засаг дарга, ЗДТГ, сумын “Улзын хөгжил” ОНӨААТҮГ /хогны асуудал хариуцдаг/, байгаль орчны байцаагч, СНА, сургуулийн удирдлагуудад судалгаа дүнгээ танилцуулж, тулгамдаж буй асуудлаа шийдвэрлэх талаар ярилцжээ. Сурагчдын дуу хоолой, нөлөөллийн үр дүнд СУМ ХӨГЖҮҮЛЭХ САН, “УЛЗЫН ХӨГЖИЛ” компанийн 1.5 сая төгрөгийн санхүүжилтээр сургуулийн орчинд стандартын шаардлага хангасан ангилдаг хогийн савтай болсон. Маш удаашралтай явагдаж байсан сумын хогийн цэгийг бүрэн хашаалах ажлыг хурдасгахад нөлөөлсөн. Мөн “Иргэн төсөл” хичээлийн үр дүнд сурагчид асуудлаа судалгаа шинжилгээний дүнд олж харах, боловсруулах, дүгнэлт хийх, түүнийг шийдвэрлэх арга зам эрэлхийлэх, сумын төсөв санхүү, холбогдох асуудлын талаар хууль дүрэм, журам, шийдвэрүүдийг судалж, төрийн эрх мэдэл бүхий хүнд дуу хоолойгоо хүргэж, нөлөөлөх, шийдвэр гаргахад оролцож, хогийг дахин боловсруулах арга технологийн талаар судалсан. Бусад сурагчид, эцэг эх, төрийн байгуулагад сумын хэмжээнд хогийн сав хүрэлцэхгүй байгаа асуудлыг шийдвэрлэх нь манай сум, эх орон, эх дэлхийдээ оруулж буй хувь нэмэр, тогтвортой хөгжлийн боловсрол юм гэдгийг ойлгуулсан.

**Оролцогч:** Улаанбаатар хотын 6-р сургуулийн “Тэмүүлэл” баг

**Багш:** Ц.Тунгалагбаяр, С.Уянга

**Сонгосон асуудал:** Хөгжлийн бэрхшээлээс төрийн бэрхшээл их буюу хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд энгийн сургуульд сурах боломж байна уу?

**Үр дагавар:** Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд энгийн сургуульд сурч чадахгүй байна. Бараг бүх сургуульд тэдний сурах орчинг бүрдүүлээгүй байна.

**Асуудлаа шийдвэрлэсэн арга:** Сурагчид өөрсдийн сонгосон асуудлын хүрээнд Star TV, Eagle TV- ээр эрх ашиг нь зөрчигдөж, дуу хоолой нь сайн сонсогдохгүй байгаа үе тэнгийнхнийхээ асуудлыг шийдвэрлэхээр олон нийт, шийдвэр гаргагчдад дуу хоолойгоо хүргэсэн.

Нийслэлийн Боловсролын Газрын дарга, СБД-ийн Боловсролын хэлтсийн дарга, Шинэ эрин, 6, 20, 73-р сургуулийн захиралтай уулзаж тэдний ажлын үнэлгээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг энгийн сургуульд сурах боломжийг бүрдүүлэх санаачилгыг шалгуур үзүүлэлт болгох талаар ярилцсан. Сургууль дээрээ нөлөөллийн ажил зохион байгуулсны үр дүнд сургуулийн гаднах шатыг тэргэнцэртэй хүүхдэд зориулан налуу болгосон. Сургуулийн номын санд харааны бэрхшээлтэй, сонсголын бэрхшээлтэй сурагчдад зориулсан ном сурах бичиг, үйлчлүүлэх нөхцөл бүрдээгүй талаар санал хүргүүлсэн.

БСШУС-ын сайдын 2019 оны А\292 дугаар тушаалаар Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ЕБС-д тэгш хамран сургах журмыг баталсан нь бидний сонгосон асуудал тулгамдсан асуудал байсныг баталснаас гадна багийн гишүүд уг журмыг батлахад болон сургуулийн хамт олны хандлагад нөлөөлөхөд хувь нэмрээ оруулсан гэж үзсэн.



# СУРАГЧДЫН ШИВНЭЭ К



Galaxy S21 FE 5G

# ОРГИЛ ӨӨД КЛУБ ӨӨДРӨГ



БҮЛЭГ 5.

ДЭЛХИЙН ИРГЭНИЙ  
БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР

## БҮЛЭГ 5. ДЭЛХИЙН ИРГЭНИЙ БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨР<sup>34</sup>

### 5.1 ДЭЛХИЙН ИРГЭНИЙ БОЛОВСРОЛ: МЭДЛЭГ, ОЙЛГОЛТ

	3-5 нас	5-7 нас	7-11	11-14	14-16	16-19
Нийгмийн шударга ёс болон эрх тэгш байдал	Шударга, шударга бус гэж юуг хэлэх вэ? Халамжлах болон хуваалцахын ач холбогдол	Шударга байдал гэж юу вэ? Орон нутгийн хувьд болон бусад нөхцөлд ядуу ба баян байх гэж юу болохыг харуулсан жишээнүүд	Яагаад шударга ёс гэдэг нь адил тэгш хандахтай үргэлж утга нэг байдаггүй вэ? Орон нутаг, улс орон, дэлхийн түвшин дэх ядуурал болон тэгш бус байдлын (хүйсийн болон бусад) шалтгаан болон үр нөлөө	Ядуурал (харьцангуй болон үнэмлэхүй) ба тэгш бус байдлыг тодорхойлох болон хэмжих Нийгэм хоорондын болон нийгэм доторх тэгш бус байдал, түүний өөрчлөлт Ядуурал, тэгш бус болон гадуурхлын шалтгаан болон үр дагавар	Ядуурал болон тэгш бус байдлын суурь шалтгаанууд ба тэдгээрийн бодлого, эрх мэдэл, тогтолцоотой хамаарах хамаарал Ядуурал, тэгш бус байдлыг бууруулах янз бүрийн үзэл бодол Ядуурал болон тэгш бус байдлыг бууруулах үндэсний болон олон улсын санаачлагууд	Нийгмийн шударга ёс болон эрх тэгш байдлыг хангахад тулгардаг сорилт, бэрхшээлүүд Нийгмийн шударга ёс болон шударга ёс тогтоох талаарх ялгаатай үзэл бодол
Амин чанар ба олон талт байдал	Хүн нэг бүрийн онцгой шинж байдал ба үнэ цэн Миний болон бусад хүний адил ба ялгаатай зүйлс	Орон нутгийн болон өргөн хүрээнд хүмүүсийн ялгаатай ба адил төстэй талууд Өөрийн амин чанар болон харьяалагдах мэдрэмжид хувь нэмрээ оруулдаг зүйлс	Өөрийн үзэж туулсан болон үзэж туулаагүй нийгэм соёлын олон янз байдал Ялгаатай соёлын бидний амьдралд оруулж буй хувь нэмэр Өрөөсгөл ойлголт болон арьс өнгө, хүйсээр ялгаварлахын мөн чанар ба тэдгээртэй тэмцэх аргууд	Олон талт байдлын ашиг тус болон сорилт Ялгаварлан гадуурхалт, өрөөсгөл болон хэвшмэл ойлголтын нөлөө ба тэдгээртэй хэрхэн тэмцэх талаар Соёлын амин чанарт хэл, үнэ цэнэт зүйлс, итгэл үнэмшлийн ач холбогдол	Өрөөсгөл ойлголт, ялгаварлан гадуурхалт, гадуурхалд хэлний гүйцэтгэх үүрэг Хүмүүсийн өнөөгийн соёл, амин чанар, эрх мэдэлд түүхэн үйл явдлын (боолчлол, колоничлол зэрэг) үзүүлсэн нөлөө	Амин чанарын олон талт, уян хатан мөн чанар Давамгай соёлын дэлхий ертөнцийг харах, ойлгох тодорхой арга замыг сурталчилж, бусдыг ноёлох хандлага

<sup>34</sup> Education for Global Citizenship (A guide for schools), OXFAM

Даяарчлал болон харилцан хамарал	Эргэн тойрны болон орон нутгийн орчин Бусад газруудтай холбогдох энгийн холбоосууд (хоол хүнсээр дамжуулан гэх мэт)	Өөрийн болон дэлхийн янз бүрийн газар нутгийн ижил төстэй болон ялгаатай талууд Орон нутаг ба олон улсын холбоо	Хүмүүс болон улс орнуудын харилцаа холбоо (жишээлбэл: худалдаа болон харилцаа холбоогоор холбогдсон) Орон нутгийн хэмжээнд хийсэн үйлдэл дэлхийн түвшинд хэрхэн нөлөөлдөг вэ?	Дэлхийн болон орон нутгийн асуудал хоорондын холбоо, харилцан хамаарал Дэлхийг хүчнүүд болон тэдгээрийн хүмүүсийн амьдралд үзүүлэх нөлөөг өөрчлөх Орон нутаг, үндэстэн, эсвэл дэлхийн түвшинд гаргасан шийдвэрийн хүмүүс болон хил дамнан байгаль орчинд үзүүлэх нөлөө	Даяарчлалын ба дэлхий нийтийн асуудлуудын нарийн төвөгтэй байдал Баян, ядуу орнуудын эрх мэдлийн тэнцвэргүй байдал, түүний нөлөө Дэлхийн эдийн засаг, улс төрийн тогтолцоо	Баялаг болон тэгш бус байдалд даяарчлалын олон түвшинд үзүүлэх нөлөө Худалдаа, санхүүгийн урсгал, хүмүүсийн шилжилт хөдөлгөөн, дэлхийн засаглалыг авч үзэх янз бүрийн арга-хандлагын талаарх шүүмж Даяарчлалын засгийн газар болон хүй олонд авчирдаг боломж, бэрхшээл
Тогтвортой хөгжил	Амьд биет ба тэдгээрийн хэрэгцээ Ойр орчноо хэрхэн арчлах талаар Ирээдүйд өөрчлөлт гарах боломж	Хүмүүсийн (чиний өөрийн) үйл ажиллагааны бусдад болон хүрээлэн буй орчинд үзүүлэх эерэг ба сөрөг нөлөө Хүмүүс байгаль орчныг хэрхэн сүйтгэж эсвэл хайрлаж хамгаалдаг вэ?	Хүмүүсийн байгаль орчноос хамааралтай байдал Уур амьсгалын өөрчлөлтийн үндэс (учир шалтгаан ба үр дагавар) Байгаль орчинд хариуцлагатай хандаж амьдрах ба экологийн ул мөр дэх дэлхийн тэгш бус байдал	Хөгжил болон амьдралын чанар, тэдгээрийг хэрхэн хэмжих талаарх ялгаатай үзэл бодол НҮБ-н Тогтвортой хөгжлийн зорилгууд болон гарч буй ахиц дэвшил Биологийн олон талт байдлын ач холбогдол Уур амьсгалын өөрчлөлтийн өргөн хүрээний учир шалтгаан болон үр дагавар	Тогтвортой байдал болон хөгжил-дилемма Шинжлэх ухааны нээлт болон технологийн хөгжлийн ёс суртахуун, ёс зүй, нийгэм, эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх нөлөө-үр дагавар Засгийн газар, аж ахуй нэгж, иргэний нийгмийн байгууллага болон иргэний тогтвортой хөгжилд гүйцэтгэх үүрэг	Хөгжлийн онолууд болон түүний талаарх шүүмж Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын маргаантай мөн чанар Хөгжилд хувь хүн болон хүй олныг оролцуулах, эрхмэдэлжүүлэх үүрэг
Энх тайваг ба нөөц	Өөрийн тань үйлдэл ямар үр дагавартай байдаг вэ?	Хувь хүн, анги, гэр бүлийн түвшинд санал зөрөлдөх, зөрчилдөх шалтгаан	Хувь хүн хоорондын зөрчилдөөнөөс эхлээд дэлхийн түвшин дэх бүхий л түвшний зөрчилдөөний учир шалтгаан болон үр дагавар	Бүх түвшний зөрчилдөөний учир шалтгаан болон үр дагавар	Шударга ёс энх тайван хоорондын холбоо, энх тайван удаан тогтох нөхцөл	Зөрчил мөргөлдөөний нарийн төвөгтэй байдал болон яагаад заримыг нь шийдвэрлэхэд илүү хүнд байдаг талаар

Зөрчилдөөнөөс зайлсхийх, зөрчилдөөнийг удирдах, шийдвэрлэх, үндсэн аргууд	Зөрчилдөөнөөс зайлсхийх, зөрчилдөөнийг удирдах, шийдвэрлэх зарим аргууд	Зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлэх, зөрчилдөөнийг харилцан ашигтай болон бусад байдлаар шийдвэрлэх, удирдах стратегиуд Өөрийн ба бусад нийгмийн өнгөрсөн болон өнөө үеийн зөрчилдөөний жишээнүүд	Зөрчилдөөнийг шударгаар шийдвэрлэхийн ач холбогдол Нийгэм болон улс төрийн өөрчлөлтийн төлөө хүчирхийллийн бус тэмцлийн үүрэг	Зөрчилдөөний зэрэг болон бүтээлч үр дүн Шударга дайны онол ба түүний талаарх шүүмж	Үндэсний болон дэлхийн түвшинд өөрчлөлт хийх нөхцөлийг бүрдүүлэхэд зөрчилдөөний гүйцэтгэх үүрэг
Хүний эрх	Сургууль, анги дахь эрх Бусдын эрхийг хүндэтгэх хэрэгцээ, шаардлага Хүний үндсэн эрх ба хүмүүсийн үндсэн эрх хэрхэн зөрчигдөж байгаа талаар	Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенц Зарим хүний эрх зөрчигдөж байгаа шалтгаан Эрхийг хангах үүрэгтэй хүмүүс (багш, орон нутгийн удирдлага, Засгийн газар)	Хүний эрхийн түгээмэл тунхаглал Иргэн, нийгэм, засгийн газрын хүний эрхийг хүндэлж, хамгаалахын ач холбогдол Өөрийн болон бусад улс дахь хүний эрхийн түүхэн болон өнөөгийн асуудал, хөдөлгөөн	Хүний эрхийн зөрчлийн суурь шалтгаанууд болон тухайн нөхцөл байдалд хүний эрхийг дэмжих буюу дордуулдаг улс төр, хууль эрх зүй, нийгэм-соёл, шашин, эдийн засгийн хүчин зүйлүүд Хүний эрхийн талаар төрийн хүлээх үүрэг	Хүний эрхийн түүх болон философи Хүний эрхийн талаар ба түүний түгээмэл, салшгүй, харилцан хамааралтай шинж чанарын талаарх маргаан
Эрх мэдлэг ба засаглал	Өөрийн анги болон сургуульд дүрэм журам тогтоох болон өөрчлөхөд хэрхэн оролцох талаар Эрх мэдлийн тэгш бус хуваарилалт болон зарим хүмүүсийг шийдвэр гаргалтад хэрхэн оролцуулдаггүй вэ?	Анги болон илүү өргөн хүрээн дэх дүрэм журмын хэрэгцээ ба хүмүүс дүрэм журам гаргах болон өөрчлөхөд хэрхэн оролцох вэ? Бүс нутаг болон улс орныг хэрхэн удирддаг талаарх үндсэн ойлголт	Үндэстэн, бүс нутаг (жишээ нь: ЕХ) дэлхийн засаглалын бүтэц, тогтолцоо болон улс хоорондын ялгаа Төлөөлөлгүй болон эрх мэдэлгүй байдал нь ялгаварлан гадуурхалт болон гадуурхагдах/орхигдох байдалд хэрхэн хүргэдэг талаар Хамтын үйлдлийн хүч болон шударга бус явдалтай тэмцэхэд засгийн газар болон нийгмийн хөдөлгөөний үүрэг	Дэлхийн засаглалын бүтэц, үйл явц Дэлхий дахинд тулгарч буй сорилт бэрхшээлийг давах олон улсын хамтын ажиллагаа Байгууллага эсвэл улс орны эрх мэдэл, нөлөө өргөжин тэлэх нь тэдгээрийн соёл, хандлага, туршлагад хэрхэн нөлөөлдөг талаар	Хувь хүн, бүлэг, улсын болон хувийн сектор хэрхэн дэлхийн засаглалд оролцох вэ? Улс орнуудын эрх мэдлийн тэгш бус байдал нь дэлхийн асуудалд хэрхэн нөлөөлдөг талаар Дэлхий, үндэстэн, орон нутгийн түвшинд иргэншил ба иргэний оролцоонд саад учруулж буй хүчин зүйлүүд

## 5.2. ДЭЛХИЙН ИРГЭНИЙ БОЛОВСРОЛ: УР ЧАДВАР

	3-5 нас	5-7 нас	7-11	11-14	14-16	16-19
Шүүн тунгаах болон бүтээлч сэтгэлээ	Асуулт асуух Асуудлыг шийдвэрлэх арга замыг санал болгох Олон янзын санааг мэдэхийг хүсэх	Хамааралтай асуулт асуух Ялгаатай үзэл бодлын ач тусыг авч үзэх Асуудлыг шийдвэрлэхэд олон арга-хандлага хэрэглэх	Өрөөсгөл ойлголт, үзэл бодлыг тодорхойлж эхлэх Өөрийн санаа/байр сууриа нотлох, ялгаатай үзэл бодлыг үнэлж, эсрэг аргумент/нотолгоо гаргах Өөр боломжит хувилбаруудыг харж, асуудлыг шийдэх шинэ санаа санал болгох	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад эх сурвалжийг өрөөсгөл, хэвшмэл ойлголт, олон янзын дуу хоолой, үзэл санааны хувьд ямар байгааг үнэлэх Хүн ба аливаа асуудлын талаарх өөрийн болон бусдын таамаглалыг үнэлж, дүгнэх Шинэ санааг нээлттэйгээр хүлээж авах	Асуудлын талаархи олон өнцгийн хэтийн төлөв, аргумент, нотолгоог үнэлж, нэгтгэж, статистикийн хэрэглээнд дүн шинжилгээ хийж эхлэх Цаад үнэ цэнэ, таамаглалыг тодорхойлох Санаа ба мэдээллийг холбох	Дэлхийд тулгарч буй сорилтуудыг шийдвэрлэх ялгаатай арга-хандлагуудыг үнэлэх Эрх мэдэл нь үзэл бодол, дуу хоолой, шийдвэр гаргалт, засаглал, мэдлэгийг бий болгоход хэрхэн нөлөөлж байгааг үнэлэх Санаа бодлыг нэгтгэж, орон нутгийн болон дэлхийн асуудалд шинэ шийдэл боловсруулахад оролцох
Бусдын оронд өөрийгөө тавьж өөрийнхн ч үүднээс ойлгох чадвар	Хүмүүсийн мэдрэмж болон хэрэгцээг таних, ойлгох	Хүмүүсийн мэдрэмжийг таниж, санаа тавих Ойрын хүрээллийн бус болон өөрөөс нь ялгаатай нөхцөлд байгаа хүнийг анхаарч, санаа тавих	Бусдын мэдрэмжийг харгалзан өөрийн зан авираа тохируулах Орон нутгийн болон алс холд байгаа хүмүүст анхаарлаа хандуулах, ойлгох Ялгааварлан гадуурхал, ташаа ойлголтын үр дагаврыг ойлгох	Үг хэллэг, биеийн хэлэмж, дохио зангаа, өнгө аясаар дамжуулан хүмүүст ямар мэдрэмж төрж байгааг олж мэдэх Хүмүүсийн итгэл үнэмшил, амьдралын нөхцөл, хувийн шинж чанар нь зан төлөв болон ертөнцийг үзэх үзэлд хэрхэн нөлөөлдөг талаар ялган таних	Өөрийгөө бусдын оронд тавьж сонсох Дэлхий ертөнц, орон нутгийн болон дэлхийн асуудлыг өргөн хүрээгээр харах	Хүмүүсийн нийгэм, эдийн засгийн байдал нь аливаа нөхцөл байдлыг хэрхэн харах болон сонголт хийхэд нөлөөлдгийг ойлгох Тухайн нөхцөлд олон янзаат оролцогчдын сэдлийн нарийн төвөгтэй байдлыг ойлгох
Өөрийгөө танин мэтэх, арга үүднээс танин	Мэдрэмжээ таних, нэрлэх, эерэгээр илэрхийлэх, үйлдэх	Өөрийн зан үйлийн бусдад хэрхэн нөлөөлж байгааг ойлгож, сонголт хийхдээ ашиглахад туслах	Хувийн шийдвэр ба орон нутаг, дэлхийн хэмжээнд хүмүүст нөлөөлж буй асуудлын уялдаа холбоог тодорхойлох	Өөрийн давуу болон сул талаа таньж мэдэх	Ертөнцийг үзэх үзэлд соёлын нөлөө байдгийг ойлгож өөрийн үзэл бодлын хязгаарлалтыг танин мэдэх	Өөрийн үнэт зүйлсэд дүн шинжилгээ хийж, тодруулж, эдгээр нь сонголт, амьдралын хэв маягт хэрхэн нөлөөлж байгааг үнэлэлт дүгнэлт хийж

	Өөрийн үйлдлийн бусдад үзүүлэх үр нөлөөг анзаарч мэдэх Хүмүүсийн мэдрэмжийг тодорхойлох (аз жаргалтай, гунигтай, санаа зовсон)	Өөрт болон бусдад чухал зүйлийг тодорхойлох Алдаанаас суралцах болон бусдын өгсөн санал зөвлөмжийг ашиглах	Бусад хүмүүсийн талаар эсвэл шинэ, хүнд нөхцөл байдалд сөрөг мэдрэмжтэй байдаг шалтгаанаа нээн илрүүлэх	Өөрийн сэтгэл хөдлөл, үг, үйлдэл нь орон нутаг болон дэлхийн хэмжээнд хүмүүст хэрхэн нөлөөлж болохыг үнэлэх	Туршлага, эрдэм мэдлэг, санал зөвлөмжийг үнэлж, ирээдүйн суралцах үйл, бодож сэтгэх, үйлдэлдээ ашиглах	Нийгэм, соёл, түүхийн нөхцөл байдлаас шалтгаалан бидний оюун санаа хэрхэн бүрэлддэг, энэ нь аль нэг асуудлын талаарх бидний оюун санаанд хэрхэн нөлөөлдөг талаар Дэлхийн иргэн байх гэж юу вэ? гэдэг талаар өөрийн ойлгосноо илэрхийлэх
Харилцаа	Бусдыг сонсох Ээлжилж үзэл бодлоо илэрхийлэх	Өөрт, бусдад болон дэлхий нийтэд нөлөөлж буй асуудлын талаарх хэлэлцүүлэгт оролцох Үзэл бодлоо илэрхийлж, үүнийхээ шалтгааныг тайлбарлаж эхлэх Бусдыг анхааралтай сонсох	Бусдыг анхааралтай сонсож, асуулт асуух болон хариулт өгөх Олон янзын зохимжит аргыг ашиглан тухайн асуудлаар өөрийн санаа, үзэл бодлыг ойлгомжтой илэрхийлэх Өөрийн үзэл бодлыг батлах үндэслэл, нотолгоо, жишээ гаргах	Асуудлын талаар сэдэв, үзэгч, зорилгод нийцэхүйц төрөл бүрийн сургаар үр бүтээлтэй харилцах Идэвхтэй сонсох үр чадварыг ашиглах Шинэ соёлын орчинд зан үйлээ зохицуулах тааруулах	Дэлхий нийтийн тулгамдсан асуудлын талаар саруул ухаанаар, итгэж үнэмшихүйцээр мэтгэлцэх Янз бүрийн бүлгүүдэд харилцааны арга хэрэгсэл, агуулга, төрх янзын үзүүлэх нөлөөллийг шинжлэх	Бусдын үзэл бодлыг сонсож, эргэцүүлж, үнэлж цэгнэн, зохих ёсоор хариулах Соёл хоорондын харилцааны сорилтуудыг тодорхойлж, шийдвэрлэх
Хамтын ажиглалтаа болон зөрчилдөөнийг шийдвэрлэх	Бүлгийн үйл ажиллагаанд оролцох Хуваалцах болон ээлжлэх Маргааныг эв зүйгээр шийдэх	Хамтарч тоглох болон ажиллах Бүлгийнхээ хүн бүрийг тэгш хамруулахад туслах Ая данг тааруулан эелдэг төлөв харилцаж эхлэх	Асуудлыг шийдэх болон зорилгод хүрэхийн төлөө хамтарч ажиллах Уур, бухимдал, түрэмгий занг удирдах арга барил ашиглах Асуудлыг шийдвэрлэх болон харилцан буулт хийхэд бусдын үзэл бодлын талаарх мэдлэгээ ашиглах	Бүлгийн ажилд янз бүрийн үүрэг хүлээх Таарамжгүй харилцааг сайжруулах үр дүнтэй стратеги ашиглах	Бүлэгт гүйцэтгэсэн манлайлал болон бусад үүргийн талаар эргэцүүлэн бодох Зарим зөрчилдөөнийг харилцан ашигтай шийдвэрлэх шийдлийг тодорхойлох Зөрчилдөөнийг шийдвэрлэхдээ үзэл бодол болон соёлын хэм хэмжээ болон олон янзын үзэл бодолд мэдрэмжтэй хандах	Үе тэнгийнхэн болон насанд хүрэгчидтэй үр дүнтэй хэлэлцээ хийх Маргааныг зохицуулах Зөрчилдөөнийг удирдах, шийдвэрлэхэд олон янзын стратеги ашиглах

Тодорхойгүй болон ээдрээтэй нөхцлийг үлдирдэг чадвар	Юу хийхээ мэдэхгүй бол туслаж хүсэх	Өөрийн амьдрал, орон нутагт гарч байгаа өөрчлөлтийн талаарх мэдрэмжээ дүрслэн ярих	Өөрийн орон нутаг болон дэлхий ертөнцөд гарч буй өөрчлөлт, үйл явдлын талаарх мэдрэмжээ дүрслэх	Шинэ нөхцөлд дасан зохицох, орон нутгийн болон дэлхийн асуудлыг харах шинэ арга замыг нээн илрүүлэх	Дэлхий дахиныг хамарсан асуудлыг таньж мэдэх, бодож эргэцүүлэх, үйлдэл хийхдээ шинэ эсвэл сайжруулсан үзэл санааг нэгтгэн ашиглах	Амьдралдаа хариуцлагатай хандаж, ухаалаг сонголт хийх  Өөрчлөгдөж буй хэрэгцээ, харилцааг эерэгээр хүлээн авч шийдвэрлэх
	Өөрийн амьдрал, орон нутагт гарч байгаа өөрчлөлтийн талаарх мэдрэмжээ дүрслэн ярих	Өөрийн сорилтыг даван туулах стратеги ашиглах	Цаг үеийн сорилтыг даван туулах стратеги ашиглах	Ирээдүйн талаарх олон янзын болон альтернатив үзэл санааг судлах	Зорилгоо хүрч болохуйц алхмуудад хувааж, бэрхшээлийг урьдчилан харж, даван туулах	

### 5.3 ДЭЛХИЙН ИРГЭНИЙ БОЛОВСРОЛ: ҮНЭТ ЗҮЙЛ, ХАНДЛАГА

	3-5 нас	5-7 нас	7-11	11-14	14-16	16-19
Мэдээлэлд тулгуурлан эргэцүүлсэн үйлдэл	Ангидаа болон бүлэгтээ бусдыг дэмжих	Өөрийн анги, сургуулийн амьдралд идэвхтэй оролцож, бүтээлч хувь нэмэр оруулах  Ямар нэг зүйл шударга бус санагдвал үйлдэл хийх	Сургууль дээрх шийдвэр гаргалтад оролцох  Өөрийн орн нутгийн сайн сайхан байдалд хувь нэмрээ оруулах  Сонгогдсон төлөөлөгчид, шийдвэр гаргагчид болон бусад хүмүүстэй аливаа асуудлын талаарх үзэл бодол, баримт нотолгоогоо хуваалцах	Өөрийнхөө дуу хоолойг хүргэх зохистой үйлдэл, боломжийг тодорхойлж төлөвлөх  Тэгш бус байдал, шударга бус байдлыг хадгалах, үргэлжлүүлэх үзэл бодлыг эсэргүүцэх  Өөрийн хийсэн үйлдлээсээ сурсан зүйлээ эргэцүүлэх	Өөрийн хандлага, төсөөлөл, зан үйлд шүүмжлэлтэй хандах хэрэгтэйг ойлгох  Сонгогдсон шийдвэр гаргагчдын үүргийг ойлгох болон тэдэнд хэрхэн нөлөөлөх талаар мэдэж авах  Тохиромжтой зорилго сонгож, түүнд хүрэх үйл ажиллагааны чиглэлээ төлөвлөх	Дэлхий дахинд тулгамдсан асуудалд олон талын оролцогчдын үзүүлэх нөлөөг үнэлэх, тэдгээрт хэрхэн нөлөөлж болох талаар судалж үзэх  Холбогдох улс төрийн үйл явцад оролцох  Дэлхий дахинд тулгамдсан асуудлыг нээн илрүүлэх болон түүнд чиглэсэн үйлдэл хийхэд бусдыг манлайлах

Өөрийн амин чанарыг мэдэрх болон өөртөө итгэх	Өөрийгөө болон өөрийн онцлог шинжээ ойлгож мэдэх Өөрийн болон бусдын үнэ цэнийг мэдрэх	Харъяалагдах мэдрэмж авах болон бусадтай харилцах харилцаагаа үнэ цэнэтгэйд тооцох Өөрийн онцлог шинж чанарын талаар мэдэж, бахархах	Бусадтай адилхан болон бусдаас ялгаатай аль ч байдалдаа сэтгэл хангалуун байх Өөрийн амин чанарт хувь нэмэр оруулж буй зүйлсийг үнэ цэнэтэй гэж үзэх	Өөрийн болон бусдын хувийн онцлог шинжийг үнэлэх Өөрийгөө сорьж буй шинэ санал бодол, байр суурьд нээлттэй хандах	Орон нутгийн болон дэлхийн түвшин дэх хүмүүсийн харилцан уялдаа холбоо, харилцан хамаарлыг талархан хүлээн авах Орон нутаг болон дэлхийд харъяалагдах мэдрэмж авах	Хувь хүний амин чанарын олон талт, уян хатан шинж чанарыг талархан хүлээн авах
Нийгмийн шударга ёс, эрх тэгш байдал, ядуурлыг	Шударга байдлын мэдрэмж Ээлжлэх болон хуваалцах хүсэл эрмэлзлэл	Бусдын төлөө босох, дуугарах хүсэл эрмэлзлэл Бусадтай харилцахдаа шударга хандах	Орон нутаг болон дэлхийн хэмжээнд бусдад шударга бус хандсан явдалд дургуйцэх, Шударга ёсны мэдрэмж Дэлхийд болж байгаа үйл явдал, асуудлыг илүү ихээр сонирхох	Шударга бус байдал, мөлжлөг, хүний эрхийг үгүйсгэсэн асуудалд идэвхтэйгээр анхаарал хандуулах, санаа зовох Шударга бус байдал, тэгш бус байдлын эсрэг үйлдэл хийх хүсэл эрмэлзлэл	Орон нутгийн болон дэлхийн асуудалд хувийн ба хамтын хариуцлага хүлээх мэдрэмж Орон нутаг, улс орон, дэлхийн хэмжээнд нийгмийн шударга ёс, тэгш байдлыг хангахыг дэмжсэн үйл ажиллагаанд оролцох хүсэл	Ардчиллын зарчим болон нийгмийн шударга ёс, эрх тэгш байдал, ядуурлыг арилгахын төлөө зүтгэх
Хүнийг болон хүний эрхийг	Бусдыг бодож эхлэх	Бусдын санаа бодол, мэдрэмжийг хүндэтгэх Бусдын эрхийг хүндэтгэх Хүн бүр тэгш эрхтэй гэсэн итгэл, үнэмшил	Үг, үйлдэл, сонголтынхоо бусдад үзүүлэх үр дагаврыг бодож тунгаахад бэлэн байх Ялгаварлан гадуурхал, өрөөсгөл ойлголтын эсрэг сөрөх нь хүн бүрийн үүрэг гэсэн итгэл, үнэмшил	Эрх нь зөрчигдөж, шударга бус хандлагад өртөж, ялгаварлан гадуурхагдаж байгаа хүмүүстэй эв санааны нэгдэлтэй байх мэдрэмж Хүн бүрийн тэгш эрхийг хангуулахыг тухайн үүрэг хүлээгчдээс шаардах зүтгэл	Өнөө болон хойч үеийн эрх, хэрэгцээг хүлээн зөвшөөрөх	Хүний эрхийг хамгаалахад тууштай зүтгэх



**ХАВСРАЛТ**

## ХАВСРАЛТ 1

# ЭНХТАЙВАН, ХҮНИЙ ЭРХ, ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ БОЛОВСРОЛЫН ЮНЕСКОГИЙН БОЛОВСРОЛЫН ЗӨВЛӨМЖ (ТАЙЛБАР)<sup>35</sup>

## ХЭНД уг зөвлөмжийг зориулсан бэ?

Тус зөвлөмжийг боловсролын салбарт болон хамаарах бусад салбарт ажиллаж байгаа хувь хүн, мэргэжилтнүүдэд нэгэн зэрэг хамаарах, ашиглах боломжтой. Сонирхсон хүн бүр гэдэгт хууль тогтоогч, бодлого боловсруулагч, Боловсролын яамны мэргэжилтэн, багш, боловсролын байгууллагын ажилтан, сургалтын хөтөлбөр боловсруулагч, сургуулийн удирдлага, суралцагч, өв уламжлал тээгч, албан бус боловсролын сургагч, орон нутгийн магнайлагч, гэр бүл, асран хамагалагч, хувь шинжээч, судлаач, академик болон иргэний нийгмийн байгууллага, үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл багтана.

Зөвлөмж нь хүчирхийлэл, харгис үзэл номлолоос урьдчилан сэргийлэхээр зорьж байгаа, энх тайвныг цогцлоох санаачилга, зөрчилдөөний дараах нөхөн сэргээх үйл явцад идэвхийлэн оролцож байгаа, нийгмийн шударга ёс, хүний эрх, тогтвортой хөгжлийг улам ихээр хөхиүлэн дэмжиж байгаа хүмүүст ч тустай.

## Энэхүү зөвлөмж ӨӨРЧЛӨЛТ авчрахад хэрхэн туслах вэ?

Тус зөвлөмж бол үйл хэрэгт уриалахын хамт нөлөөллийн арга хэрэгсэл, үнэлэх хэмжүүр болно.

### Үйл хэрэгт уриалга болохын хувьд

Боловсролын салбарт сонирхолтой, мөн оролцож байгаа хүн нэг бүрд урам зориг төрүүлнэ.

### Нөлөөллийн арга хэрэгслийн тухайд

Бодлого боловсруулах, өөрчлөхөд нөлөөлж чадна.

### Үнэлэх хэмжүүр байснаар

Суралцагчдыг идэвхтэй, хариуцлагатай өөрчлөлт авчрах төлөөлөгч болгохоор боловсролын тогтолцооны бэлдэж байгаа явц, ахиц дэвшил, хамарсан хүрээгээ харахад ашиглаж болно.

<sup>35</sup> Recommendation on Education for Peace, Human Rights and Sustainable Development (an explainer), UNESCO, 2024

## ЮУгаараа уг зөвлөмж онцгой билээ?

- Хүний эрхэд түшиглэсэн товч тодорхой заавар бөгөөд боловсролоор дамжуулан хэрхэн энх тайван цогцлооход туслах, зөрчилдөөн, хүчирхийлэл үүсгэж байгаа олон тооны, гүн гүнзгий нөхцөлдсөн суурь шалтгаанд анхаарч ажиллах, хүмүүст илүү шударга, эрүүл, тогтвортой нийгмийн бий болгоход тустай мэдлэг, ур чадвар олгодог болно.
- Зөвхөн сургуулиар хязгаарлахгүй амьдралын туршид боловсролын бүх хэлбэр, төрөл, түвшинг хамардаг.
- Боловсролын салбарын бүх бүрэлдэхүүнд (үндэсний хөтөлбөр боловсруулах, үнэлэх, багш хөгжүүлэх, заах материал, сургуулийн бодлого гэх мэт), түүнчлэн сургалтын уламжлалт орчноос гадна суралцахуйд заавар хамаатай байдаг.
- Засаг төр, иргэний нийгмийн талууд гээд өргөн цар хүрээнд боловсролын оролцогч талуудад хүрдэг.

## Тухайн баримт бичиг ЮУ агуулна вэ?

Баримт бичиг нь “Оршил”, “Үйл ажиллагаанд чиглэсэн зөвлөмж” бүхий догол мөр, Хавсралт гэсэн хэсгээс бүрдэнэ. Тухайлбал, баримт бичгээс дараах агуулга үзэх боломжтой.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Ерөнхий бага хурлаар баталсан нэр томъёоны цөөн **тодорхойлолт** бий. Учир нь эдгээр тодорхойлолтын агуулгыг нэг бүрээр Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын Гишүүн Улсууд хүлээн зөвшөөрч, зөвшилцөн баталсан юм.

\*\*\*\*\*

Хувь хүнд төдийгүй боловсролын тогтолцоог өөрийг нь бодитой хувирган өөрчлөхүйц туршлага суралцахдаа олж авах нөхцөл бүрдүүлэхийн тулд боловсролын тогтолцооны бүх бүрэлдэхүүнд зориулсан **14 удирдах зарчим** байна.

\*\*\*\*\*

Үндэсний хөтөлбөрөө загварчлах, мөн суралцахуйн бүх үйл ажиллагааг зааварлахын тулд **суралцахуйн зорилтын** өргөн дэлгэр жагсаалт бий.

\*\*\*\*\*

**Үйл хэрэг өрнүүлэх хүрээг жагсаасан** байгаа нь өнийн энх тайван, олон улсын ойлголцол, хамтын ажиллагаа, хүний эрх, дэлхийн иргэншил, тогтвортой хөгжлийг цогцлоохын тулд боловсролын тогтолцоо ажилладаг байлгахад хувь хүн, бүлэг этгээд юу хийж болох вэ гэдгийг дүрслэн харуулсан юм.


## ХУВИРГАН ӨӨРЧЛӨХ БОЛОВСРОЛ РУУ УДИРДАН ЗАЛАХ НЬ

Боловсролын бодлого, хөтөлбөр, үйл ажиллагаа нь Зөвлөмжийн зорилготой шууд уялдах ба хувирган өөрчилсөн, сайн чанартай боловсрол байвал зохино. Үүнийг 14 удирдах зарчим байдлаар боловсролын хууль тогтоомж, бодлого, стратеги, үндэсний хөтөлбөр, заах арга зүй, багшийн хөгжил, үнэлгээ, заах, суралцах материал, суралцах орчин гэх мэтчилэн (албан, албан бус, амьдралаас суралцахуй байх үл хамааран) боловсролын хэмжигдэхүүнд бүрд хамааруулан боловсруулав.

Хүний эрхэд суурилсан	Насан туршийн, тасралтгүй үргэлжилсэн, хувирган өөрчилсөн
Хүртээмжтэй, сайн чанартай (боловсрол нь бүх нийтийн, нийтийн сайн сайхан гэж тооцох)	Мэдлэг хамтдаа бүтээх үйл явцыг хөхиүлэн дэмжсэн
Үл ялгаварласан	Үзэл бодол, итгэл үнэшил, шашин, илэрхийлэлтэй байх эрх чөлөөг биелүүлж, үзэн ядах бүх хэлбэрийг өдөөж байгааг арилгасан
Халамж, энэрэл, эв санааны нэгдэлд хүрсэн ёс зүйг өөриймшүүлсэн	Оролцуулсан, түүнчлэн технологийн ёс зүйтэй, хариуцлагатай хэрэглээг ашигласан
Жендэрийн эрх тэгш байдлыг сайжруулсан	Орон нутгийн, олон улсын түвшинд холбоо харилцааг тодотгож олон улсын болон дэлхийн өнцөг тусгасан
Тэгш боломж олгосон, тэгш хамарсан, ялгаатай байдлыг хүндэтгэсэн	Соёл, үе хоорондын яриа хэлэлцээг хөхиүлэн дэмжсэн
Суралцагч, багш, боловсролын байгууллагын ажилтны аюулгүй байдал, эрүүл мэнд, сайн сайхан байдлыг баталгаажуулсан	Дэлхийн иргэншил, энх тайван, хүний эрх, тогтвортой хөгжлийг хүн бүрийн тусын тулд зориулах хамтын хариуцлагын ёс зүйг өөриймшүүлсэн

## МЭДЛЭГ, УР ЧАДВАР, УР ЧАДВАР, ҮНЭТ ЗҮЙЛС ХАНДЛАГА, ЗАН ҮЙЛД ХӨГЖҮҮЛЭХ СУРАЛЦАХУЙН ЗОРИЛТ


Зөвлөмжийн зорилгод хүрэхийн тулд боловсролын үйл ажиллагаа, хөтөлбөр нь дараах суралцахуйн зорилтод хүрсэн байхын төлөө зорьсон байна.



Эдгээр ур чадварыг олгохын тулд заах, сурах янз бүрийн хандлага ашиглаж, танин мэдэхүйн, нийгмийн, сэтгэл хөдлөлийн, зан үйлийн суралцахуйг бүрэн ашиглах шаардлагатай.

## ҮЙЛ ХЭРЭГ ӨРНҮҮЛЭХ ГОЛ ХҮРЭЭ

Удирдах зарчим, суралцах зорилтын хамт Зөвлөмжид тогтолцоогоо өргөн хүрээгээр хамран, цогц байдлаар хандах замаар боловсролын харилцан адилгүй түвшинд үйл хэрэг рүү чиглүүлсэн үйл ажиллагааг (техникийн шинжтэй зөвлөмж) тодорхойлжээ. Эдгээр зөвлөсөн үйл ажиллагаа нь боловсролын бүх түвшин, төрөл, (албан бус болон албан боловсрол) боловсролын тогтолцооны хэмжигдэхүүн хамаарч байна.



## ҮЙЛ ХЭРЭГ БОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИШЭЭ

Зөвлөмж нь өргөн хүрээг хамарсан үйл ажиллагааг гардан хэрэгжүүлэхийг уриалдаг.

- Сурах бичиг нь арьс үндсээр алагчлах үзлийг таслан зогсоосон, өрөөсгөл, хэвшмэл үзлээс ангид байхаар бичих;
- Соёлын өвийг илүү сайн ойлгохын тулд боловсролын туршлагад нь соёл, урлагийг сайтар тусгаж холбох;
- Түүх заахдаа олон янзын, харилцан адилгүй өнцгийг тусган оруулах;
- Багшийн илэрхийлэх, үзэл бодлолтой байх эрх чөлөө, мэдээлэл нэвтрэх боломжийг баталгаажуулах;
- Аюулгүй, тэгш хамарсан дижитал суралцахуйн тогтолцоо, орчинг хөгжүүлэх, хувь хүний болон эмзэг өгөгдөл хамгаалах арга хэмжээ авах замаар дижитал арга хэрэгсэл хослуулах;
- Үнэлгээг хүртээмжтэй, хувь хүний хэрэгцээнд дасан зохицсон, тэгш хамарсан, ямарваа нэгэн өрөөсгөл ойлголтоос ангид байхыг баталгаажуулах;
- Бие махбодын болон сэтгэцийн эрүүл мэнд, сайн сайхан байдлыг хөхиүлэн дэмжихүйц сургуулийн тогтолцоог бэхжүүлэх;
- Тогтвортой байдал, уур амьсгалын өөрчлөлтийн тухай заахын тулд суралцах орон зай байдлаар гадаа талбайг ашиглах;
- Дэлхийн иргэншил, тогтвортой хөгжлийг хөхиүлэн дэмждэг боловсролын хөтөлбөрийг санхүүжүүлэх;
- Тогтвортой байдлыг сайжруулах, уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөнд бэлтгэлтэй байхын тулд сургуулийн дэд бүтцэд хөрөнгө оруулах;

## ТА ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРХЭН АШИГЛАЖ БОЛОХ ВЭ?

### Багш...

- Дэлхийн иргэншил эсвэл тогтвортой хөгжлийн талаарх заах
- Багшийг хөгжүүлэх илүү их, улам сайн боломжтой байхыг сайшаан дэмжих
- Өөрийн зааж байгаа хандлагаа өөрөө үнэлэхэд ашиглаж болно.

### Сургуулийн удирдлага...

- Сургуулийн бодлого боловсруулах
- Сургуулийн зөвлөл шинэчлэх талаар дэмжин ажиллах
- Инноваци бүхий сургуулийн санаачилга загварчлахдаа ашиглаж болно.

### Бодлого боловсруулагч...

- Бодлогын баримт бичгийн төсөл, үндэсний хөтөлбөр боловсруулахдаа сэдэл олж авах
- Хөтөлбөр хүргэх явцаа чиглүүлэх, тэргүүлэх ач холбогдлоо тодорхойлох
- Энх тайван, хүний эрхийн боловсрол, тогтвортой хөгжлийн боловсрол, дэлхийн иргэний боловсролын улам өсөн нэмэгдэж байгаа ач холбогдлыг сайшаан дэмжиж болно.

### Суралцагч...

- Сургуулийн хамт олныг хамарсан төсөл боловсруулах
- Өөрийн сургууль, их сургуульд бодлого өөрчлөлт хийхдээ сайшаан дэмжихдээ хэрэглэж болно.

### Эцэг эх...

- Багш, бодлого боловсруулагчтай хийх сургуулийн уулзалтад илүү ихээр оролцох
- Өөрийн тасралтгүй үргэлжлэх боловсролын талаар хувийн сонголт хийхдээ ашиглах
- Өөрийн хүүхдийн боловсрол, түүний цогц хөгжилд анхаарч, хамгийн сайн гэсэн сонголтыг эрэлхийлэхдээ үндэслэж болно.

### Иргэний нийгмийн оролцогч...

- Шинэчлэл хийх хөтөлбөрийн ноён нурууг босгохдоо ашиглах
- Боловсролоо хөгжүүлж, дэмжих чиглэлээр өөрийн үйл ажиллагаагаа загварчлах
- Өөрийн нөлөөллийн материал боловсруулахдаа тулгуурлаж болно.

### Судлаач...

- Дэлхийн иргэний боловсрол, энх тайван, хүний эрхийн боловсрол, тогтвортой хөгжлийн боловсролын талаарх сэдвээр судалгаа, нотолгоо, өгөгдөл боловсруулах
- Олон салбар дамнасан үйл хэргийг сайжруулах зорилготой санаачилга, мөн өөр өөр мэргэжлийн хүрээг хамарсан их сургуулийн хөтөлбөртэй болох
- Мэдлэгийн бүх хүрээ, салбарыг эрэн таних академик эрх чөлөөгөө бэхжүүлэхэд хэрэглэж болно.

## МӨРӨӨР АЖИЛЛАХ, ХЯНАН ШИНЖЛЭХ НЬ

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагаас дөрвөн жил тутам өөрийн гишүүн Улсуудын зүгээс энэхүү Зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлсэн талаарх тайлангаа илгээсэн мөрөөр дэлхийн хэмжээнд зөвлөлддөг туршлагатай<sup>36</sup>.

Зөвлөмжид тухайлан зааснаар илтгэх үйл явцад иргэний нийгмийн янз бүрийн оролцогчдыг оролцуулах нь их ач холбогдолтойг цохон тэмдэглэсэн байдаг.

Тайлагнах мөчлөгийн хооронд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага улс орнууд, анхааран оролцогч талуудын дунд бодлогын харилцан суралцах үйл ажиллагаа явуулж, түүнчлэн Зөвлөмжийг хэрэгжүүлэх хүсэлтэй талуудад туслах заавар боловсруулж байна.

<sup>36</sup> Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллагын конвенц, зөвлөмжийг хэрэгжүүлж байгааг хянан шинжлэх олон шат бүхий тусгай журмын дагуу ажиллах учир ямар нэгэн дагнасан механизмгүй болно. Журмыг дараах холбоосоор дэлгэрүүлж үзнэ үү: <https://www.unesco.org/en/legal-affairs/cr-committee/monitoring>

## ХАВСРАЛТ 2

# ДЭЛХИЙН ИРГЭНИЙ БОЛОВСРОЛЫН ЦАГААН ТОЛГОЙ

### Цагаан толгой (ABCs<sup>37</sup>)

#### Асуулт 1. Өнөөгийн дэлхий ертөнц ба дэлхийн иргэншил хоорондын нийц юу вэ?

Мэдээлэл, харилцаа холбооны технологийн (МХХТ) хосгүй дэвшил хүмүүст дэлхий даяар хэзээ ч, хаана ч бусад хүмүүстэй холбогдож, харилцах боломж олгосон юм. Энэ нь хүмүүс тухайн газар нутгийн хүрээ хязгаараас даван амьдарч буй бөгөөд хоорондоо холбоотой гэдэг төсөөлөл, бодит байдалд эрчимтэй хувь нэмрээ оруулсаар байна. Түүнээс гадна, үндэстэн дамнасан хүн амын шилжилт хөдөлгөөн өсөн нэмэгдсэн нь тухайн орон нутгийг илүү холимог бүрэлдэхүүнтэй болгож, хэрхэн хамтран амьдрах вэ гэдэгт суралцах хэрэгцээг нэмэгдүүлж байна. Мөн хүн амын дундах хурцадмал байдал, зөрчил мөргөлдөөний шалтгаан бөгөөд үр урхаг үндэсний хил хязгаараас даван гарч буй болон уур амьсгалын өөрчлөлт зэрэг тогтвортой хөгжилд тулгамдаж буй бэрхшээлүүд нь дэлхий нийтийн болон орон нутгийн аль аль түвшинд хамтын ажиллагаа, хамтарсан үйлдэлд уриалж байна.

#### А2. Дэлхийн иргэний боловсролыг сонирхох явдлыг юу өдөөсөн бэ?

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын 2012 онд эхлүүлсэн “Боловсролыг Нэгдүгээрт” Санаачлага (БНС) нь боловсролын хүртээмж ба чанарын зэрэгцээ дэлхийн иргэний боловсролыг гурван тэргүүлэх чиглэлийн нэгт багтаасан. БНС-ыг гаргаснаар боловсрол нь хувь хүний болон үндэстний хүсэл эрмэлзлэлийг биелүүлээд зогсохгүй нийт хүн төрөлхтөн болон дэлхийн нийтийн сайн сайхныг баталгаажуулахад хувь нэмрээ оруулах шинэ эрин үед боловсролын салбарынхан дэвшин орсон. 2015 онд улс орнуудын хөхиүлэн дэмжиж, шийдэхэд анхаарах ёстой Тогтвортой хөгжлийн зорилгуудын нэг болох Боловсролын 4.7 дугаар зорилтын хамрах сэдвийн хүрээнд дэлхийн иргэний боловсролыг багтаасан байна. Эдгээр хоёр дэвшил нь энэхүү сэдэвт агуулгад бодлогын түвшинд анхаарал хандуулах дохиог дэлхийн хамтын нийгэмлэгт өгсөн.

#### А3. Дэлхийн иргэний боловсролыг дэмжих чиглэлээр боловсролын салбарт ямар нэгэн шилжилт эсвэл чиг хандлага ажиглагдаж байна уу?

Боловсролын салбарынхны хүрээнд өрнөдөг боловсролын хүртээмж, чанарын тухай үзэл онолын маргаан хэлэлцүүлэг боловсролын агуулгаар баяжигдаж; танин мэдэхүйн ур чадварын тухай хэлэлцүүлэг нийгэм-сэтгэл санааны ур чадвараар баяжигдан; хөдөлмөрийн зах зээлд шаардлагатай болон ажил эрхлэх ур чадвар, цогц чадамжийн тухай яриа хамтран амьдарч сурах ур чадвар, цогц чадамжийн тухай болон өргөжиж; мөн үнэлгээнд үнэлгээнд суурилсан боловсролын үзэл санаа боловсролын нийцийн тухай болж өргөжин тэлэх хандлага ажиглагдаж байна. Хүртээмжийн тухай асуудлыг одоо чанар, агуулгын асуудлаар баяжуулж байна. Хэрвээ сурагч одоо сургуульд сурч байгаа бол тэд юу сурч байгааг,

37 Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллага (ЮНЕСКО)

тэдний сурч байгаа зүйл нь хүн төрөлхтний хувьд газар дэлхийг амьдрахад илүү сайн сайхан газар болгоход хувь нэмэр оруулах эсэхийг Дэлхийн хамтын нийгэмлэг биднээс асууж байна.

## **ДЭЛХИЙН ИРГЭНИЙ БОЛОВСРОЛ ГЭЖ ЮУ ВЭ?**

### **A4. Дэлхийн иргэн гэж хэн болох талаар дэлхийн нийтэд хүлээн зөвшөөрсөн нэг тодорхойлолт бий юу?**

Иргэншлийн тодорхойлолтыг хэлэлцсэн боловч дэлхийн иргэншлийн талаар нийтээр хүлээн зөвшөөрсөн тодорхойлолт байхгүй байна. Бүх тохиолдолд, дэлхийн иргэншил нь эрх зүйн статусын тухай ойлголтыг дагуулахгүй. Энэ нь дэлхийн хүн төрөлхтний бүлд харъяалагддаг гэсэн мэдрэмж, хүн төрөл(х)тний нэг хэсэг гэсэн ухамсар, эв нэгдэл, хамтын амин чанар (айдентити) бүхий, дэлхийн нийтийн түвшинд хамтарсан хариуцлага хүлээсэн гишүүд гэж төсөөлөгдөж байгаа хүмүүс гэж ойлгож болно. Дэлхийн иргэншлийг албан ёсны гишүүнчлэл гэхээсээ илүү үзэл санаа эсвэл зүйрлэл гэж үзэж болно. Хамтын үйл ажиллагаа явуулах хүрээний хувьд дэлхийн иргэншил нь илүү сайн сайхан ирээдүйг ба дэлхий ертөнцийг цогцлоохын төлөөх иргэний үйлдлээр дамжуулан гишүүдийнхээ дунд болон тэдний төлөө үйл ажиллагаа зохион байгуулах, оролцох, хоорондоо харилцах байдлыг нэмэгдүүлнэ гэсэн хүлээлттэй байдаг.

### **A5. Дэлхийн иргэний боловсролын зорилго юу вэ?**

Дэлхийн иргэний боловсролын зорилго нь суралцагчдыг дэлхийн нийтийн тулгамдсан асуудалтай нүүр тулж шийдвэрлэхийн тулд орон нутагтаа болон дэлхий дахинд аль аль түвшинд идэвхтэй үүрэг хүлээж оролцох, эцсийн дүнд илүү шударга, амар тайван, хүлцэл тэвчилтэй, тэгш хамруулсан, аюулгүй бөгөөд тогтвортой дэлхийд идэвх санаачлагатай хувь нэмэр оруулагч болгон чадавхжуулах явдал юм. Дэлхийн иргэний боловсрол нь үзэл баримтлалын хувьд гурван хэмжээстэй юм. Танин мэдэхүйн хэмжээс нь суралцагчдын мэдлэг, ойлголт, шүмжлэлт сэтгэлгээ эзэмшихтэй хамааралтай. Нийгэм-сэтгэл санааны хэмжээс нь нийтлэг хүн төрөлхтөнд харъяалагдах мэдрэмж болон суралцагчдын нинжин сэтгэл, эв нэгдэл, ялгаатай болон олон янзат байдлыг хүндэтгэх, үнэт зүйлс, хариуцлага хуваалцахтай холбоотой. Зан үйлийн цар хүрээ нь суралцагчид илүү амар амгалан, тогтвортой дэлхийн төлөө орон нутгийн, үндэсний, дэлхийн нийтийн түвшинд хариуцлагатай үйлдэл хийх хүлээлттэй байдаг.

### **A6. Дэлхийн иргэний боловсрол болон иргэний боловсрол хоёр ямар уялдаа холбоотой вэ?**

Улс орнууд иргэний боловсролдоо дэлхийн иргэний боловсролын гол үнэт зүйлсийг тусгах нь нэмэгдэж байна. Энэ нь зарим талаар тухайн орон нутагт амьдарч байгаа хүн ам улам бүр холимог бүрэлдэхүүнтэй болж байгаа учраас суралцагчид иргэний боловсролынхоо нэг хэсэг болгон соёл, үндэстний хувьд өөр хүмүүстэй хэрхэн хамт амьдрахад суралцах өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээтэй холбоотой бодит байдал юм. Энэ нь зүй ёсны хандлага бөгөөд үүнийг иргэний боловсрол эсвэл дэлхийн иргэний боловсрол гэж нэрлэх ёстой эсэх талаар маргалдах шаардлагагүй юм. Иргэний боловсрол нь дэлхийн иргэний боловсролын буух хамгийн нийтлэг хөрс юм. Энх тайвны боловсрол, тогтвортой хөгжлийн төлөө боловсрол, эсвэл олон улсын ойлголцлын төлөөх боловсрол нь дэлхийн иргэний боловсролын мөн чанарт нийцэж байгаа учир тэдэнд мөн адил хандах ёстой. Нэр өгөх асуудалд бус хөхиүлэн дэмжиж байгаа гол үнэт зүйлс, үзэл санаанд анхаарлаа төвлөрүүлэх ёстой. Боловсролыг эзэмшүүлэх арга зам, бүтцийн асуудлуудын зэрэгцээ нэр томьёо нь өөр өөр байж болно.

## **A7. Дэлхийн иргэний боловсролд энх тайвны боловсрол, тогтвортой хөгжлийн боловсрол, эсвэл олон улсын ойлголцлын төлөө боловсролоос өөрөөр хандах ёстой юу?**

Эдгээр сэдвүүдэд хооронд нь сөргүүлэн тавих бие даасан хүрээнүүд гэж хандаж болохгүй. Дэлхийн иргэний боловсрол нь ялгаварлан гадуурхахгүй байх, нийгмийн ялгаатай ба олон янзат байдлыг хүндэтгэх, хүн төрөлхтний эв нэгдэлтэй байх зэрэг үнэт зүйлсийг дэмждэг боловсрол юм. Энэ нь энх тайвны боловсрол, олон улсын ойлголцлын төлөө боловсролоос үзэл баримтлалын хувьд зөрүүгүй. Дэлхийн иргэний боловсрол, тогтвортой хөгжлийн төлөө боловсрол хоёулаа хувирган өөрчлөх болон нэгдмэл сургах зүйг дэмждэг. Аль аль нь дэлхий нийтийн тулгамдсан асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэхэд шаардлагатай үйл ажиллагаанд санаа тавьдаг, харин тэдний сэдэвчилсэн агуулга нь онцлог ялгаатай байх хандлагатай - дэлхийн иргэний боловсрол нь энх тайван, зөрчил мөргөлдөөнтэй холбоотой дэлхий нийтийн тулгамдсан асуудлуудыг хамаардаг, тогтвортой хөгжлийн төлөө боловсрол нь байгаль орчны асуудлууд, байгалийн нөөцтэй холбоотой дэлхий нийтийн тулгамдсан асуудлуудыг хамаардаг. Дэлхийн иргэний боловсрол болон боловсролын бусад хандлагууд нь хоорондоо уялдаа холбоотой зорилго зорилтуудад чиглэсэн байхад тэдгээрийг өөд өөдөөс нь сөргөлдүүлэх нь бүтээлч бус, ашиг ч үгүй юм.

## **A8. Дэлхийн иргэний боловсрол нь хүчирхийлэлд уриалсан хэт туйлширсан үзлээс урьдчилан сэргийлэх боловсролтой ямар холбоотой вэ?**

Дэлхийн иргэний боловсролыг хүчирхийлэлд уриалсан хэт туйлширсан үзлээс урьдчилан сэргийлэхэд ашигтай арга хэрэгслийн нэг гэж сурталчилдаг. Тодорхойлолтоор бол, хүчирхийлэлд уриалсан хэт туйлширсан үзэл нь нийгмийн олон янзат байдал эсвэл үзэл бодлын ялгааг тэвчдэггүй. Эсрэгээр, дэлхийн иргэншил, дэлхийн иргэний боловсролын суурь зарчмуудын нэг нь олон янзат байдлыг хүндэтгэх юм. Дахин хэлэхэд, тодорхойлолтоор, хүчирхийлэлд уриалсан хэт туйлширсан үзэл нь экстремист үзэл суртлын сэдэлтэй зорилгодоо хүрэхийн тулд хүчирхийллийн аргыг хэрэглэхэд хүргэдэг, харин дэлхийн иргэншил, дэлхийн иргэний боловсрол хүчирхийллийн бус, нинжин сэтгэл, хүн төрөлхтний төлөө эв нэгдлийн зарчим дээр суурилдаг. Дэлхийн иргэншил нь хүчирхийлэлд уриалсан хэт туйлширсан үзлээс сэргийлэх вакцин болдог. Хэрвээ хүчирхийлэлд уриалсан хэт туйлширсан үзэл нь өвчин гэж үзвэл дэлхийн иргэншил нь эмчилгээ нь юм.

## **ДЭЛХИЙН ИРГЭНИЙ БОЛОВСРОЛЫГ ОЛГОХ НЬ**

### **A9. Дэлхийн иргэний боловсролыг боловсролын аль түвшинд олгох вэ?**

Дэлхийн иргэний боловсрол нь даян дэлхийн харилцаа, тулгамдсан асуудалтай холбоотойг харгалзан бага боловсролын дараагийн түвшний “нас бие гүйцсэн” сурагчдад зориулсан боловсрол гэж хүмүүс ихэвчлэн боддог. Гэтэл тийм биш юм. Дэлхийн иргэний боловсролын гурван хэмжээс дотроос хандахад хамгийн их бэрхшээлтэй нь хандлага, үнэт зүйлсийг төлөвшүүлэхэд чиглэсэн нийгэм-сэтгэл санааны хэмжээс юм. Мэдээлэл, мэдлэгийг анги танхимд олж авч болох боловч үнэт зүйлс, итгэл үнэмшлийн тогтолцоо, хандлагыг туршлага хуримтлуулах, нийгэмшүүлэх үйл явцаар дамжуулан төлөвшүүлдэг. Тэдгээрийг сургалтаар бус суралцагчдын хөгжлийн үйл явцаар дамжуулан олж авдаг. Ийм учраас, бага нас нь суралцагчид дэлхийн иргэншлийн зөв сэтгэлгээг олж авдаг дэлхийн иргэний боловсролыг эхлүүлэх хамгийн зөв үе юм.

### **A10. Бид дэлхийн иргэний боловсролыг бие даасан хичээл болгох шаардлагатай юу?**

Дэлхийн иргэний боловсролыг бие даасан хичээл байна гэж ойлгож болохгүй юм. Энэ нь дэлхийн иргэншлийн гол үнэт зүйлс, тухайлбал үл ялгаварлан гадуурхах, ялгаатай байдлыг хүндэтгэх, хүн

төрөлхтний эв нэгдэлтэй байхыг дэмждэг боловсрол юм; тиймээс, түүнийг хэрэгжүүлэх арга замууд нь өөр, өөр байж болно. Дэлхийн иргэний боловсролыг одоо орж байгаа хичээлүүдэд интеграцчилан оруулж болохын зэрэгцээ хэрэв хүсвэл бие даасан хичээл болгон оруулж болно. Иргэний эрхийн үндэс, иргэний боловсрол, нийгмийн ухааны хичээлүүд болон энх тайвны боловсрол болон хүний эрх, ардчилал, шударга ёс, олон улсын ойлголцлын тухай сэдвүүд ордог бусад хичээлүүдтэй интеграцчилж болно. Ямар арга замаар заах нь гол асуудал биш бөгөөд дэлхийн иргэний боловсролыг үр дүнтэй олгохын тулд дэлхийн иргэний боловсролын гол үнэт зүйлс нь боловсролын бодлого, сургалтын хөтөлбөрт тусгагдаж, дэмжигдсэн байх ёстой.

### **A11. Дэлхийн иргэний боловсролыг олгох хамгийн үр дүнтэй сургах зүй юу вэ?**

Дэлхийн иргэний боловсролын танин мэдэхүйн хэмжээсийг уламжлалт танхимын сургалтыг суралцагчдын мэдээллийн бусад эх үүсвэрт хүртэж, дүн шинжилгээ хийхтэй хослуулан хангаж болно. Гэвч, нийгэм-сэтгэл санааны хэмжээсийг хангахын тулд сургах зүй нь нэгдмэл (holistic) байх ёстой. Мэдээлэл, мэдлэгийг дадлагатай хослуулах ёстой. Суралцагчдыг өөрийн үзэл бодол, үнэт зүйлс, хандлагаа бүрдүүлэх, шалгах, төлөвшүүлэх болон хариуцлагатай үйлдэл хийхэд суралцах боломж, бодитоор турших нөхцөлөөр хангах нь зүйтэй. Орон нутгийн түвшинд үйл ажиллагаанд оролцох, ялгаатай эсвэл өөр өөр үзэл бодолтой хүн амтай харилцах боломж байх шаардлагатай. Гол үнэт зүйлсийг суралцагчдын өдөр тутмын амьдралд, сургуулийн орчинд хэрэгжүүлж дадлагажуулах ёстой.

### **A12. Дэлхийн иргэний боловсролын талаар багш нарт зориулсан тусгай хөтөлбөр байх ёстой юу?**

Дэлхийн иргэний боловсролыг өмнө заагдаж байгаа бусад холбогдох сэдвүүдтэй нэгтгэж болно гэсэнтэй ижил утгаар дэлхийн иргэний боловсролын талаарх багшийн боловсрол, сургалтыг бусад холбогдох агуулгуудтай нэгтгэж болохын зэрэгцээ бие даасан хичээл, сургалт болгон оруулж болно. Хэдийгээр тусгай сургалтын хөтөлбөр гаргах шаардлагагүй байж болох ч дэлхийн иргэний боловсрол нь хувирган өөрчлөх сургах зүйг шаарддаг. Энэ нь суралцагчид бодит амьдралын асуудлуудад шүүмжлэлтэйгээр дүн шинжилгээ хийх, боломжит шийдлүүдийг бүтээлчээр, шинэлэг байдлаар тодорхойлохыг хөхиүлэн дэмждэг; гол зонхилох үзэл онолууд, ертөнцийг үзэх үзэл, эрх мэдлийн харилцааг шүүмжлэлтэйгээр эргэн харах, тогтолцооны хувьд хангалтгүй төлөөлөлтэй байдаг эсвэл гадуурхагдсан хүмүүс/бүлгүүдийг авч үзэхэд дэмжлэг үзүүлдэг; хүссэн өөрчлөлтөө хийх ажиллагаанд оролцоход анхаарал төвлөрүүлдэг гэсэн үг. Иймээс, бие даасан эсвэл интеграцчилсан сургалтын хөтөлбөрөөр дамжуулан багш нар, сургалтын менежерүүдэд энэхүү сурган хүмүүжүүлэх өвөрмөц чиг хандлагад суралцах боломж олгох нь зүйтэй.

### **A13. Бидэнд дэлхийн иргэний боловсролын сургалтын хөтөлбөрийн нийтлэг хүрээ хэрэгтэй юу?**

Дэлхийн иргэний боловсролын зарчмуудыг одоо орж байгаа хичээлүүдтэй нэгтгэн олгож болно. Энэ нь шинэ, тусгай сургалтын хөтөлбөрийн хүрээг шаардахгүй. Мөн сургалтын хөтөлбөр боловсруулах нь гадны нөлөөгөөр хийгддэг ажил биш бөгөөд тухайн улс үндэстний эрхийн асуудал юм. Дэлхийн иргэний боловсролын талаарх олон янзын үзэл бодол байгаа тул дэлхийн иргэний боловсролын сургалтын хөтөлбөрийн дэлхийн нийтээр зөвшөөрсөн хүрээ байх нь эргэлзээтэй юм. Гэвч, дэлхийн иргэний боловсрол нь сургалтын хөтөлбөр боловсруулдаг мэргэжилтнүүд, шинжээчид, боловсролын удирдах ажилтнууд, боловсролын ажилтнуудын хувьд харьцангуй шинэ нэр томъёо тул тэдэнд сургах зүйн зарим нэг удирдамж өгөх шаардлагатай байна. Энэ үүднээс, ЮНЕСКО дэлхийн иргэний боловсролын багшлахуйн болон суралцахуйн ерөнхий зорилтуудын удирдамжийн баримт бичиг боловсруулсан ба тэдгээр зорилтуудад хүрэх онцлог арга замыг тухайн гишүүн орны сонголтод үлдээсэн. Мөн бусад орнуудын сайн туршлагаас суралцах боломж нь улс орнуудад ашигтай юм.

#### **A14. Бид дэлхийн иргэний боловсролын сурагчдад үзүүлж байгаа нөлөөг хэрхэн үнэлж чадах вэ?**

Танин мэдэхүйн нөлөөг сурагчид мэдээлэл, мэдлэгийн тодорхой багцыг эзэмшсэнийг шалгалтаар дамжуулан үнэлэх нь харцангуй хялбар байх болно. Нийгэм-сэтгэл санааны болон зан үйлийн ур чадвар, цогц чадамжийн эзэмшилтийг үнэлэх нь сурагчдын хөгжил, тодорхой хандлагын төлөвшилтийн зэрэгцээ хувь хүний хөгжлийн нэг хэсэг болсон тэдний сэтгэлгээ, зан үйлийн хэв маягийг хэмжих нь өөр арга барилыг шаардаж болзошгүй. Үүнд хүрэхийн тулд даалгавар, үзүүлбэр, ажиглалт, төсөл болон бусад гүйцэтгэх даалгаврууд өгөх зэрэг оролцоот үнэлгээний аргууд үр дүнтэй байж болно. Ялангуяа, дэлхийн иргэний боловсролын нөлөөний үнэлгээний гол анхаарал нь гарах үр дүнд биш сурах үйл явц дээр төвлөрсөн байх ёстой. Энэ үүднээс, эцсийн үнэлгээнээс илүү явцын үнэлгээг илүүд үзнэ.

#### **A15. Дэлхийн иргэний боловсрол нь зөвхөн дэлхий нийтийн тулгамдсан асуудлууд, арга хэмжээнүүдийн тухай юм уу?**

Дэлхийн иргэний боловсролын суурь үзэл санаа нь хамтдаа амьдарч сурах явдал юм. Энэ нь ялгаатай байдал болон хүн төрөлхтний төлөө эв нэгдлийг хүндэтгэхийг хөхиүлэн дэмждэг. Энэхүү дадал дэлхийн, мөн түүнчлэн орон нутгийн хэмжээнд суралцаж болно. Сурагчдад өөр орны соёлын тухай заахын зэрэгцээ орон нутагт нь оршин суугаа цагаач/шилжин суурьшсан хүүхдүүдэд хүндэтгэлтэй, эрхэм чанарт нь халдахгүй хандахыг заах нь дэлхийн иргэний боловсролын хувьд үнэ цэнэтэй байх болно. Ялгаварлан гадуурхахгүй байх, хүчирхийлэл үйлдэхгүй байх зэрэг суурь үнэт зүйлсийн тухай сурах боломж олгох нь дэлхийн иргэний боловсролыг эхлүүлэх сайн цэг юм. Хүн төрөлхтөнд бүхэлд нь санаа тавьж, эв нэгдэлтэй байж, танихгүй хүнд тусламж үзүүлэх зэрэг нь таньдаг хүндээ тусалж, түүнтэй эв нэгдэлтэй байхаас эхэлнэ. Орон нутагт тулгамдсан асуудлууд, авах арга хэмжээ нь дэлхийн иргэний боловсролд багтах чухал сэдвүүд байдаг.

#### **A16. Дэлхийн иргэний боловсрол нь дэлхий нийтэд хэрэгтэй юм уу, эсвэл улам бүр даяарчлагдаж буй ертөнцөд амьдрах хувь хүнд хэрэгцээтэй юм уу?**

Энэ асуулт нь даян дэлхийн эв нэгдэл ба хувь хүний эсвэл үндэстний өрсөлдөх чадварыг нэгэн зэрэг хөхиүлэн дэмжих бэрхшээлтэй байдгийг харуулдаг. Даян дэлхийн эв нэгдэл нь дэлхийн иргэний боловсрол дэлхийд ямар хувь нэмэр оруулж болохыг тодотгож байхад нөгөөдөх нь дэлхийн иргэний боловсрол хувь суралцагчийн төлөө юу хийж чадах, “21-р зууны ур чадвар”-ыг эзэмших боломж олгоход анхаарлаа төвлөрүүлж байна. Энэхүү 2 эцсийн үр дүнг тасралтгүй үргэлжлэх шугаман дээр тавьж харвал сөргөлдөөнт байдал шийдвэрлэгдэнэ. Эхлэлийн цэг нь суралцагчдын өрсөлдөх чадвараа дээшлүүлэх хувийн сонирхол байж болох боловч цаашид тэднийг өөр чиглэлд хандуулж, хувийн болон орон нутгийн бодит байдлаас нь хөндийрүүлж, тэдний бодит байдал бусдын бодит байдалтай хэрхэн холбогдож байгааг олж харахад чиглүүлэх ёстой. Тэд тус тусын бодит байдлын харилцан нөлөөллийг олж хараад, эцсийн эцэст, харилцан хамтран ажиллаж, эв нэгдэлтэй байх зайлшгүй шаардлагыг авч үзэх чадавхтай болж эрхмэдэлжсэн байна. Хоёр сонирхлын хоорондын ялгаанд бус харилцан үйлчлэлд онцлон анхаарал хандуулсан байхад өрсөлдөөнт байдал намжина.

#### **A17. Орон нутгийн эсвэл үндэсний амин чанар (айдентити) нь хүчтэй эсвэл гадуурхсан эсвэл бүр бусад амин чанарт дайсагнасан байдалтай нийгэмд дэлхийн иргэний боловсролыг хэрхэн нэвтрүүлж болох вэ?**

Дэлхийн иргэний боловсролд тус дэм болж буй нэг нөхцөл нь нийтлэг үнэт зүйлс, ялгаатай байдал, олон ургальч зарчмуудад нээлттэй улс төр, нийгэм, соёл эсвэл шашны уур амьсгал юм. Хэрвээ үндэсний/орон нутгийн нөхцөл байдал ээлтэй бус бол дэлхийн иргэний боловсролын нөлөө хязгаарлагдмал байх нь гарцаагүй бөгөөд онцгой тохиолдолд эхлүүлэх ч боломжгүй болно. Дэлхийн иргэний боловсролын

гол үнэт зүйлсэд хандах ямар нэгэн түвшний нээлттэй байдал байгаа тохиолдолд орон нутгийн бие биенээ танихгүй иргэдийн дундах эв нэгдлийн үзэл санаанаас эхлэх нь дэлхийн иргэний боловсролыг түгээхэд тустай байх болно. Хүн төрөлхтний хувьд эв нэгдлийн үндэс нь бие биенээ танихгүй, хэзээ ч танилцахгүй хүмүүсийн дундах нинжин сэтгэл болон хайр энэрэл юм. Энэ хандлага нь орон нутгийн хил хязгаарын гаднах хүмүүсийг танин мэдэх асуудлыг сөхөх магадлал багатай хэдий ч, суралцагчдад дэлхийн иргэний боловсролын суурь зарчмын нэг болох хүн төрөлхтөнтэй эв нэгдэлтэй байхыг мэдэрч, дадлага хийх боломж олгоно.

## **ДЭЛХИЙН ИРГЭНИЙ БОЛОВСРОЛ БА ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГУУД**

**А18. Тогтвортой Хөгжлийн Зорилгуудын (Боловсролын талаарх ТХЗ 4) 4.7-р Зорилтод Дэлхийн иргэний боловсролыг дурьдсан байгаа. Мөн цаашилбал, тогтвортой хөгжлийн төлөөх боловсрол, тогтвортой амьдралын хэв маяг, хүний эрх, жендэрийн эрх тэгш байдал, энх тайванч ба хүчирхийллийн бус соёлыг дэмжих, дэлхийн иргэний, соёлын олон янзат байдал, тогтвортой хөгжилд оруулах соёлын хувь нэмэр зэрэг бусад сэдвүүдийг хамарсан байдаг. Энэ нөхцөлд дэлхийн иргэний боловсролыг хэрхэн хэрэгжүүлэх ёстой вэ?**

БНСУ-ын Инчон хотод 2015 онд зохион байгуулагдсан Дэлхийн Боловсролын Чуулганы “Боловсрол 2030: Инчоны Тунхаглал ба Үйл ажиллагааны хүрээ” үр дүнгийн баримт бичиг нь улс орнуудын боловсролын тогтолцоонд, тухайлбал, сургалтын хөтөлбөр, багшийн боловсрол, үнэлгээнд эдгээр сэдвүүдийг тусгахыг дэмжсэн. Гэхдээ энэ зорилтод хүрэхэд баримтлах хандлага, арга зам улс орон бүрт өөр байх хандлагыг зөвтгөн тодорхой заагаагүй болно. Энэ нь мөн онцгойлох сэдвүүдийн сонголтонд хамаарах юм. Бүх сэдвүүдэд хандах эх үүсвэрүүд хангалтгүй байхад ач холбогдлоор нь эрэмбэлэх нь хэвийн зүйл юм. Энэхүү үйл явцад хэрвээ тэргүүлэх ач холбогдол өгсөн бол дэлхийн иргэний боловсролыг хүний эрх, энх тайвны соёл, үл хүчирхийлэх, соёлын олон янз байдал зэрэг бусад асуудлыг шийдвэрлэх эхлэлийн цэг гэж үзэж болно. Үүний зэрэгцээ, тогтвортой хөгжлийн төлөө боловсрол нь тогтвортой амьдралын хэв маяг, дэлхийн иргэн, хүний эрх, тогтвортой хөгжилд оруулах соёлын хувь нэмэрт холбоотой асуудлуудын эхлэлийн үр дүнтэй цэг болж болох юм.

**А19. Дэлхийн иргэний боловсролын ахиц дэвшлийг хэмжих дэлхийн нийтийн үзүүлэлт байна уу?**

Дэлхий нийтийн ганц албан ёсны шалгуур үзүүлэлт байдаг нь: “(а) үндэсний боловсролын бодлогод (б) сургалтын хөтөлбөрт (в) багшийн боловсролд (г) сурагчдын үнэлгээнд (и) дэлхийн иргэний боловсрол ба (ii) жендерийн эрх тэгш байдал ба хүний эрхийн боловсролыг хамарсан тогтвортой хөгжлийн төлөө боловсрол нь зонхилох чиг хандлага болсон хэр хэмжээ” юм. Энэ үзүүлэлтийн дэлхий дахины мэдээг ЮНЕСКО 1974 оны Олон улсын Ойлголцол, Хамтын ажиллагаа, Энх тайвны төлөөх Боловсрол болон Хүний эрх, Үндсэн Эрх чөлөөтэй холбоотой Боловсролын тухай Зөвлөмжид зориулан боловсруулсан асуулга судалгааны дагуу цуглуулдаг. Судалгаа нь дэлхийн иргэний боловсролын зэрэгцээ тогтвортой хөгжлийн төлөө боловсролын гол үзэл баримтлалыг хамардаг. Мэдээллийг дөрвөн жил тутам цуглуулдаг.

**А20. 4.7 Зорилтыг хэмжих дэлхий дахины ганц шалгуур үзүүлэлт нь зорилтонд туссан бүх чиглэлээр гарах ахиц дэвшлийг багтаан үнэлж чадах уу?**

Дэлхий дахины шалгуур үзүүлэлт Зорилтод заасан бүх сэдвийн хүрээний ахиц дэвшлийг хянан шинжилдэггүй. Дэлхийн иргэний боловсрол болон тогтвортой хөгжлийн төлөө боловсролын хувьд ч тэдгээрийн бүх нарийн төвөгтэй хэмжээсийг үнэлж хэмжиж чадахгүй байна. 4.7 Зорилтын хувьд

ЮНЕСКО-гийн бодлого дараах байдалтай байна: Дэлхийн олон нийтэд хэдийгээр хязгаартай боловч ахиц дэвшлийг хянан шинжлэх тодорхой түвшин байгааг баталгаажуулах боломж олгохын тулд Гишүүн орнуудын баталсан дэлхий дахины шалгуур үзүүлэлтийн мэдээллийг 1974 оны Зөвлөмжийн судалгааны хэрэгслээр цуглуулна. Дэлхийн иргэний боловсрол болон тогтвортой хөгжлийн төлөө боловсролын онцлог талууд болон Зорилтод орсон бусад чиглэлүүдийг дэлхий дахинд хянан шинжлэхийн тулд ЮНЕСКО бусад боломжтой богино хугацааны судалгаа, асуулгын үр дүнг цуглуулж, дүн шинжилгээ хийж түгээнэ. Эдгээр нь хэмжээгээрээ дэлхий нийтийн биш байж болох боловч Зорилтыг хэрхэн хэрэгжүүлж байгааг нэмж тодруулах боломжтой.



## “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн

### ТУНХАГ

Боловсрол нь хүн бүрийн өдөр тутмын амьдралд, насан турш нөлөөлөх үндсэн эрх, хүний хөгжлийн түлхүүр бөгөөд иргэн бүрт чанартай боловсрол олгох нь төрийн хүлээх гол үүрэг хариуцлага гэдэгт итгэн;

Өнөөгийн тогтолцоонд боловсролыг явцуу тодорхойлдог, хүн бүрийн ялгаатай байдлыг харгалздаггүй, ялгаварлан гадуурхдаг, хангалттай санхүүжилт олгодоггүй зэргээс шалтгаалан бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх үйл явцад цогц хандлага дутагдаж; боловсролын тогтолцооны үр өгөөж нь хувь хүний хүсэл тэмүүлэл, нийгмийн эрэлт хэрэгцээнээс асар зөрүүтэй байсаар ирсний улмаас үнэ цэнэтэй амьдарч, амьдралын чанараа дээшлүүлэх боломж олгохгүй байгаад сэтгэл зовнин;

Энэ нь эрх мэдлийн шударга бус бүтцийг бий болгож, тэгш бус байдлыг хадгалж үлдэх арга зам болж байгааг эсэргүүцэн;

Боловсролын чанар, хүртээмж, хариуцлагатай байдлын төлөө хүчээ нэгтгэн ажиллаж, энэ үйл явцад хувь хүн, иргэний нийгмийн байгууллага, бүлгүүдийг өргөнөөр татан оролцуулж, өргөн суурьтай, зохион байгуулалттай, хүчтэй хөдөлгөөн бий болгохыг чухалчлан;

Энэ үйл явцад нийгмийн бүх бүлэг, ялангуяа эрх мэдлийн цөөнхийн оролцоог хангахыг онцлон;

Иргэд, бүлгүүдийн мэдлэг, чадварыг хөгжүүлж, тулгарсан асуудлаа гаргаж ирэх, шийдлийг шаардах, хариуцлага тооцох чадавхтай болоход нь дэмжлэг үзүүлэхийг эрмэлзэн;

Боловсролын тогтолцоог хүний мэдэх, бүтээх, хүний ёсоор хамтран амьдарч, нэр төртэйгээр оршиход суралцахуйц, хувь хүний потенциал, чадвар, чадавхыг нээж, эерэг зан үйл, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн, хүмүүнлэг, ардчилсан, хүн бүрийн эрхийг хангасан, тэгш хүртээмжтэй болгон өөрчлөхийг эрхэмлэн;

Хүүхэд, эцэг эх, багш, орон нутгийн бүлгүүд болон үндэсний, хэлний, соёлын, бэлгийн цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, орлого багатай иргэд зэрэг дуу хоолойгоо хүргэж, шийдвэр гаргахад оролцож чадахгүй байгаа бүлгүүдийг эрх мэдэлжүүлэх зорилгоор боловсролын тогтолцоо, бодлогод хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чадавхыг бүрдүүлэх, нөлөөлөх ур чадвараа дээшлүүлэх шаардлагыг ухамсарлан;

Хүний эрх, жендэрийн тэгш эрх, үл ялгаварлан гадуурхах, хүчирхийллээс ангид, хүлээцтэй байх, нээлттэй, ил тод, хариуцлагатай байх зарчмыг баримтлан;

Монгол улсад боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах, төсвийг хянах, хариуцлага шаардах, бодлогод нөлөөлөх үндэсний кампанит ажил зохион байгуулах зорилгоор эвсэн нэгдсэнээ тунхаглаж байна.

2010 оны 9 сарын 3



